ГАМШГИЙН ЭРСДЭЛ СУДЛАЛ

Онцгой байдлын сургуулийн Онол, арга зүйн сэтгүүл

2016 он №2 (8)

АГУУЛГА

Онол, арга зүй

Д.Сэржмядаг
ГАМШГААС ХАМГААЛАХ САЛБАРЫН ЗАРИМ НЭР ТОМЪЁОГ ТОДОТГОХУЙ 5

Х.Сүхбаатар
ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АР ТАЛ ХАНГАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ 11

Б.Машбат
НЕФТЬ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН РЕЗЕРВУАРТ ГАРСАН ГАЛ ТҮЙМРИЙГ УНТРААХ АРГА ЗҮЙ 18

С.Баттөмөр
ХҮНИЙ АМЬСГАЛЫН ЭРХТЭНД ХОРТ ХИЙ УТААНЫ НӨЛӨӨЛӨЛ 25

Эрдэм шинжилгээний өгүүлэл

Х. Мягмаржав, Д. Цэрэндорж, Н. Одмаа
ТАРИАЛАНГИЙН ТӨВИЙН БҮСИЙН ХҮРЭН ХӨРСНИЙ АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГЭЭС 29

Ж.Серикжан
АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ БА АХИЦ ДЭВШИЛ 35

Залуу судлаач

Б.Батмөнх
ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГИЙГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ОЛГОХ СУРГАЛТЫН ОНЦЛОГ 41

Д.Цэцэндалай
ГЭР ХОРООЛОЛД ГАРЧ БУЙ ГАЛ ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ 53

Ц.Очбадрал
ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ 62

Т.Мөнхдорж
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛАХ НЬ 68

Сонсогчийн булан

Г.Уртнасан
ХУР БОРООНЫ УСЫГ АМЬДРАЛД АШИГЛАХ АРГА 79

Мэргэжилтний зөвөлгөө

А.Ариунбилэг
ХУВЦАСНЫ ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ АРГА 87

Мэдээ, мэдээлэл

ОНЦГОЙ БАЙДЛЫН СУРГУУЛИЙН 2016 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 90

ОНЦГОЙ БАЙДЛЫН СУРГУУЛИЙН 2016 ОНЫ ТООН МЭДЭЭ 93

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Мэндчилгээ

Эрхэм уншигч таны энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилье.

Улиран одож буй 2016 он Онцгой байдлын сургуулийн хувьд ололт, амжилтаар арвин жил байлаа.

Сургууль өнгөрч буй оныг сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулж, эдийн засаг, нөөцийн удирдлагын тэнхим, эчнээ анги нээж сургалтын төрөл, хэлбэрээ нэмэгдүүлэх зэргээр сургалтын чанарыг дээшлүүлэх, сурч ажиллахад таатай орчинг бүрдүүлэх чиглэлд бодитой ахиц гарсан түүхэн үйл явдлаар үдэж байна.

Гамшгийн эрсдэл судлал сэтгүүлийн энэ удаагийн дугаарыг шинэ агуулга, шинэ өнгө төрхтэйгээр та бүхэндээ өргөн барьж байна. Сэтгүүлд онцгой байдлын албаны мэргэжил эзэмшихээр суралцаж буй сонсогч оюутнуудад нэн хэрэгтэй гамшгаас хамгаалах үйл ажиллагааны онол, арга зүйн асуудлыг тэргүүн эгнээнд нийтлэхийн зэрэгцээ, мэдээлэл танин мэдэхүйн чиглэлээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаа түүний эргэн тойронд болж буй шинэ мэдээ, мэдээлэл, сонирхолтой баримт, туршлага зэргийг олны хүртээл болгох болно. Мөн гамшгаас хамгаалах чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачдын болон магистрантур, докторантурт суралцагчдын судалгааны үнэ цэнэтэй өгүүллүүдийг бид аль болох нийтлэхийг урьдал болгоно.

Манай сэтгүүлд нийтлэгдсэн эрдэмтэн, судлаачдын өгүүлэл, нийтлэл, мэдээ, мэдээллүүд уншигч Таны сурч мэдэх их хүсэл, мэдлэг оюуны тань санд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэнтэй дараагийн дугаараар дахин уулзахдаа баяртай байх болно.

ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн захирал,

дэд хурандаа У.Ганхөлөг

ГАМШГИЙН ЭРСДЭЛ СУДЛАЛ
ХСИС-ийн Онцгой байдлын сургууль

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч

У.Ганхөлөг
Онцгой байдлын сургуулийн захирал, дэд хурандаа

Зөвлөлийн гишүүд

Х. Сүхбаатар
Гамшгаас хамгаалах албаны тэнхмийн эрхлэгч, дэд хурандаа

Б.Машбат
Гал түймэртэй тэмцэх албаны тэнхмийн эрхлэгч, хурандаа

Х.Мягмаржав
Эдийн засаг, нөөцийн удирдлагын тэнхмийн эрхлэгч, доктор, дэд хурандаа

С.Базаррагчаа
Гал түймэртэй тэмцэх албаны тэнхмийн дэд профессор, доктор, дэд хурандаа

Дугаарыг эрхэлсэн

Д.Сэржмядаг
Гамшгаас хамгаалах албаны тэнхмийн дэд профессор, доктор, дэд хурандаа

ОНОЛ, АРГА ЗҮЙ

ГАМШГААС ХАМГААЛАХ САЛБАРЫН ЗАРИМ НЭР ТОМЪЁОГ ТОДОТГОХУЙ

дэд хурандаа Д.СЭРЖМЯДАГ
ХСИС-ийн ОБС-ийн Гамшгаас хамгаалах албаны
тэнхмийн дэд профессор, доктор (Ph.D)

Аливаа хэлний үгийн санд мэргэжлийн тусгай ухагдахууныг тэмдэглэсэн бүлэг үгс байх бөгөөд тэдгээрийг нэр томъёо хэмээн нэрлэдэг[1].

Монгол Улсад Гамшгаас хамгаалах салбарын нэр томъёо хэрэглэгдээд арав гаруй жил болж байна. Үүнтэй холбоотойгоор энэ салбарт хэрэглэгдэх зарим тулгуур нэр томъёог олон нийт төдийгүй мэргэжлийн хүмүүс, тэрчлэн энэ салбарын эрдэмтэн, судлаачид ч янз бүрээр ойлгож ярьж, бичих нь элбэг. Иймд тухайн салбарын зарим нэр томъёоны утга санааг тодорхойлж тайлбарлах шаардлага урган гарч байна. Ер нь аливаа салбарт нэр томъёо, үг хэллэгийг нэг мөр ойлгож, хэрэглэж хэвших асуудал амин чухал зүйл байдаг.

Аюул ба осол

Нийгэм нь байгалийн болон технологийн гаралтай аливаа эрсдэлийн дунд оршдог. Аюул, осол нь байгалийн болоод технологийн онцгой үзэгдэлтэй хүн төрөлхтөн нүүр тулах буюу нийгмийг хүрээлэн буй эрсдэлүүд бодит биеллээ олох байдлыг илэрхийлдэг.

Англи хэлнээ эдгээр үгийн утга санааг Лонгманы толь бичигт аюул (hazard)-ыг "аюултай байж болох ямар нэг зүйл"[2], осол (accident)-ыг "хэн нэгний санамсаргүй байдлаас үүдэж хэн нэгэн хүн гэмтэх эсвэл ямар нэг эд зүйл эвдрэх нөхцөл"[3] хэмээн тайлбарлан бичсэн байна.

Википедия нэвтэрхий тольд аюул нь амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд заналхийлэх түвшинг илэрхийлэх нөхцөл байдал[4], осол (accident) нь гол төлөв санаачлага болон шаардлага хангах байдал дутагдсантай холбоотойгоор үүсдэг санаандгүй болон төлөвлөөгүй үзэгдэл юмуу нөхцөл байдал[5] хэмээн тайлбарлажээ.

Монгол хэлнээ "аюул"-ыг гамшиг зовлон учруулж болох хор хөнөөл, гай[6], "осол"-ыг анхаарал болгоомжгүйгээс болж гарсан алдаа, эндэл[7] гэж тайлбарлажээ.

Эдгээр тайлбаруудыг нэгтгэн дүгнэвэл аюул нь онцгой үзэгдэл, осол нь хүний анхаарал болгоомжгүй үйлдэлтэй холбоотой үүсдэг гэсэн

---

[1] Пүрэвжав Э., Шинжлэх ухаан технологийн монгол нэр томъёог боловсруулж ирсэн туршлага, Нэр томъёо судлал сэтгүүл

[2] something that may be dangerous

[3] a situation in which someone is injured or something is damaged without anyone intending them to be

[4] A hazard is a situation that poses a level of threat to life, health, property or environment

[5] An accident or mishap is an unforeseen and unplanned event or circumstance, often with lack of intention or necessity.

[6] Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, 2008

[7] Мөн тэнд

ерөнхий нэг нийтлэг шинжээр илэрхийлэгдэхээр байна.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд аюул, ослыг "***аюул***т үзэгдэл" гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг[8], "техникийн холбогдолтой ***осол***" гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хэлнэ[9] гэж тодорхойлжээ.

Хуулийн эдгээр тодорхойлолтууд аюул, ослын нийтлэг шинжийг илэрхийлэхийн зэрэгцээ энэ хүрээнд хамаарах хүчин зүйлүүдийг дэлгэрэнгүй дурдаж өгсөн нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны мөн чанарт тохирсон тодорхойлолт болсон гэж үзэж болохоор байна.

Манай улсад хорь шахам хэлбэрийн аюулт үзэгдэл, осол тохиолддог болон тохиолдож болзошгүй бөгөөд эдгээрийг дараах байдлаар ангилж болно.

1-р хүснэгт. Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолддог болон тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, осол

Гамшгийн ангилал	Гамшгийн төрөл	Гамшгийн нэр
Байгалийн гаралтай	Цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл	Цасан шуурга
		Их цас
		Зуд
		Шороон шуурга
		Үер
		Ой, хээрийн түймэр
		Ган, цөлжилт
		Аянга
	Геологийн гаралтай аюул	Газар хөдлөлт
		Хөрсний гулсалт
	Биологийн гаралтай аюул	Хортон шавьж, хөнөөлт мэрэгч тархах
		Хүний гоц халдварт өвчин
		Мал, амьтны гоц халдварт өвчин
Хүний үйл ажиллагаатай холбоотой	Технологийн гаралтай осол	Үйлдвэрлэлийн осол
		Тээврийн хэрэгслийн осол, сүйрэл
		Цацраг, химийн бодисын алдагдал
		Дэлбэрэлт
		Объектын түймэр
	Нийгмийн гаралтай аюул	Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал
		Террорист халдлага

Онцгой байдал

Онцгой байдал (emergency) гэдгийг Лонгманы толь бичигт "нэн даруй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай таамаглаагүй буюу аюултай нөхцөл байдал"[10], Википедиа нэвтэрхий тольд "нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай гэнэтийн, яаралтай, гол төлөв таамаглаагүй үйл явдал юмуу тохиолдол"[11], "таамаглаагүй үйл явдлын улмаас яаралтай тусламж, дэмжлэг авах

[8] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.3-д

[9] Мөн хуулийн 4.1.4-д

[10] an unexpected and dangerous situation that must be dealt with immediately

[11] a sudden, urgent, usually unexpected occurrence or occasion requiring immediate action.

хэрэгцээ үүсэх нөхцөл"[12] хэмээн тайлбарласан байна.

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд "онцгой байдал" гэдгийг "байгалийн гамшиг, улс төрийн хямрал зэргээс улс орны хэмжээнд юмуу тодорхой бүс нутгийн иргэдийн амар тайван байдал, байгууллагуудын хэвийн ажиллагаа алдагдаж болох нөхцөл байдал"[13] гэж тайлбарлажээ.

Оросын холбооны улсын Байгалийн болон технологийн гаралтай гамшгаас хүн ам, газар нутгийг хамгаалах тухай холбооны хуульд "онцгой байдал" гэдгийг хүний амьдралын хэвийн нөхцөл алдагдах, хүн амь насаа алдах, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, эд хөрөнгөнд хохирол учирч болох эсвэл хохирол учруулсан осол, сүйрэл, байгалийн аюулт үзэгдлийн улмаас тодорхой нэг газар нутагт үүссэн нөхцөл байдлыг хэлнэ[14] гэж тодорхойлсон байна.

Ер нь онцгой байдал гэдэг нэр томъёо яаралтай арга хэмжээ авах шаардлагатай нөхцөл байдал үүсэх гэж буйг болон яаралтай тусламж дэмжлэг авах хэрэгцээ үүссэн байх гэсэн хоорондоо үл ялиг ялгаатай хоёр хэлбэрээр хэрэглэгддэг байна. Тодруулбал, нэгт нийгэмд ноцтой хор хөнөөлтэй нөхцөл байдал үүсэх нь тодорхой болсон тэр үеийг онцгой байдал гэж ойлгох ба энэ утгаараа тодорхой нутаг дэвсгэрт нийтийн аюулгүй байдалд заналхийлсэн нөхцөл үүсэх үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд тогтоож байгаа дэглэмийг онцгой байдал хэмээн ойлгоно. Онцгой байдлын энэ утга Монгол Улсын Онц байдлын тухай хуулийн "онц байдал" гэж "Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг" хэлнэ гэсэн тодорхойлолтоор илэрхийлэгдэж байна.

Хоёрт нийгэмд өчүүхэн хор уршиг учруулсан багахан аюул, осол тохиолдохыг онцгой байдал гэж үзэх ба энэ үед хор уршгийг арилгах арга хэмжээ нь гол төлөв мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор тухайн газар орны нөөц боломжийн хүрээнд шийдвэрлэгддэг байна. Тухайлбал нэг объектод гал гарахад тухайн нутаг дэвсгэрийн харъяалал бүхий гал унтраах анги очиж унтрааж улмаар учирсан хор уршгийг орон нутгийн түвшинд шийдвэрлэх тохиолдлыг онцгой байдал гэж ойлгоно. Онцгой байдлын энэ утга одоогийн Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг илэрхийлж байгаа юм.

[12] "a state, especially of need for help or relief, created by some unexpected event"

[13] Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, 2008

[14] Российская федерация федеральный закон о защите населения и территорий от чрезвычайных ситуаций природного и техногенного характера, 1994

Эдгээр тайлбар, тодорхойлолтод дүн шинжилгээ хийвэл онцгой байдал гэж аливаа аюул, осол болон нийгмийн шалтгаантай хүчирхийллийн нөлөөгөөр нийгэмд хохирол учирсан буюу учруулахуйц нөхцөл байдал үүсэх гэсэн санааг илэрхийлж байна.

Гамшиг

Гамшиг (disaster) гэдгийг Вэбстерийн толь бичигт "их хэмжээний хохирол, гарз, сүйрлийг авчрах гэнэтийн аюултай үзэгдэл"[15], Википедиа тайлбар тольд "байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой аюулын улмаас их хэмжээний хохирол, сүйрэл учрах, хүний амь нас үрэгдэх болон хүрээлэн буй орчинд эрс өөрчлөлт орох нөхцөл үүсэхийг"[16] хэлнэ гэсэн бол Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд гамшиг гэдгийг "ган, зуд, үер ус, өвчин тахал, дайсны хөнөөл зэрэг аюул" хэмээн тайлбарласан байна.

Гамшгийг улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачид өргөн хүрээтэйгээр тал бүрээс нь судалж өөрсдийн үзэл бодлын үүднээс өөр хоорондоо илт зөрүүтэй биш олон янзын тодорхойлолт гаргасан байдаг бөгөөд эдгээр тодорхойлолтыг нэгтгэн дүгнэж үзвэл гамшиг нь аюул, ослоос учирсан хохирол ба түүнд нэрвэгдэгсдийн хор уршгийг арилгахад тухайн нийгмийн чадавхаас хэтэрсэн /тухайн газар орны чадавх хүрэхгүй болсон нөхцөл/ үзэгдэл тохиолдох гэсэн утгаар гол төлөв тодорхойлогдож байна[17].

Харин Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд "***гамшиг***" гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг[18] хэлнэ гэжээ.

Эндээс гамшиг гэдэг нь нэрвэгдсэн нийгмийн тэмцэх хүчин чадавхаас хэтэрсэн хохирол, хор уршиг гэдэг утгаар ихэвчлэн тодорхойлогдсон байна. Тэгвэл чадавх, нөөц боломжоос давсан гэдгийг ямар шалгуур үзүүлэлтээр гаргах нь ихээхэн маргаантай асуудал билээ. Өөрөөр хэлбэл ямар хэмжээний хохирол учирвал гамшиг боллоо гэж үзэх вэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм.

Гамшиг гэдэг мэдээж гамшигт хүргэж буй аюултай үзэгдлийн эрч хүчнээс илүү өртөж буй объектын тухайн гамшигт эмзэг байдлаас хамаарна. Хүний амь нас хохирох тал дээр энэ асуудлыг шийдэхэд ёс суртахууны талаасаа төвөгтэй ч харин эдийн засаг, байгаль орчинд хохирол учруулах тухайд тодорхой хэмжээгээр шийдэх боломжтой.

Дэлхий дахинд тохиолдсон гамшгийн талаарх мэдээ мэдээллийг бүртгэдэг хамгийн нэр хүнд бүхий эх сурвалж болох Белги дэх Лювены их

[15] a sudden calamitous event bringing great damage, loss, or destruction

[16] A disaster is a natural and man-made hazard that has come to fruition, resulting in an event of substantial extent causing significant physical damage or destruction, loss of life, or drastic change to the environment.

[17] Quarantelli, 1984; Perry, 1991; Tierney, Lindell & Perry, 2001

[18] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-д

2-р хүснэгт. Аюул, осол, онцгой байдал, гамшиг хоорондын хамаарал[19]

		Хугацаа/магадлал		
		Үзэгдэл тохиолдох эсэх нь тодорхойгүй	Үзэгдэл нүүрлэж буй	Үзэгдэл тохиолдсон
Нийгмийн чадавхтай харьцуулахад	нийгмийн тэмцэх хүчин чадавхаас хэтрээгүй	Аюул/осол	Онцгой байдал	Онцгой байдал
	нийгмийн тэмцэх хүчин чадавхаас хэтэрсэн	Аюул/осол	Онцгой байдал	Гамшиг

сургуулийн Гамшгийн дэгдэлтийг судлах төв нь дараахь 4 шалгуурын дор хаяж аль нэгийг хангасан тохиолдолд үйл явдлыг гамшиг гэж үздэг байна. Үүнд:

- 10 буюу түүнээс дээш хүн амь насаа алдсан байх
- 100 буюу түүнээс дээш хүн өртсөн байх
- Онцгой байдал зарласан байх
- Олон улсын тусламж дуудсан байх

гэсэн шалгуурыг хангасан тохиолдолд гамшиг болсон гэж үздэг байна.

Харин манай орны хувьд одоогоор ямар тохиолдолд гамшиг гэж үзэх нарийн тогтсон шалгуур үзүүлэлтийг албан ёсны эрх зүйн хэм хэмжээ болгон тодорхойлоогүй байгаа юм. Гамшигт тодорхой шалгуурт үндэслэж цар хүрээ тогтоох нь гамшгаас хамгаалах арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

Аюул, осол, онцгой байдал, гамшиг гэсэн нэр томъёонууд өөр хоорондоо ялгаатай ойлголтууд бөгөөд эдгээрийн харилцан хамаарлыг 2-р хүснэгтээс тодорхой харж болно.

Хүснэгтээс харахад аюул/осол гэсэн нэр томъёог нөхцөл байдал үүсээгүй эсвэл хэзээ үүсэх эсэх нь тодорхойгүй үед, ноцтой аюул/осол нүүрлэж буй болон орон нутгийн чадавхаас хэтрээгүй аюул/осол тохиолдсон үед онцгой байдал харин орон нутгийн чадавхаас хэтэрсэн аюул/осол тохиолдсон үед гамшиг болсон гэж ойлгогдож байна.

Иймд гамшгаас хамгаалах салбарын эдгээр үндсэн нэр томъёоны ялгаануудад анхааралтай хандаж зөв утгаар нь хэрэглэж хэвших нь зүйтэй юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003
- Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, 2008
- Д. Сэржмядаг., Гамшгаас хамгаалах менежментийн зарим нэр томъёог тодотгохуй, Нэр томъёо судлал сэтгүүл №14, 2012

[19] Michael K. Lindell, Carla S. Prater, Ronald W. Perry Fundamentals of Emergency Management, 2006 p.8

- Э. Пүрэвжав., Шинжлэх ухаан технологийн монгол нэр томъёог боловсруулж ирсэн туршлага, Нэр томъёо судлал сэтгүүл, №4
- П.Дамдин Гамшгийн менежмент ба эрх зүйн орчин өгүүлэл Гамшгийн менежмент эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, 2009
- Российская федерация федеральный закон о защите населения и территорий от чрезвычайных ситуаций природного и техногенного характера, 1994
- Michael K. Lindell, Carla S. Prater, Ronald W. Perry, Fundamentals of Emergency Management, 2006

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АР ТАЛ ХАНГАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

дэд хурандаа Х.Сүхбаатар
Гамшгаас хамгаалах албаны тэнхмийн эрхлэгч, докторант,

Онцгой байдлын албаны аврагч нарын гүйцэтгэж буй үүрэг нь иргэдээ гамшиг, ослын аюулаас аврах явдал байдаг билээ. Энэ үүргийг гүйцэтгэхдээ захирагч даргын өгсөн тушаалын дагуу "байлдаанд" гэсэн командаар тархаж аврах ажиллагааг явуулдаг. Өөрөөр хэлбэл цэргийн удирдлага, тогтолцоотой нэгэн адил тухайн тавигдсан үүргийг биелүүлдэг.

Онцгой байдлын байгууллага үүсч хөгжсөн богинохон хугацаанд түүний ар талын хангалтыг зохион байгуулах, төлөвлөх асуудал ч улам бүр өргөжин хөгжсөөр байна.

Онцгой байдал гэж гамшгаас хамгаалах арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг онцгой ажиллагаа явуулж байгаа нөхцлийг хэлнэ[20]гэж тодорхойлсон байна.

Онцгой байдал гэж осол, сүйрэл, байгалийн аюул, гамшигт үзэгдлийн аюулаас болж хүний амь нас, эрүүл мэндэд болон хүрээлэн буй орчинд ихээхэн хохирол учруулж, хүмүүсийн аж төрөх нөхцлийг алдагдуулан эд материалын ихээхэн хохиролд хүргэх хязгаарлагдмал газар нутагт бий болсон нөхцөл байдлыг хэлнэ[21].

Онцгой нөхцөл байдлын үед аврагчдыг зэвсэг, техник, ар талын материал хэрэгслээр хангах, тээвэрлэх, аврах багажаар хангах, өвчтөн шархтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, тэдгээрийг голомтоос татан гаргах зорилгоор бий болгосон хүч хэрэгслийн бүлэглэлийг онцгой байдлын албаны ар тал гэнэ[22] гэж тодорхойлж болно.

Онцгой нөхцөл байдлын ажиллагааны бүх талын хангалт нь аврах ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд захирагч штаб аврагчдыг аврах ажиллагаанд цагт нь зохион байгуулалттай орох аврах ажиллагааг амжилттай явуулах таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн төрөл, тусгай мэргэжлийн дэмжлэгийг болон хангалтын хүч хэрэгслийн нягт ажиллагааг хангах зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээ[23] юм.Үүнийг 1 дүгээр зургаар үзүүлэв.


Дээрх бүдүүвч нь аврах ажиллагааны, техникийн, ар талын хангалтуудын бүрэлдэхүүний сонгодог хувилбарын илэрхийлэл боловч тэр нь тухайн улс орны онцлог, гамшгаас хамгаалах төрийн бодлогоор тодорхойлогдсон өөрөөрийн хувилбартай өөрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын гүйцэтгэх үүрэгт

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 заалт

[21]О.Үржин, П.Цэдэв нарын, Эрэн хайх аврах ажлын үндэс, 2 дахь талд, УБ., 2012

[22]П.Цэдэв, "Онцгой байдлын үеийн ар тал хангалт" лекцийн 1 дэх тал

[23]П.Цэдэв, "Онцгой байдлын үеийн ар тал хангалт"лекцийн 2 дахьтал



нийцсэн байх зүй тогтолцоотой гамшгаас хамгаалах байгуулалтын асуудлыг тодорхойлно.

Онцгой байдлын ар тал техникийн хангалтын үүрэг, зорилго

Ар тал техникийн хангалт нь өргөн агуулгаараа техникийн (багаж зэвсэглэл, авто хуягтын), ар талын (хүнсний, хувцасны, шатах тосох материалын, тээврийн, аврагчдын техникийн сэлбэг, эд хогшил, соёл гэгээрлийн зүйл орон сууцны, санхүү, худалдааны бусад хангалт) үйлчилгээг хамарсан ойлголт[24]юм.

Онцгой байдлын албаны ар тал бол тайван ба гамшиг ослын үед алба хаагчдыг шаардлагатай бүх төрлийн зэвсэглэмж, техник, материал хэрэглэлээр хангах, зэвсэглэмж техник, материал хэрэглэлийг тээвэрлэх ажиллагааг зохион байгуулдаг.

Аливаа гамшиг ослын үеийн хамтын ажиллагааны амжилт ОБАлбаны ар талын хангалтаас ихээхэн хамаарна.

Онцгой байдлын албаны ар талын хангалт гэдэг нь тайван ба гамшиг ослын үед тодорхой төлөвлөгөө, тооцооны дагуу бүх төрлийн материал хэрэглэлээр цаг тухайд нь тасралтгүй, шуурхай хангах цогц үйл ажиллагаа юм.

Ар тал техникийн хангалтын үндсэн үүрэг:

- Аврагчдыг зэвсэг техник, материалын нөөцөөр орон тоо, нормд хүртэл хангах, хадгалах, хамгаалах, засварлах сэргээн босгох;
- Ар талын техникийн хангалтын хүч хэрэгслийг бэлтгэх;
- Аврагчдын хамгаалалт аюулгүй байдлыг хангах;
- Ар тал техникийн хангалтыг удирдах зэрэг болно.

Эдгээр үндсэн үүрэг нь тухайн аврах ангид тавигдсан үүрэг даргын гаргасан шийдвэрт үндэслэн ар тал техникийн албадаас зохион байгуулах бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, ахуйн болон материал хэрэгслийн хэрэгцээг хангах, гамшгийн голомтод аврагч, гамшигт нэрвэгдсэн иргэд бие бүрэлдэхүүн, зэвсэг техникт эмнэлгийн, техникийн тусламж үзүүлэх арга

[24]П.Цэдэв, "Онцгой байдлын үеийн ар тал хангалт" лекцын 3 дахь тал

хэмжээг тасралтгүй явуулах үйл ажиллагаагаар хангагдана.

Онцгой байдлын ар тал техникийн хангалт: Аврах ажиллагааны бүрэлдэхүүнд багтаж, аврагчдын эрүүл мэнд, зэвсэг техникийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварыг тасралтгүй хангах зорилгоор бүрдүүлж бий болгосон материал хэрэгслийн нөөц бүхий эмнэлгийн, засвар татан гаргалтын, тээврийн, аж ахуйн зориулалтын хүч хэрэгслээс бүрдсэн ар тал техникийн анги салбаруудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээ юм.

Гамшиг ослын үед болон тайван цагт Онцгой байдлын албаны ар талын хангалтыг зохион байгуулах үйл ажиллагаа нь улс орны эдийн засгийн чадавхи, эдийн засгийн дайчилгааны боломж, зэвсэглэмж, техник технологийн шинэчлэлийн төвшин, тайван цагт бүрдүүлсэн материал хэрэглэлийн нөөцийн хэмжээ, тэдгээрийн зохистой байршуулалт, ар талын бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, ар талын техник, хүч хэрэгслийн хангалтын байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Онцгой байдлын албаны ар талын хангалт нь улс орны эдийн засгийн байдалтай шууд холбоотой учир эдийн засгийн дайчилгаа гэдэг ойлголтын талаар онцгойлон авч үзье.

Дайчлах гэдэг нь хөдөлгөөнд оруулах гэсэн утгатай. Орчин үед дайчилгаа гэдэг бол улсын бүх хүчин чадал, нөөцийг Онцгой байдлын албаны дайчилгаагаар дэлгэх нөхцөл ба хэрэгцээнд тохируулан нэгэн бүхэл болгон зангидах асуудал гэж үзэж байна.

Эдийн засгийн дайчилгаа – энэ бол гамшгийн үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эдийн засгийг өөрчлөн байгуулах онцлог үйл явц юм. Эдийн засгийн дайчилгаа нь Онцгой байдлын албаны дайчилгаатай нягт уялдаатай бөгөөд гамшгийн үеийн нөхцөл байдалтай зохицох ёстой.

Эдийн засгийн дайчилгаа дараах зорилтуудыг шийдвэрлэх үүрэгтэй:

- Онцгой байдлын албаны дайчилгаагаар дэлгэн байрлуулах үед материал хэрэглэлийн нөөц, тээвэр, хүн хүч, техник хэрэгслээр хангах;
- Гамшгийн үеийн гарз хохирлыг нөхөх боломжийг урьдчилан бүрдүүлэх;
- Төрийн өмчит үйлдвэрийн газрууд, удирдлагын бүтэц, дэд бүтцүүд, гадаад эдийн засгийн харилцаа, үндэсний эдийн засгийн чухал салбарууд зэргийн тогтвортой байдлыг хангах.

Онцгой байдлын албаны болон мэргэжлийн ангиудын хэрэгцээг бүхэлд нь хангах зорилгоор эдийн засгийг тайван цагийн байдлаас гамшгийн үеийн цагийн байдалд шилжүүлэхэд бэлтгэх, шилжүүлэх арга хэмжээнүүдийн системийг ***эдийн засгийн дайчилгаа***гэнэ.

Эдийн засгийн дайчилгааг хэрхэн зохион байгуулахаас онцгой байдлын албаны ар талын хангалт ихээхэн хамаарна.

Онцгой байдлын албаны ар тал нь гамшгийн үед стратегийн ар талын төгсгөлийн шат бөгөөд анги, байгууллага, салбар, онцгой байдлын

алба хаагч болон техник нэг бүрийг хэрэгцээт бүх зүйлээр хангана.

Онцгой байдлын албаны ар талын үндсэн үүрэг нь гамшиг ослын ямар ч нөхцөлд материал, техникийн хангалтыг цаг хугацаанд нь, тасралтгүй хийх явдал юм. Материал хэрэгслийн хангалт гэдэг нь аврагч нарыг зайлшгүй шаардлагатай багаж зэвсэглэмжийн, техникийн, шатах тослох материалын, хүнсний, хувцасны, орон сууцны эд хогшлын хангалтаар хангах үйл явцыг хэлнэ.

Аврах ажиллагааны үеийн материал хэрэглэлийн хэрэгцээ тухайн анги, салбарын гүйцэтгэж буй үүрэг, бие бүрэлдэхүүн, зэвсэглэл техник, материал хэрэгслийн хангалтын байдал, гамшгийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Энэ бүхнээс үүдэн материал хэрэглэлийн тээвэрлэлтийг богино хугацаанд, оновчтой зохион байгуулах шаардлага урган гарч байна.

дэвсгэрт дэлгэн байрлуулах, ар талын тандалт явуулах, харуул хамгаалалтыг зохион байгуулах зэрэг олон арга хэмжээг зөв зохион байгуулах шаардлагатай байдаг.

Ар талын хангалтын үүргийг амжилттай биелүүлэхэд нөлөөлдөг бас нэг чухал зүйл бол материал хэрэглэлийн тээвэрлэлтийг оновчтой төлөвлөх, автотээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг шаардлагын хэмжээнд байлгах явдал юм. Түүнчлэн үүргээ амжилттай биелүүлэхийн тулд ар талын албадын албан тушаалтнууд дараах зүйлүүдийг мэдэж байх шаардлагатай:

Онцгой байдлын албаны ар талын гүйцэтгэх үүрэг, ажлын цар хүрээ нь шуурхай удирдлагын ар талын үйл ажиллагаа, аврах анги, салбаруудын гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн, газар орон, цаг агаарын байдал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална.

Материалын хангалт нь аврах анги, салбарыг хэрэгцээт зэвсэглэл техник, галт хэрэгсэл, шатахуун, хүнс, хувцас, техник хэрэгсэл бусад зүйлсээр хангахад чиглэгдэнэ.

Онцгой байдлын албаны ар талын хангалтын үүргийг амжилттай биелүүлэхийн тулд нөөцийн салбаруудыг уян хатан, чанд удирдах, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг өндөр төвшинд хүргэх, ар талын хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх хэрэгтэй. Мөн ар талын анги, салбаруудыг тэдний аюулгүй байдал, үүрэг гүйцэтгэх боломжийг хангасан нутаг

- материал хэрэглэлийн нөөцийн хэмжээ, чанар байдал;
- тээврийн болон ар талын техник хэрэгслийн тоо;
- анги, салбаруудын материал хэрэглэлийн хангалтын байдал;
- ар талын бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн төвшин.

Материал хэрэгслийн нөөц: Онцгой байдлын албаны бүх шатны ар талын бааз, агуулах, анги, салбарт хадгалагдаж буй аврах багаж зэвсэглэл, техник, шатахуун, хүнс, хувцас, инженерийн болон бусад эд хэрэглэлийг хэлнэ.

Бүх төрөл, тусгай мэргэжлийн аврах анги салбарын бүрэлдэхүүнд

онцгой байдлын ар талыг бүрдүүлдэг материал хэрэгслийн нөөц бүхий агуулахууд, авто тээвэр, техник, эмнэлгийн болон ар талын бусад салбарууд багтдаг.

Онцгой байдлын ар талын хангалтыг зохион байгуулалтын харьяалалаар нь Онцгой байдлын тусгай анги, аврах анги, салбарын гэж ангилдаг. Бүх төрлийн аврах ажиллагаанд ар талын анги, салбарууд нь хангаж байгаа анги, салбаруудын харьяалалд хамт байрлана.

Онцгой байдлын ар талын үндсэн үүрэг нь аврах үйл ажиллагааг ямарч нөхцөлд явуулахад зэвсэг техник, ар талын материал хэрэгслээр тасралтгүй хангах, өвчтөн шархтанд эмнэлгийнтусламж үзүүлэх, тэдгээрийг гамшгийн голомтоос татан гаргах явдал юм.[25]

Ар талын үүргийг биелүүлэхэд материал хэрэгслийг тасралтгүй тээвэрлэн хүргэх, тээвэрлэлтийг оновчтой зөв чадварлаг зохион байгуулах нь гол чухал үүрэг юм.

Онцгой байдлын удирдлага болзахирагч, штаб болон удирдлагын бусад байгууллагууд цагийн байдлын тухай мэдээлэл авч судлан шинжилж нягтлан, шийдвэр гаргаж гүйцэгчид нь хүргэх замаар аврах ажиллагаанд бэлтгэх болон аврах ажиллагааны явцад анги, салбарын хүчин чармайлтыг аврах үүргээ амжилттай биелүүлэхэд чиглүүлэх зүй зохистой үйл ажиллагаа мөн.

Ар талын удирдлага бол Онцгой байдлын удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм.

Ар талын удирдлага гэдэг нь аврах ажиллагаанд зэвсэг техник, ар талын материал хэрэгсэл, эрүүл мэндийн хангалтыг зохион байгуулж явуулахад захирагч, штаб,арталын дарга, төрөл, мэргэжлийн албадын дарга нараас явуулж буй үйл ажиллагаа бөгөөд ар талыг бэлэн байлгах, бэлтгэх, ар талын өмнө тавигдсан үүргийг биелүүлэх явцад түүнийг удирдах үйл ажиллагаа юм[26].

Ар талын удирдлагын үндсэн зорилго нь аврах үйл ажиллагаанд тавигдсан үүргийг биелүүлэхийн тулд цагийн байдлын тодорхой нөхцөлд ар талын хүч хэрэгслийг дээд зэргээр үр бүтээлтэй ашиглах нөхцөлийг хангах явдал юм[27]. Ар талын удирдлагын үндсэн агуулгад доорх арга хэмжээ хамаарагдана.Үүнд:

- ар талын хангалтыг зохион байгуулах саналыг цаг тухайд нь хэрэгжих үндэслэлтэйгээр гаргаж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэгч нарт маш богино хугацаанд хүргэх;
- аврах үйл ажиллагаанд ар талын хангалтыг төлөвлөх;
- харъяа анги, салбарт тавигдсан үүрэг хүргэх;
- удирдлагын ар талын байр болон ар талын харъяа анги, салбаруудын харилцан

[25]П.Цэдэв, "Онцгой байдлын үеийн ар тал хангалт" лекцын 2. 3 дахь тал

[26]Ц.Төрмөнх "Цэргийнартал, техникийнхангалтынүндэс" лекц

[27]Мөн тэнд

ажиллагаа, хангалтын уялдаа холбоог зохион байгуулах;
- аврах үйл ажиллагаанд бэлтгэх түүнийг зохион байгуулж явуулах үед ар талын төрөл бүрийн хэрэгслийг ашиглаж тасралтгүй удирдах;
- цагийн байдлын мэдээг тасралтгүй олох, цуглуулах,судлах,тогтоох;
- өгөгдсөн үүргийн гүйцэтгэлийг хянаж, туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Ар талын удирдлагын үндсэн агуулгыг хангахын тулд ар талыг бэлэн байдлын өндөр түвшинд байлгах, удирдлагын ар талын байр болон ар талын анги, салбарын удирдлагын байрын тогтвортой ажиллагааг хангах, цагийн байдлын мэдээг цуглуулах, удирдлагын ба холбооны хэрэгслийг үр бүтээлтэй ашиглах, албан тушаалтнуудын ар талын мэдлэгийг гүнзгийрүүлэх, ажлын тэргүүний арга барилыг амьдралд нэвтрүүлэх, аврах үйл ажиллагааны удирдлагыг нарийн зохион байгуулах шаардлагатай юм.

Ар талын хангалт нь дараах зарчмуудтай байна[28]. Үүнд:

1. Ар талын хангалтын албаны бэлэн байдал болон бэлэн байдлын зэргүүдэд шилжихэд байнга бэлэн байх;
2. Ар талын хангалтын хүч хэрэгслийг зөв хувиарлан ашиглах чадвартай байх;
3. Ар талын хангалт тасралтгүй бүрэн хэмжээгээр тухай бүрд нь хийгдэж байх;
4. Ар талын хангалтыг зөрчил гарч болзошгүй чиглэлд төвлөрүүлж, төлөвлөгдсөн байх;
5. Ар талын хангалт нь аривлан хэмнэлтийн зарчимд тулгуурлагдсан байх;
6. Ар талын хангалтын материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн байх;
7. Ар талын хүч хэрэгсэл сургагдсан, ашиглах чадвартай маневарлах хугацааг зөв сонгож хийж чаддаг байх;
8. Ар талын удирдлагын тогтвортой байдлыг өндөр түвшинд байлгах зэрэг болно.

Ар талын удирдлага нь Онцгой байдлын албаны удирдлагын нэгэн адил өндөр бэлэн байдалтай, шуурхай бүтээлч ажиллагаатай, бат тогтвортой байх шаардлагатай. Ар талын удирдлагад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- тасралтгүй байх;
- хатуу чанд байх;
- уян хатан байх.

Эдгээр шаардлагууд нь доорхи үйл ажиллагааг нарийн чандтөлөвлөгөөтэй хэрэгжүүлсэнээр хангагдана. Үүнд:

Тасралтгүй байх нь:

- захирагч штаб, удирдлагаас тавигдсан үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд байнга нөлөөлөх;
- аврах болон холбоо мэдээллийн найдвартай техник хэрэгсэлтэй байх;
- алдагдсан удирдлагыг богино хугацаанд сэргээх чадвартай байх;

[28]Ц.Төрмөнх "Цэргийн ар тал, техникийн хангалтын үндэс" лекц

- цагийн байдлын тухай мэдээг тасралтгүй авах боломжтой.

Хатуу чанд байх нь:

- гаргасан шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх;
- шийдвэртэй, зоригтой арга хэмжээг хэрэгжүүлэх;
- албан хаагчддаа өндөр шаардлага тавих;
- хамт олныг тавигдсан үүргийг биелүүлэхэд чиглүүлэх.

Уян хатан чанар нь:

- цагийн байдлын өөрчлөлт бүрд тасралтгүй удирдах өөрчлөлтийг урьдчилан төсөөлөх, таамаглах мэдрэмжтэй байх;
- удирдлагыг нэг байрнаас нөгөөд шуурхай шилжүүлэх боломж;
- холбоо удирдлагын хэрэгслийг чадварлаг ашиглах цагийн байдлын ямарч нөхцөлд удирдлага бэлэн байх зэрэг болно.

Үргэлжлэл дараагийн дугаарт.

НЕФТЬ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН РЕЗЕРВУАРТ ГАРСАН ГАЛ ТҮЙМРИЙГ УНТРААХ АРГА ЗҮЙ

Хурандаа Б.Машбат
Гал түймэртэй тэмцэх албаны тэнхмийн эрхлэгч, докторант

Нефть бүтээгдэхүүний агуулахын резервуарт ихэнх тохиолдолд хий уурын холимогийн тэсрэлтийн улмаас гал түймэр үүсвэрлэн гардаг.

Гал түймэр тархан дэлгэрэхэд доорх хүчин зүйлүүд нөлөөлдөг. Үүнд:

- Гал түймэр үүсвэрлэн гарсан газар (гал түймрийн голомт)
- Гал түймрийн голомтын хэмжээ
- Резервуарийн хийц бүтээцийн бат бөх чанар
- Тухайн үеийн цаг агаар болон цаг уурын нөхцөл байдал
- Тухайн объектийн ажилчдын гамшиг, ослын үед ажиллах шуурхай бэлэн байдал
- Объектийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, зохион байгуулалт
- Объектод гал унтраах ангийн хүрэлцэн ирэх хугацаа

Нефть бүтээгдэхүүний агуулахын босоо төмөр хийцтэй резервуарт гарсан гал түймрийг унтраахад хамгийн түрүүнд шатаж буй болон зэргэлдээ резервуарийг хөргөх арга хэмжээг зохион байгуулна. Үүнтэй зэрэгцээд нефть бүтээгдэхүүн дамжуулах хоолой шугам, шатаж буй болон зэргэлдээ резервуарийн хаалт, залгааг нойтон эсгийгээр бүтээж хамгаална.

Шатаж буй резервуарийн эргэн тойрон гадаргууг анхны хушуугаар хөргөх ба дараагийн хушуугаар хамгийн ойр зайд байрлах зэргэлдээ хоёр резервуарийн гадаргууг шатаж буй резервуар талаас (резервуарийн хагас тойргийн гадаргууг) хөргөнө.

5000 $м^3$ дээш эзэлхүүнтэй резервуарийг лафетний хушуугаар хөргөлт хийнэ.

Шатаж буй резервуарийн салхины дагуу байгаа зэргэлдээ резервуарийг эхэлж хөргөхөөс гадна энэ резервуарийн амьсгалын хавхлагийг тусдаа хушуу гарган хөргөх ажиллагааг зохион байгуулна.

Резервуарийг хөргөх хушууны тоог тооцоолж олно. Шатаж буй резервуарийг 3 – аас доошгүй хушуугаар, зэргэлдээ резервуарыг 2 – оос доошгүй хушуугаар хөргөлт хийнэ.

Хөөсөөр шатаж буй резервуарийг унтраах үйл ажиллагааг зохион байгуулахаас өмнө 15 минутын хугацаагаар хөөсөөр 3 удаа дайралт (гал түймрийг унтраах) хийх хөөс үүсгэгчийн нөөцийг бүрдүүлнэ. Мөн хөөсөөр гал түймрийг унтрааж буй техник хэрэгслийг гар болон лафетийн хушуугаар хөргөх ажиллагааг зохион байгуулна..

Шатлагыг бүрэн зогсоотол тооцоолон бодож гаргасан бүх хүч хэрэгслээр шатаж буй резервуарийн гал түймрийг хөөсөөр унтраах дайралт хийнэ. Шатамхай шингэн дахин дөллөн асахаас урьдчилан сэргийлэхийн тулд шатлага зогссоны дараа 5 минут хөөсөөр гал унтраах үйл ажиллагаагааг үргэлжлүүлэнэ.

Хүснэгт 1

РВС маркийн резервуарийг хөргөх усны эрч

Хөргөх арга	Резервуарийг хөргөх усны эрч		
	Шатаж буй резервуар	Зэргэлдээ резервуар	Даланд гал түймэр тархан дэлгэрсэн үед
Галын автомашины болон бусад хөдөлгөөнт техник хэрэгсэлийн тусламжтайгаар галын хушуугаар хөргөлт хийх	0,8	0,3	1,2
Резервуарийн суурин цагираг хэлбэрийн төхөөрөмжөөр хөргөх			
- РВС маркийн 12 м доош өндөртэй резервуар	О,5	0,2	1,0
- РВС маркийн 12 м дээш өндөртэй резервуар	0,75	0,3	1,1

Хүснэгт 2

Резервуарийн геометр хэмжигдэхүүн

д\д	Резервуарийн төрөл	Резервуарийн өндөр, м	Резервуарийн диаметр, м	Толиогоор шатах талбай, м	Резервуарийн периметр, м
1	РВС-1000	9	12	120	39
2	РВС-2000	12	15	181	48
3	РВС-3000	12	19	283	60
4	$РВС\text{-}5000_1$	12	23	408	72
5	$РВС\text{-}5000_2$	15	21	344	65
6	$РВС\text{-}10000_1$	12	34	918	107
7	$РВС\text{-}10000_2$	18	29	637	89
8	РВС-15000	12	40	1250	126
9	РВС-15000	18	34	918	107
10	РВС-20000	12	46	1632	143
11	РВС-20000	18	40	1250	125
12	РВС-30000	12	47	1764	149
13	РВС-30000	18	46	1632	143
14	РВС-50000	18	61	2892	190

Хүснэгт 3.

Резервуарийн гал түймрийг унтраах хөөс үүсгэгч холимгийн эрч

Нефть бүтээгдэхүүний төрөл	Хөөс үүсгэгч холимгийн эрч, л/(с·м^2)	
	Фторын хольцтой хөөс үүсгэгч	Ерөнхий зориулалтын хөөс үүсгэгч
Нефть, нефть бүтээгдэхүүн $\mathbf{T_{дөл.ас} \geq 28^0C}$	0,05	0,08
Нефть, нефть бүтээгдэхүүн $\mathbf{T_{дөл.ас} > 28^0C}$	0,05	0,05
Хийн конденсат	0,12	0,30
Бензин, керосин, дизелийн түлш, хийн конденсацаас гаргаж авсан бүтээгдэхүүн	0,10	0,15

Хөөсөөр гал унтраах үйл ажиллагаа эхэлснээс хойш 15 минутын дотор шатлага зогсохгүй бол шалтгааныг нь тогтоож хөөсөөр гал унтраах тооцоогоо дахин хийсний дараа гал унтраах үйл ажиллагаагааг дахин шинээр зохион байгуулна.

Нефть бүтээгдэхүүний агуулахын резервуарт гарсан гал түймрийг унтраах жишээ бодлого

Өгөгдөхүүний хүрээнд резервуарт гарсан гал түймрийг унтраах бодлогоор дараах зүйлүүдийг шийдвэрлэнэ.Үүнд:

1. Нефть бүтээгдэхүүний агуулахын резервуарт гарсан гал түймрийг унтраах хүч хэрэгслийн тооцоог хийх
2. Нефть бүтээгдэхүүний агуулахын резервуарт гарсан гал түймрийг унтраах хүч хэрэгслийг байрлуулсан тактикийн бүдүүвч зургийг үйлдэх


Тайлбар:

- Резервуарын геометр хэмжигдэхүүнийг Хүснэгт 2 – оос харна.
- Резервуарын бүлэглэлд нэг төрлийн нефть бүтээгдэхүүн хадгалсан
- Зэргэлдээ 2 резурвуар хамгийн ойр зайд байрласан
- 5000 $м^3$-ээс бага багтаамжтай резервуарийг РС-70 хушуугаар, 5000 $м^3$-ээс их багтаамжтай резервуарийг лафетний хушуугаар хөргөлт хийнэ
- 3000 $м^3$ хүртэл багтаамжтай резервуарт ГПС – 600, 3000 $м^3$ – ээс дээш дээш багтаамжтай резервуарт ГПС – 2000 хөөсний хушуугаар хөөс өгнө.
- Энэ бодлогот ерөнхий зориулалттай хөөс үүсгэгчээр гал түймрийг унтраахаар тооцсон.

Нефть бүтээгдэхүүний агуулахын РВС маркийн 3000 м3 багтаамжтай резервуарт гал түймэр гарчээ (Зураг 2). Уг резервуарт АИ – 93 маркийн бензин хадгалагдаж байсан ба 3000 $м^3$ багтаамжтай 2 резервуар хамгийн ойрхон зэргэлдээ байрласан байв.

Нефть агуулахын гал унтраах усан хангамжийн систем (Зураг 1).

Хамгийн ойрхон байрлах гал унтраах ангийн чадамж АЦ-40, АНР – 40, АЛ, АКП, АВ – 40 маркийн гал унтраах автомашинаар хангагдсан.



Зураг 1. Нефть бүтээгдэхүүний агуулахын резервуарийн бүдүүвч ба усан хангамжийн систем

Тодорхойлох нь:

- Шатаж буй болон зэргэлдээ байрлах резервуарийг хөргөх РС–70 маркийн хушууны тоог тодорхойлох.
- Хөөсөөр гал унтраах ГПС – 2000 маркийн хөөсний хушууны тоог тодорхойлох.
- Бүдүүвч зураг дээр хүч хэрэгсэлийг байрлуулах

Бодох нь:

1. Шатаж буй резервуарийг хөргөх хушууны тоог тодорхойлох:

$N_{хө}^{ш} = P_{ш} \cdot I_{шаа}^{ш} / q_{хо} =$ = (60 х 0,8)/7 = 6,85 → 7 хошуу

$P_{г}$= 60 м – Шатаж буй резервуарийн периметр, м (Хүснэгт 2);

$I_{тр}^{г}$ = 0,8 л/(с•м) –Шатаж буй резервуарийг хөргөх шаардлагатай ус өгөх эрч, (Хүснэгт 1);

$q_{ств}$ = 7 л/с - РС 70 маркийн хушууны зарцуулалт

2. Зэргэлдээ резервуарийг хөргөх хушууны тоог тодорхойлох:

- Резервуар №1

$N_{хо}^{№1} = 0,5 \cdot P_{з} \cdot I_{шаа}^{3} / q_{хо} = 0,5 \cdot 60 \cdot 0,3 / 7 = 1,28 \Rightarrow 2$ (РС – 70 хушуу)

- Резервуар №2

$N_{хө}^{№2}$ **=0,5·$P_з$· $I_{шаа}^{3}$ / $q_{хо}$ = 0,5 · 60 · 0,3 / 7 = 1,28 => 2 (РС – 70 хушуу)**

$P_з$ = 60 м – зэргэлдээ резервуарийн периметр, м (Хүснэгт 2)

$I_{шаа}^{3}$ = 0,3 л/(с·м^2) - зэргэлдээ резервуарийг хөргөх шаардлагатай усны эрч, л/(с·м^2) (Хүснэгт 1)

3. Зэргэлдээ резервуарийн амьсгалын хавхлаг, хөөсөөр гал унтрааж буй техник хэрэгслийг хөргөх РС – 70 хушууны тоог тодорхойлох.

- Хөөсөөр гал түймэр унтрааж буй техник, хэрэгслийг хөргөхөд нэг ширхэг РС – 70 хушуу шаардагдана.
- Шатаж буй резервуарийн салхин доор байрлаж буй зэргэлдээ №2 резервуарийг хөргөхөд нэг ширхэг РС – 70 хушуу шаардагдана.

4. Шатаж буй болон зэргэлдээ резервуаруудад болон хөөсөөр гал түймэр унтрааж буй техник хэрэгслийг хөргөхөд шаардлагатай тасгийн тоог тодорхойлох.

$N_{тас}^{хө}$ = $N_{хө}^{ш}$/$n_{хо}^{(РС-70)}$ + Σ $N_{хө}^{з}$/ $n_{хо}^{(РС-70)}$= 7/2 + (2/2 + 2\2) = 5,5 => 6 (тасаг)

$n_{хо}^{(РС-70)}$= 2 ширхэг РС – 70 хушуугаар хөргөлт хийхэд нэг тасаг шаардагдана

Зэргэлдээ резервуарийн амьсгалын хавхлаг, хөөсөөр гал унтрааж буй техник хэрэгслийг хөргөхөд нэг тасаг шаардагдана.

5. Хөөсөөр гал унтраах шаардлагатай хөөсний хушууны - $N_{гпс}$ тоог тодорхойлох:

$N_{ГПС}$ = $S_{гт}$ · $I_{шаа}^{хол}$/$q_{хо}^{хол}$ = 283 ·0,08 / 20 = 1,13 => 2 (ГПС - 2000)

$S_{гт}$ = 283 м^2 – Шатамхай шингэнтэй резервуарийн шаталтын гадаргуугийн талбай (Хүснэгт 2);

$I_{шаа}^{хол}$ = 0,08л/(с•м2)– Шатаж буй резервуарын гал түймрийг унтраахад шаардлагтай ус хөөс үүсгэгчийн холимгийн шаардлагтай эрч (Хүснэгт 3);

$q_{хо}^{хол}$= 20 л/с – ГПС – 2000 маркийн хөөсний хушуугаар хөөс үүсгэгчийн холимгийг өгөх зарцуулалт (Хүснэгт 3);

6. Гал түймрийг унтраахад шаардлагатай хөөс үүсгэгчийн хэмжээг тодорхойлох


$V_{х.ү}$ = $N_{ГПС}$ · $q_{гпс}^{х.ү}$ · $t_{но}$ · 60 · K_3 = 2 · 1,2 · 15 · 60 · 3 = 6480 л

$q_{гпс}^{х.ү}$ = 1,2л/с– ГПС хөөсний хушууны хөөс үүсгэгчийн зарцуулалт (6-% хольцтой холимог), л/с

$t_{но}$ = 15 мин – Хөөсөөр гал унтраах нормт хугацаа

K_3 = 3 – Хөөс үүсгэгчийн 3 удаагийн нөөц

1. Гал түймэр гарсан газарт хөөс үүсгэгчийг хүргэх шаардлагатай галын хөөсний албаны автомашины тоог тодорхойлох:



Зураг 2. Нефть бүтээгдэхүүний агуулахын резервуарт гарсан гал түймрийг унтраах бүдүүвч зураг

$N_{ХөГАМ} = V_{хө.у}/V_{ХөГАМ} = 6480 / 5300 = 1,22 = 2$ **(ХөГАМ \АПТ\)**

$V_{ХөГАМ}$ **= 5300 л** – Хөөсөөр гал унтраах АПТ маркийн автомашины хөөс үүсгэгчийг тээвэрлэх багтаамж, л

2. Нефть бүтээгдэхүүнй агуулахын бүдүүвч зураг 2 дээр хүч, хэрэгслийг байрлуулав

- ❖ Шатаж буй болон зэргэлдээ резервуарууд, зэргэлдээ резервуарийн амьсгалын хавхлаг, хөөсөөр гал түймрийг унтрааж буй техник хэрэгслийг хөргөж байгаа хушуу хоолойн бүдүүвч зураг.
- ❖ ГПС маркийн хөөсний хушуугаар гал түймрийг унтрааж байгаа бүдүүвч зураг.

ДҮГНЭЛТ:

Хөргөлт хийхэд шаардлагатай хушууны тоо

- ❖ Шатаж буй резервуарийг хөргөхөд РС – 70 маркийн 7 хушуу
- ❖ Зэргэлдээ №1 резервуарийг хөргөхөд РС – 70 маркийн 2 хушуу
- ❖ Зэргэлдээ №2 резервуарийг хөргөхөд РС – 70 маркийн 2 хушуу
- ❖ Зэргэлдээ №1 резервуарийн амьсгалын хавхлагийг хөргөхөд РС – 70 маркийн 1 хушуу
- ❖ Хөөсөөр гал унтрааж буй техник, хэрэгсэл, зэргэлдээ №2 резервуарийг хөргөхөд РС – 70 маркийн 2 хушуу тус тус шаардагдана.

Гал түймрийг унтраахад шаардлагтай хөөсний хуушууны тоо

- ГПС – 2000 маркийн хөөсний 2 ширхэг хушуу
- 6480 л хөөс үүсгэгч
- АВ–40(5557) маркийн хөөсөөр гал унтраах 2 машин тус тус шаардагдана.

Ном зүй

1. Я.С.Повзик. Пожарная тактика. М.1999.
2. В.П.Иванов, П.П.Клюс.Справочник руководитель тушения пожаров. М. 1987.
3. Т.Лхамжав. Гал унтраах арга зүй. УБ. 1991.
4. Г.Даваадорж. Гал унтраах бодлогын хураамж. УБ. 1996.
5. Д.Ганболд. Гал унтраах багж зэвсэглэмж. УБ. 2010
6. Д.Эрдэнэбилэг. Шатлагын физик химийн үндэс хичээлийн бодлогын сурах бичиг. УБ. 2014.
7. Д.Баян-Эрдэнэ. Галын усан хангамж. УБ. 2007.

ХҮНИЙ АМЬСГАЛЫН ЭРХТЭНД ХОРТ ХИЙ УТААНЫ НӨЛӨӨЛӨЛ

Дэд хурандаа С.Баттөмөр
Гал түймэртэй тэмцэх албаны тэнхмийн ахлах багш, докторант

Хүний амьсгалын эрхтэн уушиг: Хүний амьсгалах гол эрхтэн бол уушиг. Уушигны үндсэн үүрэг нь амьсгалах үйл ажиллагааг явуулан хийн солилцоонд оролцдог. Амьсгалах гэдэг нь хүчилтөрөгч \$O_2$\ ба нүүрсхүчлийн хийн \$CO_2$\ даралтын нөхцөлдсөн солилцоо буюу хүчилтөрөгч \$O_2$\ хэрэглэж нүүрсхүчлийн хий \$CO_2$\ гадагш гаргах үйл ажиллагааны цогц нэгдэл юм. Өөрөөр хэлбэл амьсгалын үр дүнд нүүрсхүчлийн хий \$CO_2$\ цуснаас гарч, тэр хэмжээний хүчилтөрөгч \$O_2$\-өөр хангагдана. Уушиг бол цээжний хөндийн ихэнх зайг эзлэн оршдог хос эрхтэн, баруун нь гурван дэлбэн, арван хэлтэн, зүүн нь хоёр дэлбэн, арван хэлтэнгээс тогтож, дэлбэнгүүд хоорондоо холбогч эдээр тусгаарлагдан ховил үүсгэсэн байдаг бол орой нь уруугаа харсан пирамид хэлбэртэй, хэлтэнгүүд хоорондоо холбогч эдэн хальсаар зааглагдана.

Цээжний хөндийн эзэлхүүн өөрчлөгдөхөд түүнийг дагаад уушигны эзэлхүүн өөрчлөгдсөний үр дүнд гадаад амьсгал, амьсгалын үйл ажиллагаа хангагдаж, амьсгал авахад цээжний эзэлхүүн ихэсч, гаргахад багасна. Амьсгалын энэ хөдөлгөөнөөр гадаад амьсгалын үндсэн үйл ажиллагаа болох уушигны агааржуулалт явагдана. Уушигны агааржуулалт нь амьсгалын булчингийн идэвх, гуурсан хоолой агаар дамжуулах байдал, уушигны уян харимхайн ба сунамхай чанар, уушигны хэсэг бүр дэх хийн тархалт ба цусны гүйдэл зэрэг олон хүчин зүйлүүдээр тодорхойлогдож, эдгээрийн аль нэг нь өөрчлөгдөхөд амьсгалын хямрал, улмаар дутагдал үүснэ.

Уушигны эзэлхүүн: Амьсгалын янз бүрийн үе дэх уушгинд агуулагдаж байгаа агаарын хэмжээгээр тодорхойлогдох үзүүлэлтийг уушигны эзэлхүүн гэнэ. Хэд хэдэн эзэлхүүний нийлбэрийг уушигны багтаамж гэсэн нэр томъёогоор илэрхийлнэ. Уушигны эзэлхүүн ба багтаамжийг спирографи болон бусад шинжилгээний аргуудаар тодорхойлох ба дөрвөн эзэлхүүн, дөрвөн багтаамжтай байдаг. Уушиг болон амьсгалын замын агаарын эзэлхүүн нь дараах зүйлээс хамаарна.

1. Хүний бие галбир, амьсгалын тогтолцооны байдлаас;
2. Уушигны эдийн шинж чанараас;
3. Цулцангийн гадаргуугийн таталцлаас;
4. Амьсгалын булчингийн хүч зэргээс хамаарч өөр өөр байна;

Амьсгалын хэвийн үйл ажиллагааны үед гарах амьсгалыг ердийн амьсгал гэнэ. Ердийн амьсгал нь жигд далайцтай байдаггүй ба тодорхой нэг хугацаанд гүн амьсгал авдаг үүнийг шургамал амьсгал авалт гэнэ. Шургамал амьсгал авалт нь уушигны агааржуулалт муу явагддаг хэсэг газрын хийн солилцоог сайжруулах, хэрэгцээг зохицуулах зэрэг физиологийн чухал ач холбогдолтой. Энгийн үед хүн 20-60 удаа амьсгалсны дараа шургамал амьсгал гардаг ба ердийн амьсгалын

давтамж мөчлөг, далайц, хэмнэл алдагдахыг эмгэг амьсгал гэнэ. Хамгийн олон тохиолдох эмгэг амьсгал бол амьсгаадалт юм.

Амьсгаадах үед амьсгалын давтамж далайц өөрчлөгдөхийн зэрэгцээ амьсгал бачимдах шинж илэрнэ. Амьсгаадалт бол цусанд хүчилтөрөгч \$O_2$\ буурч нүүрсхүчлийн хий \$CO_2$\ ихэссэнтэй холбоотойгоор амьсгалын төв цочирсноос үүсдэг. Амьсгал түргэссэнтэй холбоотой хүний ашигт үйл ажиллагаа буурдаг. Амьсгаадалтыг инспиратор ба экспиратор гэж хоёр ангилдаг. Инспиратор амьсгаадалтын үед амьсгалын замд нарийсалт үүссэнтэй холбоотой амьсгал авалт саадтай удаан болдог бол экспиратор амьсгаадалтын үед уян хатан байдал алдагдан амьсгалах талбай багассантай холбоотой амьсгал гаралт нь саадтай удаан болдог. Энэ хоёр хэлбэр нь хавсарсан байдлаар тохиолдож болно.

Бидний амьсгалж буй агаарт нүүрсхүчлийн хий \$CO_2$\ маш бага хэмжээтэй байдаг нүүрсхүчлийн хий \$CO_2$\ цусны сийвэнд амархан уусдаг. Артерийн цусанд байгаа нүүрсхүчлийн хий \$CO_2$\ 5 орчим хувь нь энэ хэлбэрээр зөөгддөг. Гал түймэр гарсан үед дутуу шатсан эд зүйлсээс нүүрсхүчлийн дутуу исэл орчинд тархаж хүний амьсгалын эрхтнээр дамжин цусанд орж цусны хүчилтөрөгч зөөвөрлөх чадвар багасч цусанд хүчилтөрөгч дутагдана. Ингэснээр хүний толгой эргэх, дотор муухай оргих, бөөлжис цутгах, зүрх дэлсэх, амьсгаадах шинж тэмдэг ажиглагдана.

Хүчилтөрөгч /O_2/ организмуудын амьсгалах болон исэлдэх явцад оролцдог, уураг өөх тос, нүүрс усны хайрлагад ордог, биологийн явц дахь энергийн эх үүсвэр юм. Азот /N/ хүчилтөрөгчийг шингэлэгчийн үүрэг гүйцэтгэх ба исэлдэх болон биологийн явцын эрчмийг зохицуулдаг. Мөн бодисын биологийн эргэлтэнд оролцдог, уураг хүчлийн найрлагад орох ба азотын эргэлт нь бичил биетнээр дамжин явагдана. Озон /O_3/ нарны хэт ягаан туяа ба цахилгаан цэнэгийн нөлөөгөөр хүчилтөрөгчийн атом задарч озоныг үүсгэнэ. Газрын гадарга орчим озоны хэмжээ өчүүхэн бага боловч бороо орсны дараа нэмэгддэг, 22-40 км-ийн өндөрт озоны масс хуримтлагдсан давхаргыг озоны давхарга гэнэ. Нарнаас ирэх хэт ягаан туяаг шингээн авч амьд организмыг хорт туяанаас хамгаалдаг. Хүүрсхүчлийн хий /CO_2/ ургамлын фотосинтезэд оролцдог, дэлхийн гадаргын урт долгионт цацраг, дулааны энергийн зарим хэсгийг өөртөө шингээдэг ба ингэснээр амьдрал оршин тогтноход шаардагдах дулааныг барьж хадгалаж байдаг. Хэрэв нүүрсхүчлийн хий байгаагүй бол манай дэлхийн дундаж температур -17^0C байх байсан ба одоо манай дэлхийн дундаж температур 15^0C байна. Аргон /Ar/ 1984 онд агаарт химийн идэвхгүй хий Аргон байдгийг нээсэн ба төрөл бүрийн гэрэлтүүлэг чимэглэлд ашигладаг.

1 дүгээр хүснэгт. Хорт бодисийн физиологийн үйлчлэл

Байгын бүрэлдэхүүн	**Томъёо**	**Эзлэх хувь**
Азот	N	78,08
Хүчилтөрөгч	O_2	20,95
Аргон	A_z	0,93

Нёон	N	0,002
Өөрчлөгддөг бүрэлдэхүүн	**Томъёо**	**Эзлэх хувь**
Усны уур	H_2O	0,1-4,0
Нүүрсхүчлийн хий	CO_2	0,0034
Озон	O_3	0,0006

2 дугаар хүснэгт. Нүүрсхүчлийн дутуу исэл \CO\, нүүрсхүчлийн хий \CO_2\ хүний биед нөлөөлөх байдал

Хий	Агаар	Үйлчлэх байдал
CO	0,01	Тодорхой хэдэн цагийн дараа үл мэдэх үйлчлэх
	0,1	Толгой өвдөх цагийн хугацаанд бөөлжис хүрэх
	0,5	20-30 мин хооронд үхэлд хүрэх
	1	1-2 мин дараа амьсгал авсны дараа ухаан алдах хүчтэй хордох
CO_2	0,04	Хоргүй
	4-5	Амьсгалын дэглэмд өөрчлөлт орж судасны цохилт түрэгсэх, хурдан гүн амьсгалах, чих шуугих
	8	Толгой өвдөх эргэх
	10	Ухаан алдана

Гал түймэр гарсан тохиолдолд гол төлөв органик бодис шатдаг ба шаталтын үед утаа, хортой хий ялгаруулдаг байна. Утаа бол гал түймрийн шатлагын улмаас тогтсон өчүүхэн хатуу хэсгийн тархац бөгөөд энэ нь хүнийг хорт хийн нэгэн адил хордуулах чадалтай байдаг. Эдгээрээс зарим бодисын шинж чанарыг авч үзвэл:

Азот: Өнгөгүй, үнэргүй, усанд муу уусдаг агаараас бага зэрэг хөнгөн 0,25 гр/л азот нь шатдаггүй галыг тэтгэдэггүй ердийн үед азот хүний биед хоргүй харин порцилний даралт ихэссэнээс хортой үйлчлэл үзүүлдэг.

Хүчилтөрөгчийн физик шинж чанар: Хүний амьдралын зайлшгүй хэрэгцээтэй хий, өнгө, үнэр, байхгүй агаараас, бага зэрэг хүнд /1,43 гр/л / шатдаггүй галыг тэтгэдэг.

Нүүрсхүчлийн хий: /CO_2/: Ердийн үед өнгөгүй, хурц амттай, шатдаггүй галыг тэтгэдэггүй, усанд муу уусдаг агаараас хүнд атмосферийн даралтын нүүрсхүчлийн хий их тохиолдолд хортой. Жишээ нь: 0,3 МПа - 3 кгс/см^2 үед 15-30 минутын дараа шөрмөс татаж ухаан алдана.

Нүүрсхүчлийн дутуу исэл: /CO/: Үнэргүй өнгөгүй хий агаараас бага зэрэг хөнгөн /1,25 гр/л /усанд бараг уусдаггүй, сайн шатдаг хүний организмд хортой. Гал түймэр гарсан тохиолдолд атмосферийн агаарын бүрэлдэхүүний хийн тоо хэмжээ их өөрчлөгддөг. Хүндээр хордсон үед гэмтэгсдийн биеэр улаан хүрэн толбууд үүсэх, толгой өвдөх, толгой эргэж гуйвах, согтуу хүн шиг хөөрлийн байдалд орох улмаар ухаан алдах зэрэг шинж тэмдэг илэрнэ.

Хүндээр хордох нь амь насанд аюултай. Хүний организмд хортой бодис үйлчлэх зэргээр дөрөв хуваана. Онц, өндөр, дунд, бага аюултай гэж хуваадаг. Хүний эрхтэнг хамгийн их хордуулдаг хий бол нийлэг материалийн задрал юм. 1кг/м^3 -ээс олон найрлагатай нийлэг материал

шатахад цианы устөрөгч 210-250 кг/м^3, хлорт 300-400 кг/м^3, фторт 250-300 кг/м^3, нүүрсхүчлийн эсэлт 1000 мг/м^3 ялгардаг байна. Хүний хамгийн үнэт эрдэнэ нь эрүүл мэнд юм.

Хүн амьтны эрүүл явах үндэс бол цэвэр агаараар амьсгалах. Хүн хоол тэжээлгүйгээр тодорхой хугацаанд явж чадах боловч хүчилтөрөгчгүйгээр хэдэн хоромч байж чадахгүй. Тайван байдалд эрүүл хүн нэг минутанд 8-10 литр, цагт 500-600 литр агаараар амьсгалдаг бол гамшиг осол, гал түймрийн голомтод тусгай үүрэг гүйцэтгах ажиллагаанд хорт хий, утаанаас хамгаалах аппараттай ажиллах биеийн хүчний ачааллын үед минутанд 40 литр агаараар амьсгалдаг байна. Хүний амьсгалын эрхтнүүд нь байгалиасаа өөрийгөө цэвэрлэх, хамгаалах, хоргүйжүүлэх үйл ажиллагаатай тэд хоорондоо нарийн өндөр уялдаатай явагдаж, бие махбодыг бүрэн хамгаалахаар заяасан байдаг. Гэтэл хорт хий, утааны нөлөөгөөр дээрх үүргээ гүйцэтгэж чадахгүй болдог байна.

ЭРДЭМ ШИГЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

ТАРИАЛАНГИЙН ТӨВИЙН БҮСИЙН ХҮРЭН ХӨРСНИЙ АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГЭЭС

дэд хурандаа Х. Мягмаржав
Доктор /Ph.D/, МУ-ын зөвлөх агрономч,
дэд хурандаа Д. Цэрэндорж
ЭЗНУТэнхмийн багш,
дэд ахлагч Н. Одмаа
ЭЗНУТэнхмийн багш, докторант

Хураангуй

Хөрсний үржил шимийг тооцсон үзүүлэлтүүдээс уг үйл явцад давамгайлан нөлөөлөх хүчин зүйлүүд болох хөрсний урвалын орчинг усан иономерийн аргаар тодорхойлоход нийт талбайн 60.7 % нь сул хүчиллэг, хялбар ашиглагдах нитрат азотын хэмжээ нийт талбайн 70.6% -д маш бага (0.5 мг/100 гр –аас бага), механик бүрэлдхүүний тодорхойлолтоор нийт талбайн 63.4 % элсэнцэр гэсэн дүн гарч байна.

Иймд хөрсний элэгдлийн судалгаа нь цаашид хөрс хамгаалах, хөрсний ургамлан нөмрөгийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхэд ихээхэн чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.

Тариалангийн төвийн бүсийн төдийгүй манай орны нийт хөрсний элэгдэл, эвдрэл түүн дотроо салхины эвдрэл нь маш хурцадмал асуудлын нэг болоод байна.

Түлхүүр үг: Үржил шим , хөрсний элэгдэл, хүчиллэг, механик бүрэлдхүүн, хөрсний агрегат

Нэг. Оршил

Монгол орны тариалангийн талбайг хөрсний элэгдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, усалгааны систем, ойн зурвас байгуулах, бэлчээрийн даацыг тохируулах болон цөлжиж байгаа газар нутгийг нөхөн сэргээх, мод, бут тарих, ургамалжуулах, усан сан байгуулах, гангийн нөлөөг бууруулах зэрэг үйл ажиллагаа нь энэ чиглэлийн эрдэмтэн судлаачдын нэн тэргүүнд анхаарах асуудал болж байна.

Хөрсний элэгдэл эвдрэл хэд хэдэн хүчин зүйлийн үйлчлэлээр мөн харилцан адилгүй түвшинд илэрдэг.

Байгаль, экологийн бүсийн онцлогийг харгалзан ус, салхи ба хөрс элдэншүүлгээс үүдэлтэй элэгдлийн явц, түүний улмаас хөрсний олон талт үйлчилгээнд гарах сөрөг үр дагаврыг онолын үүднээс дэлгэрэнгүй тайлбарлаад зогсохгүй, хөрсний элэгдлийг хэмжиж үнэлэх аргачлал, элэгдлийг хязгаарлан доройтсон хөрсийг нөхөн сэргээж үржил шимийг сайжруулах арга хэмжээг нарийвчлан тодорхойлж, өртөг багатай хамгийн энгийн аргаас авахуулаад өндөр технологи шаардагдах дэвшилтэт арга ажиллагааны олон хувилбарыг дэвшүүлэх нь судлаачдын нэн тэргүүний зорилт болоод байна.

Хоёр. Судалгааны ажлын зорилго: Бидний судалгааны ажлын

гол зорилго нь Монгол орны тариалангийн төвийн бүсийн хүрэн хөрсний үр шимийг судлан үнэлэх байгаль орчны төлөв байдлын гол үзүүлэлт болох агрохимийн үзүүлэлтийн түвшин ямар хэмжээнд байгааг тодорхойлж зураглал гаргах явдал байлаа.

Эдгээр ажлын ажлын хүрээнд доорх зорилтуудыг гүйцэтгэхээр тодорхойлсон.

1. Монгол орны тариалангийн бүсийн томоохон төлөөлөл болох Төв аймгийн Жаргалант сумын аж ахуйн нэгжүүдийн талбайгаас хөрсний дээж авч агрохимийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлох

2. Тариалангийн талбайн хөрсний дээжний механик бүрэлдэхүүнийг тодорхойлж хөрсний элэгдлийг тооцно.

3. Тариалангийн талбайн хөрсний агрохимийн шинжилгээний дүн болон механик бүрэлдэхүүний дүнг үндэслэн зөвлөмж боловсруулах.

Гурав. Тариалангийн төвийн бүсийн хүрэн хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлж, хөрсний элэгдлийг тодорхойлох судалгааны ажлын шинэлэг тал ба практик ач холбогдол:

Тариалангийн төвийн бүсийн хүрэн хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж, үржил шимийн үзүүлэлтүүдийн хамаарлыг тогтооход гол хүчин зүйлүүд болох хөрсний ялзмагийн агууламж, хөрсний pH, тэжээлийн голлох элементүүдийн агууламжийн судалгаа хийгдсэн.

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлж хөрсний элэгдлийг хувиар гаргасан нь энэ ажлын шинэлэг тал болно.

Тариалангийн талбайн хөрсний үржил шимийн түвшинг тодорхойлсноор, цаашид хөрсний үржил шимийг хамгаалахад авах бодит арга хэмжээнүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй, эдийн засгийн тооцоотойгоор зөв хэрэгжүүлэх, хөрсний элэгдлийг бууруулахад цаашид хийгдэх арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийн үр дүнг үнэлэхэд ач холбогдолтой байх болно.

Судалгааны ажлаар 2015-2016 онуудад Төв аймгийн Жаргалант сумын тариалангийн 3000 гаруй га талбайн хөрсний нийт 150 дээжинд агрохимийн болон механик бүрэлдэхүүний шинжилгээг 10 гаруй үзүүлэлтээр тодорхойлон шинжилгээний дүнг гаргасан.

Дөрөв. Тариалангийн төвийн бүсийн талбайн хөрсний агрохимийн шинжилгээний дүнгээс Хүснэгт 1


№	Талбайн нэршил, өмнөгч	pH	Давс %	ЦДЧ ds/m	CO_2 %	Солилцох суурь мг-экв/100 гр		Ялзмаг %	NO_2 мг/100 г	Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
						Ca	Mg			P_2O_5	K_2O
1	Янзгатын - 286 га, /гуурс/	6.2 сул хүчиллэг	0.02	0.06	-	19.1	9.3	3.5	0.21	4.4	36.0
2	Тээлийн – 170 га, /гуурс/	6.5 сул хүчиллэг	0.02	0.08	-	20.5	9.2	3.2	0.24	3.4	33.5
3	Хар толгойн -148 га /уринш/	6.1 сул хүчиллэг	0.02	0.06	-	16.5	10.0	2.6	0.22	2.1	22.0
4	Хүүхэнтийн -75 га, /уринш/	6.7 сул хүчиллэг	0.02	0.07	-	15.5	4.5	2.3	0.31	2.9	38.0
5	Бөөрийн -62 га, /гуурс/	6.0 сул хүчиллэг	0.01	0.04	-	18.0	10.5	2.3	0.40	2.1	14.0
6	Тээлийн-48 га, /уринш/	6.1 сул хүчиллэг	0.02	0.05	-	17.0	11.0	2.7	0.21	2.0	28.0
7	Тээлийн -46 га, /уринш/	6.2 сул хүчиллэг	0.02	0.05	0.99	11.0	8.0	2.4	0.51	2.5	16.0
8	Тээлийн- 23 га, /уринш/	7.6 сул шүлтлэг	0.04	0.12	-	22.0	9.0	1.9	0.98	2.2	30.0
9	Тээлийн-21 га, /уринш/	6.3 сул хүчиллэг	0.02	0.08	-	25.0	10.0	3.4	0.29	2.5	48.0
10	Тээлийн -20 га, /уринш/	6.5 сул хүчиллэг	0.02	0.06	-	21.0	11.0	3.5	0.19	2.2	32.0
11	Жинтүү толгойн-19 га, /төмс/	6.7 сул хүчиллэг	0.02	0.07	-	18.0	7.0	2.9	0.42	2.2	28.0
12	Тээлийн-18 га, /уринш/	6.5 сул хүчиллэг	0.02	0.05	-	17.0	11.0	2.3	0.24	2.2	46.0
13	Хар толгойн -12 га, /уринш/	6.4 сул хүчиллэг	0.03	0.11	-	16.0	11.0	3.1	0.27	2.2	26.0
14	Хар толгойн-11 га, /уринш/	6.1 сул хүчиллэг	0.02	0.07	-	21.0	11.0	2.7	0.16	2.5	36.0
15	Нурамтын -260 га, /гуурс/	7.7 сул шүлтлэг	0.04	0.11	-	23.0	9.0	1.9	1.06	3.2	10.0
16	Зөөхийн – 214 га, /уринш/	7.0 саармаг	0.09	0.29	-	19.0	8.0	2.6	0.31	1.7	28.0
17	Цант - 79 га, /уринш/	6.5 сул хүчиллэг	0.03	0.10	-	22.0	12.0	3.3	0.96	1.1	14.0
18	Янзагат -75 га, /гуурс/	6.5 сул хүчиллэг	0.02	0.06	-	23.0	10.0	3.2	0.39	1.1	12.0
19	Янзагат -57га, /гуурс /	6.6 сул хүчиллэг	0.03	0.10	-	18.0	10.0	2.2	0.48	2.2	32.0
20	Өлийн ам - 7.3 га /төмс/	6.8 сул хүчиллэг	0.03	0.08		23.0	7.0	3.1	1.23	1.6	24.0
21	Ногооны талбайн - 50 га	7.0 саармаг	0.35	0.11	-	24.0	7.0	3.1	1.15	3.6	19.0
22	Загдалын - 241 –ын 143 га –	7.6 сул шүлтлэг	0.04	0.13	-	21.0	8.0	2.1	0.66	2.6	15.0
23	Зөөхийн-413 –ын 200 –га, /рапс/	7.1 сул шүлтлэг	0.03	0.09	-	16.0	10.0	1.5	0.19	3.0	22.0
24	Сүүл өндөр - 30 га, /уринш/	6.9 сул хүчиллэг	0.04	0.13		22.0	8.0	2.5	0.72	1.5	14.0
25	Жинтүү – 250 га , /уринш/	7.1сул шүлтлэг	0.02	0.06	-	16.0	4.0	1.6	0.76	2.5	12.0
26	Тээлийн-47 га,	7.1 сул	0.05	0.15	-	23.0	7.0	2.9	0.25	2.2	28.0

	/гуурс/	шүлтлэг									
27	Тахилга толгойн - 648 га,/уринш/	6.7 сул хүчиллэг	0.02	0.06	0.49	13.7	3.8	1.9	0.59	1.8	13.4
28	Тахилга толгойн – 648 га, /гуурс/	6.8 сул хүчиллэг	0.01	0.04	-	12.8	6.0	2.1	0.42	2.3	12.0
	Нийт 3019 га					19.0	8.6	2.5	0.49	2.35	24.6


Хөрсний механик бүрэлдэхүүн

	Талбайн нэршил, га	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм							Механик бүрэлдхүүн
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
1	Янзгатын - 286 га, /гуурс/	11.6	36.7	24.3	7.7	7.9	10.8	27.2	Хөнгөн шавранцар
2	Тээлийн – 170 га, /гуурс	3.2	35.6	33.0	7.9	9.2	10.9	28.0	Хөнгөн шавранцар
3	Хар толгойн -148 га /уринш/	4.9	35.7	36.5	8.8	7.8	6.0	22.7	Хөнгөн шавранцар
4	Хүүхэнтийн -75 га, /уринш/	10.1	45.0	25.9	6.1	7.3	5.5	18.9	Элсэнцэр
5	Бөөрийн -62 га, /гуурс/	12.8	41.9	25.9	7.1	6.1	6.0	19.2	Элсэнцэр
6	Тээлийн-48 га, /уринш/	12.1	49.9	21.4	5.2	6.9	4.6	16.6	Элсэнцэр
7	Тээлийн -46 га, /уринш/	4.1	44.7	33.1	5.9	5.8	6.5	18.1	Элсэнцэр
8	Тээлийн- 23 га, /уринш/	3.3	20.2	45.2	10.7	8.4	12.1	31.3	Дунд шавранцар
9	Тээлийн-21 га, /уринш/	0.3	12.2	47.9	10.9	10.8	17.9	39.6	Дунд шавранцар
10	Тээлийн -20 га, /уринш/	2.4	21.5	43.0	9.7	9.0	14.5	33.1	Дунд шавранцар
11	Жинтүү толгойн- 19 га, /төмс/	14.9	41.9	21.6	6.7	7.5	7.4	21.6	Хөнгөн шавранцар
12	Тээлийн-18 га, /уринш/	1.1	30.6	40.0	8.0	8.4	11.9	28.3	Хөнгөн шавранцар
13	Хар толгойн -12 га, /уринш/	4.5	36.1	37.3	5.2	8.2	8.7	22.1	Хөнгөн шавранцар
14	Хар толгойн-11 га, /уринш/	9.6	19.9	46.3	6.8	6.9	10.6	24.3	Хөнгөн шавранцар
15	Нурамтын -260 га, /гуурс/	5.6	48.9	26.0	5.4	6.6	7.5	19.5	Элсэнцэр
16	Зөөхийн -214 /уринш/	9.0	38.3	26.1	7.7	9.0	9.8	26.5	Хөнгөн шавранцар
17	Цантын -79 га, уринш	7.5	36.3	36.4	3.1	6.2	10.6	19.9	Элсэнцэр
18	Янзагат- 75 га, гуурс	9.1	31.8	38.3	4.4	7.1	9.3	20.8	Элсэнцэр
19	Янзагат-57, гуурс	10.9	45.5	18.5	12.7	8.4	4.0	25.1	Хөнгөн шавранцар
20	Өлийн ам-7.3	0.6	22.1	41.3	10.9	12.8	12.3	35.9	Дунд шавранцар
21	Ногооны талбайн - 50 га	1.4	57.2	15.0	4.9	10.1	12.0	27.0	Хөнгөн шавранцар
22	Загдалын - 241 –ын 143 га – гуурс	9.2	39.7	32.1	3.6	8.8	6.4	18.8	Элсэнцэр

Хөрсний механик бүрэлдэхүүн



Хөрсний агрохимийн үзүүлэлтийн харьцуулалт /2009, 2016 он/



Дүгнэлт

Хөрсний агрохимийн шинжилгээг Төв аймгийн Жаргалант сумын хуучин нэрээр 4,11,12 дугаар бригадын Тээл, Загдал, Зөөхий орчмын 3019 га талбайд батлагдсан стандарт аргаар хийж гүйцэтгээд дараах дүгнэлтүүдийг гаргаж байна.

1. Хөрсний урвалын орчинг усан иономерийн аргаар тодорхойлоход нийт талбайн 60.7 % нь сул хүчиллэг, 30.6 % нь сул шүлтлэг, 8.7 % нь саармаг орчинтой байна.

2. Хөрсний үржил шимийн гол үзүүлэлт болох ялзмагийн агууламжийг Тюрингийн аргаар тодорхойлоход нийт талбайн дундаж ялзмаг 2.15 % буюу хамгийн бага үзүүлэлт Зөөхийн 413 –ын 143 талбайн ялзмагийн агууламж 1.5 % ба маш бага байгаа нь талбайн үржил шимийн үзүүлэлт хангалтгүй болсныг харуулсан.

3. Хөрсний шим тэжээлийн бодисын гол элемент болох азотын агууламжийг спектрофотометрийн аргаар тодорхойлоход 0.49 мг/100 гр буюу 2009 оны үзүүлэлттэй харьцуулахад 1.81 мг- аар багасаж, нийт шинжилгээнд хамрагдсан талбайн 70.6% хялбар ашиглагдах азотын агууламжийн бүлэглэлээр маш бага гэсэн ангилалд багтаж байна.

4. Буудайн хооллолтын гол элемент болох фосфорын агууламжийг Мачигины аргаар тодорхойлоход 2.35 мг/100 гр буюу 2009 оны шинжилгээний дүнтэй харьцуулахад 0,9 мг/100 –аар багассан дүн гарсан ба энэ хөрсний фосфорын агууламжийн бүлэглэлээр маш бага гэсэн ангилалд багтаж байна .

5. Мөн хөрсний хөдөлгөөнт калийн агууламжийг дөлийн фотометрийн аргаар тодорхойлоход 24 мг/100 гр байсан нь хөрсний солилцох калийн агууламжийн бүлэглэлээр бага гэсэн ангилалд орсон.

6. Солилцох сууриудийг комплексметрийн аргаар, мг-экв/100гр тодорхойлоход кальци 19.0 мг/100 гр, магни 8.6 мг/100 гр байгаа нь агууламжийн бүлэглэлээр хангалттай гэсэн ангилалд багтаж байна.

7. Хөрсөнд агуулагдаж байгаа физик шаврын агууламжийг Качинскийн аргаар тодорхойлоход нийт талбайн 34.2 % нь хөнгөн шавранцар, 2.3% нь дунд шавранцар, 63.4% нь элсэнцэр гэсэн ангилалд багтсан.

Зөвлөмж

1. Нийт шинжилгээнд хамрагдсан хөрсний 60.7 % нь хүчиллэг болон сул хүчиллэг байгаа нь тариалангийн талбайн ихэнх хэсэгт хүчиллэг шинж чанарыг саармагжуулах, ингэснээр pH – ийн утгыг аажим ихэсгэх, шохойжуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

2. Хөрсний үржил шимийн гол үзүүлэлт болох ялзмагийн агууламжийг нэмэгдүүлэхийн тулд тариалангийн сэлгээнд ногоон бордоот уриншийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, органик бордоогоор бордох.

3. Хөрсний азотын агууламжийг нэмэгдүүлэхийн тулд ээлжлэн тариалалтын сэлгээнд буурцагт ургамлыг заавал оруулах.

4. Хөрсний фосфорын агууламжийн бууралт хөрсний элэгдэл эвдрэлтэй шууд холбоотой байдаг тул хөрс боловсруулалтын тоог цөөрүүлж хөрс элдэншүүлэлтийн цомхотгосон технологид шилжих.

5. Шинжилгээнд хамрагдсан нийт талбайн 63.4 % нь элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байгаа нь энэ бүс нутагт хөрсний салхины элэгдэл нэлээд эрчимтэй явагдаж байгаа харуулж байна. Иймд үүсэж буй нөхцөл байдалд зохицуулан технологио өөрчилж зурвасласан тариалангийн технологид шилжих цаг хугацаа болсныг харуулж байна.

АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ БА АХИЦ ДЭВШИЛ

Дэслэгч Ж.Серикжан
Гамшгаас хамгаалах албаны тэнхмийн багш

Хураангуй: Энэхүү илтгэлд Монгол Улс ба БНСУ-ын аврагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцооны өнөөгийн байдал, тэдний боловсролын болон албан тушаалын ахиц дэвшлийн талаар харьцуулсан судалгаа хийж цаашид боловсронгуй болгох талаар өөрийн санал, дүгнэлтээ дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Түлхүүр үг: Ахлагч, сургалт, мэргэжлийн зэрэг

Оршил

Манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, объектын болон ой хээрийн түймэр, цөлжилт, хэт халалт, хүйтрэлт зэрэг байгалийн гамшгаас гадна хүн, мал амьтны гоц халдварт өвчин, хортон шавьжны тархалт, үйлдвэр, тээврийн хэрэгслийн осол, цацраг идэвхт хордолт, химийн хорт бодисын алдагдал зэргээс хүний амь нас эрсдэх, улс орон нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчинд ихээхэн хохирол учирсаар байна. Түүгээр ч үл барам зарим урьд өмнө гарч байгаагүй шинэ төрлийн өвчин үүсэн бий болж, гамшиг, ослын аюул занал шинэ төрөл, хэлбэрээр үүсэх нөхцөл бий боллоо. Энэ байдлын улмаас гамшгийн аюулын хэмжээ, тоо давтамж өсч, чиг хандлага өөрчлөгдөж байгаатай уялдан Онцгой байдлын байгууллагын болон аврах ангийн үүрэг, үйл ажиллагааг өргөжүүлэх бодит шаардлага бий болж байна.

Сүүлийн жилүүдэд гамшгаас хамгаалах, гамшгийн аюулыг бууруулах талаар нэлээдгүй арга хэмжээнүүдийг авч байгаа боловч гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэл, эмзэг байдлыг бууруулах үйл ажиллагаа хангалтгүй, хууль эрх зүйн орчин боловсронгуй бус, мэргэжлийн хүний нөөцийн хангамж, чадавх дутагдалтай, гамшгийн аюулаас иргэдийг аврах, орчин үеийн техник зэвсэглэмж хүрэлцээгүй, санхүүжилт нь хангалтгүй, төв, орон нутгийн засаг захиргааны удирдлага гамшгаас хамгаалах менежментэд, иргэд аюулгүй амьдрах арга ухаанд сайн сургагдаагүй байна.

Мөн манай улсад гамшгийн аюулыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг улс орныхоо хэрэгцээ шаардлагад нийцүүлэн олон улсын жишигт нийцүүлж шинэчлэн үндэсний чадавхыг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Бас нэг дутагдалтай зүйл нь сайтар бэлтгэгдээгүй албан хаагч, хүмүүс, хэсэг, бүлэг нь тухайлбал гамшгийн аюулын үед үүргээ зохих журмын дагуу гүйцэтгэж чадахгүй байна.

Олон улсын туршлагаас үзвэл, гамшиг осол тохиолдсон эхний үед эрэн хайх, авран туслах багийн бүрэлдэхүүн очихоос өмнө орон нутгийн иргэд нь нэрвэгдэгсдийн 30 орчим хувийг буюу гамшигт багаахан гэмтэл авсан, хөнгөн нэрвэгдэгсдийг аврах үйл ажиллагааг гүйцэтгэсэн байдаг ба харин үлдсэн хэсгийг буюу нурангийн гүнд дарагдсан болон мэргэжлийн бүлгийг туслалцаа

шаардлагатай иргэдийг тусгай хүчжүүлсэн мэргэжлийн бүрэлдэхүүн гүйцэтгэдэг болох нь тогтоогдсон юм. Ийм учраас гамшгийн үед ажиллах мэргэжлийн аврагч нарыг өндөр түвшинд бэлтгэх нь чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн байдал:Шинэ зууны гамшгаас хамгаалах гол арга бол урьдчилан сэргийлэх явдал бөгөөд аврах арга хэмжээг аль болох шуурхай гүйцэтгэх шаардлага тавигдаж байна. Энэ ажлыг юуны өмнө аврагч нар гүйцэтгэдэг.

Ахлагч гэдэг бол мэргэжлийн зохих бэлтгэлийг хангасан эрэн хайх, аврах ажлыг гүйцэтгэгч албан тушаалтан билээ. Өөрийн амь биеийг золиослон байж, иргэдийн амь насыг аврахад суралцдаг явдал бол хүнд хөдөлмөрийн нэг гэж дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг.

Тийм ч учраас дэлхийн хамгийн хүнд 5 мэргэжилд аврагч гал сөнөөгч нарыг оруулсан юм.

Одоогийн байдлаар Онцгой байдлын албаны хэмжээнд 2000 гаруй ахлагч ажиллаж байгаагаас аврагч гал сөнөөгч 52,1%, жолооч техникч 33,1%, төрөл мэргэжлийн аврагч 24,9% эзэлж байна.[29] БХИС-ийн Ахлагчийн сургуульд 1996 оноос эхлэн гамшгаас хамгаалах төрөл мэргэжлийн гал сөнөөгч-шүхэрчин, холбоочин, усчин аврагч, химичин, инженерийн аврагч нарыг бэлтгэж, мөн Цагдаагийн академид аврагч гал сөнөөгч нарыг бэлтгэж ирсэн.

Одоо ХСИС-ийн Ахлагчийн сургуульд 3-4 сарын хугацаатайгаар мэргэжлийн аврагч бэлтгэж байна. Мөн ОБЕГ-ын Давтан сургалтын төвд аврагч нарыг мэргэшлийн байдлаар давтан сургалтыг зохион байгуулж, мөн БНСУ, ОХУ, Хятад улсуудад зарим чиглэлээр аврагч нарыг төрөл бүрийн мэргэшүүлэх сургалтад хамруулдаг байна.

Аврах тусгай ангийн ахлагч нарын боловсролын байдлыг авч үзвэл, бакалавр 17, дипломын 16, Ахлагчийн сургууль төгссөн 30, бүрэн дунд боловсролтой 77, бүрэн бус дунд боловсролтой 3 байна[30]. Энэ байдлаас үзвэл, цаашид 55,9% нь мэргэжлийн сургуульд суралцаж боловсрол эзэмших шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Мөн өнөөдрийн цаг үед ахлагч нарт тулгамдаж буй асуудлууд нь дараах үндэслэлүүдээр тайлбарлагдаж байна. Үүнд:

1. Онцгой байдлын албаны нийт бие бүрэлдэхүүний 70 гаруй хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байгаа.
2. Ахлагч нар тухайн байгууллагын албаны үйл ажиллагааны гол гүйцэтгэгч нар байдаг бөгөөд ажлын ачаалал их байдаг.
3. Ажлаас өөрийн хүсэлтээр болон захиргааны санаачлагаар халагдагсдын дунд ахлагч нарын эзлэх хувь өндөр байгаа.
4. Ахлагчаас цааш хөгжих боломж бага, өөрөөр хэлбэл ахлагчаараа л карьераа дуусгана гэж боддог ахлагчдын тоо их байгаа зэрэг нь хамгийн ноцтой шалтгаанууд

[29]"Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд"., ЭШБХ-ын эмхтгэл., 2014. УБ. Х-66

[30]Мөн тэнд. Х-67

бөгөөд эдгээр нь тухайн байгууллагын албаны үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй байх нь тодорхой юм.

Иймээс

- Яагаад ахлагч нар өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх шаардлага үгүй гэж?...
- Яагаад тэд насан турш бага мэргэжилтэн байх ёстой гэж?...
- Тэд дээд боловсрол эзэмшиж албан тушаал ахих боломж байхгүй гэж?..гэсэн олон асуулт урган гарч хариулт хүлээсээр байна.

Дээрх асуултуудад тулгуурлан судлаач миний бие БНСУ-ын аврагч, гал сөнөөгч нарын эрх зүйн орчин ямар байдаг талаар судалж үзлээ.

Мэргэшүүлэх сургалтыг боловсронгуй болгох нь: Гамшиг, ослын аюулаас иргэдэд хамгаалах гол арга, хэлбэр бол аврагч нарын болон иргэдийг аврах үйл ажиллагаанд сургасан байх явдал юм.

Чухам юунд сургах ёстойг аврах ажиллагаанд оролцсон туршлага сургамжаар тодотгож, аврагчдын сургалтын онол, практик тодорхойлж өгдөг. Тийм учраас аврагч нарын үндсэн хөдөлмөр бол аврах ажиллагаанд суралцах явдал гэж томьёолж болно.

Мөн аврах ажиллагааны хэрэгсэл боловсронгуй болохын хэрээр түүнийг эзэмших, ашиглаж сурах ажиллагаанд практик дадлагаас гадна онол арга зүйн мэдлэг, ур чадварын ач холбогдол чухлаар шаардагдах боллоо. Чухамхүү аврах үйл ажиллагааны сургалтын онол, практикийн нэгдлийг хангах нь аврагчдын чадварыг дээшлүүлэх чухал хэлбэр болон хувирч байна.

Судлаач миний бие БНСУ-ын аврагч, гал сөнөөгч нарын талаар хийсэн судалгаанаас хэдэн жишээ дурдъя.

- БНСУ-ын Онцгой байдлын албанд анх элсэн орохдоо элсэхийг хүсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлээр дипломын болон түүнээс дээш зэрэгтэй байна гэсэн шаардлага тавьдаг байна. Мөн тус шаардлагыг хангасан иргэдээс төрийн жинхэнэ албаны шалгалт гэж авдаг ба төрийн жинхэнэ албаны шалгалт нь 9 дүгээр зэргийн төрийн жинхэнэ албан хаагч гэсэн шатлалаас /ихээс бага руу/ 1 дүгээр зэргийн төрийн жинхэнэ албан хаагч гэсэн зэрэгтэй байдаг. Онцгой байдлын албанд гал сөнөөгч, аврагчаар орохын тулд 9 зэргийн жинхэнэ албан хаагчийн шалгалтад тэнцсэн байх ёстой юм[31].

Эндээс дүгнэж үзвэл, манай улстай харьцуулахад бүх аврагч, гал сөнөөгч нар нь мэргэжлийн дагуу дипломын буюу түүнээс дээш боловсролтой байдаг байна. Энэ нь аврагч, гал сөнөөгч нарын мэдлэг, боловсролын түвшинг харуулж байгаа ба нөгөө талаасаа гамшиг, ослын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг илүү үр дүнтэй гүйцэтгэх баталгаа болж байгаа юм.

- Мөн анх аврагч, гал сөнөөгч албан тушаалд томилогдсон алба хаагч эхний 6-8 сар тухайн мэргэжлээр 10 дээш жил ажилласан албан хаагчийн удирдлагын доор зөвхөн

[31]"Fire-related laws of korea" 2016. South korea. p.-187

дадлагажигчаар ажиллуулдаг ба үндсэн цалингийн 80 хувьтай тэнцэх хэмжээний цалин авдаг байна[32]. Энэ нь илүү дадлага туршлагатай болгох зорилготой юм.

Тэгвэл манай улсад Ахлагчийн сургуульд сурч байгаа хугацаандаа онцгой байдлын анги салбаруудад богино хугацааны дадлага гүйцэтгэж, төгсөөд зарим нь шууд үндсэн ажилдаа ордог нь бодлогын хувьд алдаатай байна гэж үзэж цаашид шинээр ажилд орсон аврагч нарыг хамгийн багатай 3 сар дадлагажигчаар ажиллуулж бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлтэй болгох шаардлага гарч байна.

- БНСУ-д Аврагч, гал сөнөөгч нар анх томилогдсон албан тушаалдаа 1 жил ажилласны дараа албан тушаал ахих, өөр орон нутагруу шилжих боломжтой болдог байна. Гэхдээ албан тушаал ахихын тулд тухайн албан тушаалын зэрэглэлийн дагуу тогтоосон тусгай шалгалт байдаг ба тус шалгалтад заавал тэнцсэн байх шаардлагатай тавьдаг. Тус шалгалт нь онолын, ур чадварын гэсэн 2 үе шаттай явагддаг юм[33]. Эндээс дүгнэж үзвэл, аврагч, гал сөнөөгч нар нь нэг албан албан тушаалдаа байнга ажиллах бус мэдлэгтэй, ур чадвартай бол албан тушаал дэвших бүрэн боломжтой нь харагдаж байна.
- Мөн бүсүүдэд албан хаагч нарын мэргэжил дээшлүүлэх төв гэж байдаг ба тус төвд тусгай хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж дипломын мэргэжилтэй албан хаагч бакалаврын зэрэгтэй болж болдог байна.

Манай улсын хувьд авч үзвэл ахлагч нарын бараг 80 гаруй хувь нь тус албан тушаалдаа насаараа ажилладаг ба цөөхөн хэдэн албан хаагч боловсролоо дээшлүүлж байж, албан тушаал ахидаг байна. Мэдээж боловсорлоо дээшлүүлэхийн тулд ХСИС-ийн Онцгой байдлын сургууль болон бусад их дээд сургуулиудад 3-5 жилийн хугацаатай суралцдаг юм. Цаашид энэ байдлыг тусгайлан анхааран үзэж ахлагч бүрэлдэхүүнийг дээд боловсролтой болгох асуудлыг хөнгөлж өгөх шаардлагатай байна. Жишээлбэл БНСУ-д тухайн албан хаагчийн ажлын туршлагаас хамаарч суралцах хугацааг нь тогтоодог. Үүнд мэргэжлийн дагуу 5-аас дээш жил ажилласан бол их дээд сургуулиудад 4 жил, 10 дээш жил ажилласан бол 3 жил суралцдаг гэх мэт.

- Мөн БНСУ-д аврагчдад мэргэжлийн зэрэг олгодог ба 1, 2, 3 гэсэн мэргэжлийн зэргээс шалтгаалж цалингийн нэмэгдэл авдаг байна. Жишээлбэл БНСУ-ын ерөнхийлөгчийн баталсан хэд хэдэн гэрчилгээ /сертификат/ байдаг байна. Үүнд:

- Эмнэлгийн анхны тусламжийн 1, 2 дугаар зэрэгтэй
- Галын аюулгүй байдал хариуцагч 1, 2, 3 дугаар зэрэгтэй
- Галын тоног төхөөрөмжийн инженерийн 1. 2 дугаар зэрэгтэй /Fire Mechanical Professional Engineers/
- Галын дохиоллын инженерийн 1, 2 дугаар зэрэгтэй /Fire Electrical Professional Engineer/

[32]"Fire-related laws of korea" 2016. South korea. p.-198

[33]"Fire-related laws of korea" 2016. South korea. p.-204

- Барилгын галын аюулгүй байдлын инженерийн 1, 2 дугаар зэрэгтэй / Fire Professional Engineer Building/

Дээрх гэрчилгээг албан хаагч нар өөрсдөө бэлдэж онолын мэдлэг, биеээр хийж гүйцэтгэх /ур чадвар/ гэсэн 2 төрлөөр өгч тэнцсэн тохиолддог гэрчилгээ авдаг ба тэнцсэн албан хаагч нар цалингийн нэмэгдэл авах, тэтгэвэрт гарсны дараа бусад аж ахуйн нэгж байгууллагад ажиллах бүрэн боломжтой болдог байна. Энэ нь өөрийн мэргэжлийн мэдлэг чадвараа нэмэгдүүлэх бас нэг боломж болж байгаа юм.

Манай улсын хувьд мэргэшсэн инженер, зөвлөх инженерийн гэрчилгээ гэж өгдөг боловч заавал тухайн хүний боловсролын зэрэг, ажилласан жил зэргийг харж үздэг юм. Иймээс цаашид БНСУ-ын жишээг дагаж мэргэжлийн зэрэгтэй болгох, боловсролын түвшин шаардахгүйгээр шалгалтад оруулдаг болгох, шалгалтад тэнцсэн хүнд тус гэрчилгээг олгох ажлыг судлан үзэж шийдвэрлүүлж өгвөл ахлагч бүрэлдэхүүний нийгмийн асуудалд тус нэмэр болно гэж үзэж байна.

- БНСУ-д аврагч нар 15 удаа өдрийн ээлж, 15 удаа шөнийн ээлж гэсэн тогтолцоогоор ажилладаг ба 7 хоногт 2 удаа онолын хичээлд 2 удаа дадлагын хичээлд заавал хамрагддаг байна. Мөн тус улсын их дээд сургуулиудад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийн дагуу аврагч нар жилд 5-12 кредитийн хичээл судалдаг төлөвлөгөөтэй байдаг бол тухайн аврагч 40 кредит судалсан тохиолдолд мэргэжлийн дагуу их дээд сургуулиудын 3 дугаар курсээс үргэлжлүүлэн суралцах боломжтой болдог байна.

Энэ тогтолцоог бас манай улсын аврагч нарын сургалтад ашиглавал, аврагч нарын боловсролын түвшин, мэдлэг чадварыг дээшлүүлэх бүрэн боломжтой болно гэж үзэж байна.

Эндээс дүгнэвэл ахлагч бүрэлдэхүүний үүрэг оролцоо албаны үйл ажиллагаанд маш чухал бөгөөд энэ нь ахлагчийн мэдлэг, ур чадвар, хандлага, тэдний амьдралын нөхцөл бололцоог сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байгаа юм.

Ахлагч нарын сургалт, хөгжил, ахиц дэвшлийн асуудал нь тэдний дараа дараагийн цол, албан тушаалтай холбоотой учраас тодорхой зааг ялгаа, ангилалтай байх нь илүү үр дүнтэй бөгөөд чухал юм. Өөрөөр хэлбэл өрсөлдөөн бий болгох замаар ахлагч нарыг дараагийн шатны сургалтад хамруулж, цол, албан тушаалын ахиц дэвшлийг бий болгож, мэдлэг, ур чадвар, хандлагыг өөрчлөх боломжтой.

Санал, дүгнэлт

Онцгой байдлын албаны нийт 4000 орчим албан хаагчийн 3349 нь төрийн тусгай албан хаагч бөгөөд тэдгээрийн 70 гаруй хувийг ахлагч бүрэлдэхүүн бүрдүүлдэг. Энэ нь тус албаны үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд ахлагч бүрэлдэхүүний үүрэг, оролцоо нэн чухал гэдэгтэй хэн ч маргахгүй. Иймд цаашид аврагч нарыг чадваржуулах ажлыг шат дараатай зохион байгуулах хэрэгцээ, шаардлага зайлшгүй хэрэгтэй байгааг дээрх

судалгааны үр дүн тодорхой харуулж байна.

Иймээс аврагч нарыг чадваржуулах талаар дараах саналыг дэвшүүлж байна. Үүний тулд:

1. Ахлагч бүрэлдэхүүний хийж гүйцэтгэж байгаа албан тушаалуудыг дэвших замналаар ангилж, тодорхой сургалтад хамрагдсанаар тэдгээр дээр шат дараалан ажилладаг тогтолцоо бий болгох;
2. Олон жил ажилласан, зохих түвшний мэргэжлийн мэдлэг, боловсрол эзэмшсэн, туршлагатай ахлагч нарыг офицер болгон дээшлүүлдэг байдлыг хүний нөөцийн бодлоготой уялдуулж нэмэгдүүлэх;
3. Олон улсын туршлагыг судалж, олон улсын стандартыг хангасан ахлагч бүрэлдэхүүний сургалтын тогтолцоог шинээр бий болгох;
4. Онцгой байдлын сургуулийг түшиглэн аврагч нарыг мэргэшүүлэх, давтан сургах талаар сургалтын хөтөлбөр шинээр боловсруулах;
5. Мөн аврагч нарыг сургах багшлах бүрэлдэхүүнийг тусгайлан бэлтгэх, удаан жил аврагчаар ажилласан албан хаагч нараас багш бүрэлдэхүүнд түлхүү оролцуулах;
6. Аврагч нарыг гадаадын орнуудад давтан бэлтгэх сургалтад байнга оролцуулах, тэдний гадаад хэлний мэдлэгтэй болгох;
7. Олон улсын болон улсын хэмжээнд зохион байгуулдаг хээрийн сургалт, команд штабын сургалтанд ахлагч бүрэлдэхүүнийг түлхүү оролцуулах;
8. Аврагч нарыг мэргэшүүлэх, дээд боловсролтой болгох асуудлыг удирдлагын түвшинд авч үзэж ахлагч бүрэлдэхүүнд тулгамдаж байгаа асуудлыг судлан үзэж, гадаад дотоодын их, дээд сургуулиудад суралцуулах асуудлыг одоогийн байгаа байдлаас арай хөнгөвчлөх шаардлагатай байна.

Эдгээр саналуудыг ажил болгон хэрэгжүүлснээр Онцгой байдлын албаны ахлагч бүрэлдэхүүний өрсөлдөн бий болж тэдний идэвх санаачлага, мэдлэг, ур чадвар, хандлага, сайжирч тэр хэмжээгээр ажлын хариуцлага, албан тушаал өөрчлөгдөж, тэдний нийгмийн баталгаа ч сайжрах үндэслэлтэй гэж үзэж байна.

Ном зүй

1. Онцгой байдлын байгууллагад алба хаах журам. УБ.2012 он.
2. ХСИС-ийн "Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд" ЭШБХ-ын эмхтгэл.УБ. 2014 он.
3. ХСИС-ийн "Хууль сахиулах үйл ажиллагаанд ахлагч бүрэлдэхүүний үүрэг, оролцоо, тулгамдсан асуудал" ЭШБХ-ын эмхтгэл. УБ.2016 он.
4. "Fire-related laws of korea" 2016. South Korea.
5. https://www.mpss.go.kr/home/policy/law/0001/
6. http://www.safekorea.go.kr/idsiSFK/index.jsp

ЗАЛУУ СУДЛААЧ

ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГИЙГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ОЛГОХ СУРГАЛТЫН ОНЦЛОГ

хошууч М.Батмөнх
ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн 821-р дамжааны суралцагч, магистрант

Хураангуй. Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтын онцлогийг авч үзэв. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтын онолын үндэслэлийг тодорхойлох зорилгоор онолын бүтээл, эх зохиол судлаж шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнд гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох удирдлага, зохион байгуулалтын хүрээнд анхаарч авч үзэх зарим асуудал, тэдний онцлогт тохирсон сургалтын ямар боловсронгуй болгох арга, зам байж болох саналуудыг дэвшүүллээ.

Түлхүүр үг. Гамшгаас хамгаалах, хөгжлийн бэрхшээл, сургалт

Удиртгал

Дэлхийн нийтээр болзошгүй гамшгийн эрсдэлээс бүс нутаг, улс орны ард иргэдийг урьдчилан сэргийлэхэд анхаарч, дэлхийн бага хурал, бүс нутгийн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, тэдгээрийг дагаж мөрдөх тунхаг, бодлогын баримт бичгүүдийг гаргаж, гамшгийн эрсдэлийг бууруулах уриалга дэвшүүлэн улс орон бүр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2005 онд Япон Улсын Хёого хотноо зохион байгуулсан Дэлхийн бага хурлаас гаргасан "2005-2015 онд улс үндэстэн орон нутгийн гамшгийг даван туулах чадавхийг бэхжүүлэх Хёогогийн үйл ажиллагааны хүрээ"-ний тунхаг бичигт "... орон нутгийн ард иргэдийн эрсдэлийн үнэлгээг хийх, бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, эрт зарлан мэдээллэх, гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, мэдээлэл сурталчилгаанд өргөн хүрээтэй хамруулах[34] гэж заасан бөгөөд мөн тус байгууллагаас 2015 онд Япон Улсын Сендай хотноо зохион байгуулсан Дэлхийн бага хурлаас гаргасан "2015-2030 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичигт "Гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх, гамшгийн эрсдэлийг удирдах засаглал болон бэлэн байдлын чадавхийг бэхжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах" үйл ажиллагааг үндсэн чиглэл болгон тусгаж, гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах зорилтод хүрэхийн тулд үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, эргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг хамарсан гамшгийн

[34] "2005-2015 онд улс үндэстэн орон нутгийн гамшгийг даван туулах чадавхийг бэхжүүлэх Хёогогийн үйл ажиллагааны хүрээ"-ний тунхаг бичиг. 2005.

эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг албан болон албан бус боловсрол, бүх түвшний иргэний боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтанд тусгах ажлыг дэмжихээр тусгасан байна.[35]

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн зорилтод гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах, сургалт, сурталчилгааны агуулга, хэлбэр нь олон нийт болон нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн, шат дараалсан, үр дүнтэй байх зарчмыг баримтална гээд энэхүү зорилтын хүрээнд:

-гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг олон нийтэд олгох, эрсдэлгүй зан үйлийг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг иргэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан, амжиргааны түвшин доогуур орлоготой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тохирсон арга барилаар зохион байгуулах:

-олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, хүүхэд, сайн дурынхан, залуучуудад зориулсан ном, гарын авлага, заавар, сэрэмжлүүлэг, дүрс бичлэгийн богино хэмжээний кино хийх, үзүүлэн таниулах болон тараах материал бэлтгэж нийтэд түгээх:

-олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, сурталчилгааны чиглэлээр үндэсний болон олон улсын байгууллагатай түншлэл, хамтын ажиллагааг бүх түвшинд өргөжүүлж, гадаад орнуудтай туршлага солилцох, нэвтрүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй амьдрах ухааны боловсрол, хүмүүжил олгох хичээлийг сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах, сургалтыг хүүхдийн насны онцлогт тохируулан явуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх"-ээр тус тус тодорхойлжээ[36].

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал нь нийгмийн халамж, хамгааллын асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд нийт хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын төвд байх ёстой чухал асуудал юм.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд аюул үзэгдэл, осол тохиолдсон үед авран туслах, бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлын хангуулахад анхаарч, тэдний онцлогт тохирсон сургалт, сурталчилгааг зохион явуулах зүй ёсны шаардлага харагдаж байна.

Судалгааны ажлын зорилго нь гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд анхаарч авч үзэх асуудал, тэдэнд тохирсон сургалтын ямар аргууд байж болохыг тодорхойлоход оршино.

---

[35] "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичиг.2015.

[36] "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр".УБ.,2015.

Судалгааны материал, арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтын онолын үндэслэлийг тодорхойлсон бүтээл, эх зохиол, баримт бичиг, статистик мэдээ зэргийг ашиглаж, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын онолын үндэслэлийг тодорхойлох зорилгоор онолын бүтээл, эх зохиол судлах, жиших, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг судалгааны аргуудыг хэрэглэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдал

Ойролцоогоор дэлхийн хүн амын 15% буюу хүн 1 тэрбум гаруй нь аливаа нэг хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй гэсэн судалгаа гарсан бөгөөд үүнээс Ази болон Номхон Далайн бүс нутагт 650 сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаагаас 80% нь хөгжиж буй орнуудад[37], Европод 39 сая хүн амьдарч байна.[38]

Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гамшгийн нөлөөнд харилцан адилгүй өртөж байгаа бөгөөд сүүлийн 30 жилд тус бүс нутаг хэд хэдэн томоохон гамшигт нэрвэгдсэн[39]. 2005-2015 оны байдлаар гамшгийн улмаас нийтдээ 700 гаруй мянган хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн гэмтэж бэртэн, 23 орчим сая хүн орон гэргүй болж, 1.5 тэрбум хүн гамшигт ямар нэг байдлаар нэрвэгджээ. Эмэгтэйчүүд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэд (харилцан адилгүй) өртсөн ба нийт учруулсан хохирлын хэмжээ нь 1.3 их наяд ам доллар болж, 2008-2012 онд 144 сая хүн гамшгийн улмаас нүүн шилжсэн байна.[40] Зөвхөн Их Зүүн Японы (Ивате, Мияги, Фукушима муж) газар хөдлөлтөд нийт 1,674,185 хөгжлийн бэрхшээлтэй хүн өртөж, үүнээс 18,829 хүн нас барсан байна.[41]

Манай улсад аюулт үзэгдэл, ослын улмаас хичнээн хүн хөгжлийн бэрхшээлтэй болсон, өртөж, гэмтсэн талаар албан ёсны тоо, баримт тодорхой бус байна. ОБЕГ-ын хугацаат мэдээ, тайлан гаргаж ирүүлэх, нэгтгэх, дүгнэх журмын дагуу явуулдаг аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын мэдээний маягт-ГМ-1-ээс ГМ-16, бусад ослын тохиолдлын мэдээний маягт-ГМ-19, гал түймрийн хэрэг зөрчлийн мэдээний маягт ГМ-17.1, маягт-ГМ-17.2, Ой,хээрийн түймэр гарсан тухай маягт-ГМ-17.3, Аюулт үзэгдэл, ослын хохирлын нэгдсэн мэдээний маягт-ГМ-18 мэдээний хүснэгтэд тодорхой тусгаагүй орхижээ.

Монгол Улсад Хөгжлийн бэрхшээлийн холбоотой асуултууд хүн амын тооллогод 2010 онд анх багтсан ба үүнээс өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх статистик мэдээ нь ялгаатай арга зүйгээр цуглуулсан мэдээлэлд үндэслэж байжээ. Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор суурин хүн амын 4.1 хувь нь буюу 108071 хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүртгэгджээ[42].

[37] "Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага, Дэлхийн Банк, Хөгжлийн бэрхшээлийн тухай" дэлхийн тайлан. Женев., ДЭМБ.2011. 29-р тал.


[38] CSR, Европ, АНУ, https://www.st-andrews.ac.uk/hr/edi/disability/facts/

[39] Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан "Эрхийг нь бодитой болгох" Инчоны Стратеги.2012.14-р тал.

[40] "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сэндайгийн үйл ажиллагааны хүрээ" баримт бичиг.2015.4-р тал.


[41] http://www.isad.or.jp/cgi-bin/

[42] "Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллого".УБ.,2010.



Зураг.1. Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо[43]

Дээрхи үзүүлэлтээр Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2015 онд 101073 болж, өмнөх оныхоос 1500 хүн буюу 1.43 хувиар өссөн байна.




Зураг.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийт хүн амд эзлэх харьцаа

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2015 онд 10.4 мянга болж, өмнөх оныхоос 958 хүүхэд буюу 8.4 хувиар буурч, нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 10.2 хувийг эзэлж, үүнээс 72.3 хувь нь төрөлхийн, 27.7 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна гэсэн судалгаа гарчээ.[44]

[43] Статистикийн эмхэтгэлүүд., 2008- 2015.

[44] Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал.,(2015 оны жилийн эцсийн байдлаар) Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар.



Зураг.3. Хөгжлийн бэрхшээлийн төрөл, шалтгаан[45]

Дээрх судалгаанаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 16.0 хувь нь зам тээврийн осол, ахуйн осол, үйлдвэрлэлийн ослоос хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтын онцлог.

Юуны өмнө хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэсэн ойлголтоос эхэлье. 1975 онд НҮБ-аас батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглалд хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн ойлголтыг анх боловсруулжээ. Тунхаглалын нэгдүгээр зүйлд зааснаар "Бие бялдарын буюу сэтгэл санааны чадавх нь төрөлхийн буюу олдмол шалтгаанаар дутмаг болсны улмаас хувийн болон нийгмийн амьдралын шаардлагыг бие даан хангаж чадахгүй байгаа аливаа этгээдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж хэлнэ"[46] гэж, Харин Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд "хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг"[47] гэж тодорхойлсан байна. Энэ тодорхойлолт биологийн хүчин зүйлүүдийг авч үзсэнээс гадна нийгмийн хүчин зүйлүүдийг авч үзжээ.

[45] Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал.,(2015 оны жилийн эцсийн байдлаар) Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар.
[46] "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал", НҮБ.,1975.
[47] "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль". УБ.,2016.

1862 онд эмч Жон Лангдон өвчтөнийх нь дунд биеийн гаднах төрх байдал, өвчний онцлог, оюуны хөгжлийн бэрхшээлээрээ адилхан хүмүүс байгааг анзаарчээ. Тэрээр эдгээр өвчтөнүүд тодорхой нэгэн эмгэгтэй байна гэсэн шийдэлд хүрч, эмгэг гэдгийг тухайн өвчнийг тодорхойлдог нийтлэг шалтгаантай онцлог байдал, шинж тэмдгүүдийн бүрдэл гэж[48] анагаах ухааны талаас тодорхойлсон байна.

Хөгжлийн бэрхшээлийг дотор нь тархины саажилт, аутизм, дауны хам шинж, сурах эмгэг, анхаарлын хомсдол, харааны бэрхшээл сонсголын бэрхшээл, хэл ярианы бэрхшээл гэж[49] ангилдаг ба тэдэнд боловсрол эзэмшихэд нөлөөлдөг хүндрэл бэрхшээлүүд янз бүр байх бөгөөд 1-р хүснэгтэд үзүүлсэн байдлаар ангилжээ.[50]

Дээр дурьдсан хүндрэлүүдээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмшүүлэхэд нөлөөлдөг хүндрэл бэрхшээлүүд дотроо маш олон төрөлтэй байна. Энэ удаа зөвхөн сонсгол болон харааны бэрхшээлтэй иргэдийн сургалтын онцлогыг сонгож судлав.

Харааны бэрхшээл: Ямар нэгэн өвчний уршгаар, сэтгэл хөөрөл буюу шоконд орсны улмаас мөн төрөх үеийн хүндрэл зэрэг нь хараанд нөлөөлдөг байна. Яагаад энэ бүхнийг ярьж байна вэ гэхээр өөрт хэрэгтэй туслах технологийг сонгохдоо харааны бэрхшээлийн зэргээс шалтгаалж өөр өөр байдаг. Жишээ нь бүрэн хараагүй болсон хүнд илүү боловсронгуй, өндөр түвшний иж бүрэн технологи л уншиж бичих, хөдөлгөөтэй байдалд нь тус болж чаддаг. Харааны бэрхшээлтэй хүнийг хөгжүүлэхэд төвөгтэй бөгөөд харааны бэрхшээлийн түвшин, нас, юунаас болж хараагүй болсон зэрэг бүх зүйлийг тооцож үзэх шаардлагатай, эс бөгөөс бие даах сурах чадварт нь муугаар нөлөөлдөг байна.

Ерөнхийдөө хүний мэдээлэл олж авах, боловсрол эзэмшихэд шаардагддаг хамгийн эхний мэдрэмж бол харааны мэдрэмж гэж үздэг. Ийм учраас харааны бэрхшээлтэй хүний сонсгол болон хурууны мэдрэмж илүү хөгжиж үүнийгээ боловсрол олж авах үйл явцдаа ашигладаг байна. Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана. Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага баталдаг.[51]

Сонсголын бэрхшээл: Сонсох эрхтний алдагдал нь нь мөн олон янз байдаг бөгөөд нэг чих дүлийрэх болон хоёулаа сонсох чадвараа алдах зэрэг байж болно. Мөн сонсголын түвшин хэр байгаагаас хамааран бага, дунд зэргийн, ноцтой, маш гүнзгий зэргээр ангилж авч үздэг байна. Дамжуулах эдийн гэмтэлээс үүдсэн сонсголын бэрхшээлийн үед ярилцагчийн хэлсэн үгний зарим үгийг сонсохгүй байх

[48] https://prezi.com/4gpff8k1mfdh/presentation/

[49] https://prezi.com/4gpff8k1mfdh/presentation/

[50] Солонго.Э. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд мэдээлэл харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх асуудлууд". УБ., 2014.

[51] "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай".УБ.,2016.13 дугаар зүйл.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суралцахад үүсдэг хүндрэлүүд

Хөгжлийн бэрхшээл	Сурах үйл явцад саад болдог хүндрэлүүд
Физик буюу бие эрхтний доголдол	-Биеийн байрлал болон тэнцвэрээ олоход хүндрэлтэй -Өөрийн дураар чөлөөтэй хөдлөх, байрлалаа өөрчлөх чадвар дутмаг -Гар болон хөлний оролцоо дутмаг -Булчин болон хөдөлгөөнтэй холбоотой мэдрэмж муу -Өвчин болон доголдлоосоо болж ойлгоц муудсан -Хөдөлгөөний хязгаарлагдмал байдал болон хөдөлгөөний хүч хийгээд эзэлхүүн бага -Амархан сульдаж ядардаг
Мэдэрхүйн доголдол	Гэрэл, хэлбэр хэмжээ, дүрс, өнгө зэргийг ялгахад хүндрэлтэй Дуу чимээ муу сонсдог эсвэл сонсдоггүй, дуу чимээний чанар чанга сулыг ялгахад хүндрэлтэй.
Танин мэдэхүйн доголдол	*Ерөнхий хүндрэлүүд:* -Цаг хугацаа, газар орон зай хийгээд хүмүүсийг таних хийгээд хүрээлэн буй орчиндоо зүг чигээ олох чадвар муу -Эрч хүч дутмаг, хянах болон анхаарал төвлөрүүлэхэд хэцүү *Тодорхой хүндрэлүүд*: Анхаарал сул -Мэдээллийг цээжлэх буюу ой ухаандаа тогтоож авах чадвар муу -Таньж мэдэх болон түүнийгээ илэрхийлэх чадвар дутмаг -Шийдвэр гаргах, хийсвэрлэн бодох, төлөвлөх түүнийгээ хэрэгжүүлэх, нөхцөл байдалдаа тааруулж ямар зан араншин яаж биеэ авч явах талаар дутагдалтай -Тэмдэг тэмдэглэгээг таньж ойлгох ялгах чадвар муу -Ойлголт бий болоход хамаарах хүчин зүйлсийн замбараагүй байдал -Сэтгэл хөдлөлтэй холбоотой хүчин зүйлсийн замбараагүй байдал
Хэл яриа болон хэлний бэрхшээл	-Ярианы чадварын дутмагшил болон хязгаарлагдмал байдал -Хэл яриа дуудлагын болон авиа зүйн тод ойлгомжтой байдлаар илэрхийлэх үеийн хүндрэл болон энэ хоёрын хосолсон хүндрэл -Чөлөөтэй ярих болон түүний хэмнэл хурд, дуу хойлооны өнгө зэргийн замбараагүй байдал -Үгийн утга зүйг ойлгох эсвэл ашиглах чадварын асуудалтай -Үг зүйн дүрмийг ойлгож эсвэл хэрэглэх чадварын асуудалтай
Сургалтын тусгай арга нөхцөл шаарддаг бэрхшээлүүд	-Ямар нэгэн чадвар эзэмших болон зохион байгуулах тодорхой мэдээллийг ойлгоход хүндрэлтэй байдаг. -Үг үсэг, захиа бичиг түүнийг зөв таньж унших ойлгоход хүндрэлтэй байдаг. -Тоог таньж мэдэхэд хүндрэлтэй байдаг. -Зөв бичих болон үгийг үсгээр нь дуудахад асуудалтай. -Тооцоолол хийхэд хүндрэлтэй. -Төвлөрч чаддаггүй.

заримыг нь сонсох зэрэг байдал илэрдэг бөгөөд өөрөөр хэлбэл сонсголын байдал нь орж гардаг гэсэн үг. Энэ үед хиймэл эрхтний технологийг ашиглах буюу дотоод чихэндээ дижитал сонсголын төхөөрөмж ашиглах нь үр дүнтэй байдаг. Энэ нь тухайн хэлбэрийн чимээ буюу сарнисан мэдээллийг цуглуулж ойлгох хэлбэрт оруулснаар дуу чимээ мэдээллийг хүлээн авах боломжтой болдог байна. Иймээс сонсголын бэрхшээлийн энэ үед өндөр хүчин чадалтай сонсголын элдэв технологи шаардлагагүй.

Сонсох эрхтний бэрхшээл нь хоёр янзын нөлөөллийг бий болгодог. Үүнд:

- Мэдээлэл хүлээж авах чадваргүй болох:
- Хүнд өөрийн яриагаа илэрхийлж чадахгүй болох:

Сүүлийн нөхцөл нь ярилцах үед илэрдэг. Сонсголын бэрхшээл нэлээн ноцтой шатанд байгаа хүнд сурах үйл явц нь нэлээн хүндрэлтэй байдаг байна. Энэхүү бэрхшээлүүд нь ярианы хэрэглээгээр зуучлагдах логикийн болон асуудал шийдвэрлэх үйл ажиллагааны үед саад болдог байна. Иймээс сургалтын үйл явцад дохионы хэлийг ашиглах нь түгээмэл байдаг. Энэ нь суралцах үйл явцыг дэмждэг сайн талтай. Мөн аман харилцааг сайжруулахыг дэмжихийн тулд дэлгэцэн дээр хадмал орчуулга болон үндэснийхээ дохионы хэлрүү хөрвүүлж байх хэрэгтэй.

Дуу хоолойг таньдаг автомат систем нь багш нарыг аудио болон дүрстэй материалыг хадмал үгтэй болгох боломжийг олгодог бөгөөд зарим нэг төхөөрөмжүүд нь ярьж байхад зэрэг бичгээр дэлгэцэнд гаргаж байдаг. Иймээс учраас багш нарын лекц болон хэл яриагаар илэрхийлэгдэх хичээлүүдийг зэрэг бичгэн хэлбэрт оруулж байдаг техник, технологи шаардлагатай байгаа юм.

Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй. Мөн монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталдаг байна.[52]

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалт улсын хэмжээнд хэдэн удаа зохион байгуулсан, хичнээн хүн хамрагдсан тодорхой тоо байхгүй байна. Бүс нутгийн болон улс, орон нутагт зохион байгуулсан гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэд цөөнгүй хамрагддаг ч гамшгаас хамгаалах ангиллын сургалтын маягт-СМ-1 мэдээний хүснэгтэд[53] үзүүлэлт болгон оруулаагүй. Энэ удаа зөвхөн Нийслэлийн Онцгой байдлын газрын Урдьчилан сэргийлэх хэлтсээс авсан мэдээг график тоон үзүүлэлтээр харуулав.

[52] "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай".УБ.,2016.12 дугаар зүйл

[53] Хугацаат тайлан мэдээг нэгтгэх дүгнэх журам./*ОБЕГ-ын даргын 2013.06.27 №494 тушаал*/.



Зураг.4. Гамшгаас хамгаалах сургалтанд ХБИ-ийн хамрагдсан байдал[54]

Өмнөх жилүүдэд зохион байгуулсан сургалтын тоо тодорхойгүй ч 2013-2016 онд Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийт 32 удаа гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль зохион байгуулж, давхардсан тоогоор 3900 хүнийг хамруулсан байна.

Хэлэлцүүлэг

Судалгааны хүрээнд аюулт үзэгдэл, ослын улмаас хичнээн хүн хөгжлийн бэрхшээлтэй болсон, өртөж, гэмтсэн нь тодорхой бус байна. Иймд ОБЕГ-ын хугацаат мэдээ, тайлан гаргаж ирүүлэх, нэгтгэх, дүгнэх журамд нэмэлт өөрчлөлт оруулж, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын мэдээний маягт хүснэгтэд хөгжлийн бэрхшээлтэй хүн өртөж, нас барсан, гэмтсэн, хүйсийн ялгаа, насны ангиллыг тодорхой оруулах, мөн гамшгаас хамгаалах ангиллын сургалтын мэдээний хүснэгтийг шинэчилэх, хөгжлийн бэрхшээлтэй хэдээс хэдэн насны хичнээн иргэн сургалтад хамрагдсан талаар мэдээлэл оруулснаар тодорхой болно.

Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалт ерөнхийдөө тактик, тархалтын сургуулиар хамрах хүрээг тооцон явуулж ирсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургахад биеийн байрлал болон тэнцвэрээ олоход хүндрэлтэй ба өөрийн дураар чөлөөтэй хөдлөх, байрлалаа өөрчлөх чадвар дутмаг, гар болон хөлний оролцоо дутмаг, булчин болон хөдөлгөөнтэй холбоотой мэдрэмж муу, өвчин болон доголдлоосоо болж ойлгоц муудсан, хөдөлгөөний хязгаарлагдмал байдал болон хөдөлгөөний хүч хийгээд эзэлхүүн бага, амархан сульдаж ядардаг зэрэг өвөрмөц онцлогтой юм байна.

Иймд гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалт, сурталчилгааг тэдний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тохирсон арга, хэлбэрээр зохион байгуулах, онцлогт тохирсон ном, гарын авлага, заавар, сэрэмжлүүлэг, дүрс бичлэгийн богино хэмжээний кино хийх, үзүүлэн таниулах болон тараах материал бэлтгэж түгээх, үндэсний болон олон улсын байгууллагатай түншлэл, хамтын ажиллагааг бүх

[54] НОБГ-ын УСХ-ийн гамшгаас хамгаалах сургалтын мэдээ. УБ.,2013-2016.

түвшинд өргөжүүлж, гадаад орнуудтай туршлага солилцох, нэвтрүүлэх, тэдний оролцоог дээшлүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх юм бол үр дүнтэй болохоор байна.

Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтыг явуулах тусгай хэрэгцээт боловсролын мэдлэг, чадвартай боловсон хүчин Онцгой байдлын албанд одоогоор байхгүй, тусгай сургуулийн тоотой хэдэн багш нарыг эс тооцвол бусад ерөнхий болон их, дээд сургууль ч мөн хүрэлцээ муу байна.Тэгэхээр сургалт зохион байгуулах боловсон хүчний орон тоог гаргах, тусгайлан бэлтгэх, эсвэл сургалт хариуцсан мэргэжилтэнд давхар мэдлэг эзэмшүүлэх, тусгай боловсролын сургуулийн багш, тусгай мэдлэгтэй тэтгэвэрт гарсан эсвэл чөлөөлөгдсөн иргэдийн дэмжлэгийг авах, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий болон тусгай хэрэгцээт боловсролын сургууль, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт зохицуулт хийж, эрх зүйн орчныг сайжруулснаар сургалтын чанар, хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо дээшлэх юм.

Харааны бэрхшээлтэй иргэдийн сонсгол болон хурууны мэдрэмж илүү хөгжиж үүнийгээ боловсрол олж авах үйл явцдаа ашигладаг. Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангадаг байна.

Иймд тэдэнд биер гүйцэтгэх буюу орон байрнаас гарах дадлага эзэмшүүлэхэд баримжаалах аргыг ашиглах, брайль бичгийг ашиглан сэрэмжлүүлэх мэдээлэл, гарын авлага бэлтгэж түгээх, харин сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэд дэлгэцэн дээр хадмал орчуулга болон үндэснийхээ дохионы хэлрүү хөрвүүлж мэдлэг, мэдээлэл өгөх, аюулт үзэгдэлийн түвшинг тодорхойлж, өнгөөр тогтоож өгвөл сонсголгүй иргэд ямар аюул тулгарч байгааг мэдээд аюулаас өөрийгөө аврах дараагийн үйлдлээ хийхэд туслах юм. Мөн олон нийтийн телевизээр гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хадмал болон дохионы хэлээр сэрэмжлүүлэг, дүрс бичлэгийн богино хэмжээний кино хийх, үзүүлэн таниулах болон тараах материал бэлтгэж түгээх зэргээр гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах боломжууд харагдаж байна.

Дүгнэлт

Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд анхаарч авч үзэх асуудал, тэдэнд тохирсон сургалтын ямар аргууд байж болохыг тодорхойлох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтын онцлогыг тодорхойлсон онолын бүтээл, эх зохиол, холбогдох эрх зүйн баримт бичиг, статистик мэдээг судаллаа.

Судалгаагаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлдвэрлэлийн осол, зам тээврийн ослоос шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй болсон статистик тоо

байдаг ч хичнээн иргэн аюулт үзэгдэлд өртөж, гэмтэж бэртсэн, мөн гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хэчнээн иргэнд олгосон тоо баримт байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг бодитойгоор хэрэгжүүлэх 2013-2022 оны Инчеоны Стратегийн баримт бичгийн 7 дугаар зорилтод "Гамшгийн эрсдэлийг бууруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хамруулж авч үзэх"-ээр тусган хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд учирах эрсдлийг бууруулах асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, шийдвэрлэх нь зүйтэй талаар тэмдэглэсэн байна. Тиймээс гамшгийн эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг ханган сургаж дадлагажуулахад холбогдох байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын асуултууд гарч байна.

Манай орны хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд заагдсан олон эрх амьдрал дээр биелэлээ олж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын үйл явц сайнгүй байгаагийн үндсэн шалтгаан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогыг судалж, сурах орчинг бүрдүүлж өгөөгүй тэдэнтэй ажиллах багш нарыг бэлтгээгүй, ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдүүдийг дутуу чадвартай, тусгай хэрэгцээ шаардлагатай хүмүүс гэсэн буруу ойлголт хандлагаас үүдэлтэй гэж дүгнэж болох юм.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн А/358 дугаар тушаалд "Гамшгаас хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн дагуу оюутнуудад гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалтыг сургалтын төлөвлөгөөнд тусгаж, Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн багш нараар заалгаж байхыг төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн захирлуудад даалгасан. Харин сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын болон тусгай сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гамшгаас хамгаалах чиглэлийн сургалт явуулах эрх зүйн зохицуулалтгүй, хичээлийн сэдэв хөтөлбөр, төлөвлөгөөнд одоо хүртэл ороогүй байгаа нь энэхүү харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь тулгамдсан асуудлын нэг байсан хэвээр байна.

Ном зүй

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал. НҮБ.,1975.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай . УБ.,2016.
3. Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн "Эрхийг нь бодитой болгох Инчоны стратеги". 2012.
4. Хёогогийн үйл ажиллагааны хүрээний тунхаг бичиг. 2005.
5. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг. 2015.

6. Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага, Дэлхийн Банк, Хөгжлийн бэрхшээлийн тухай дэлхийн тайлан. Женев., ДЭМБ.2011.
7. Солонго.Э. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд мэдээлэл харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх асуудлууд. УБ.,2014.
8. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. УБ.,УБСЕГ.2015.
9. Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллого. УБ., 2010.
10. Статистикийн эмхэтгэлүүд. УБ.,2008-2015.

ГЭР ХОРООЛОЛД ГАРЧ БУЙ ГАЛ ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ

дэд хурандаа Д.Цэцэндалай
Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, магистрант

Удиртгал

Дэлхий нийтэд түгээмэл тохиолддог байгалийн 30 гаруй аюулт үзэгдлээс манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, хуй салхи, цөлжилт, аянга, аадар бороо, үер, хүн, малын олон улсын хөл хориот гоц халдварт өвчний тархалт зэрэг байгалийн гаралтай 10 гаруй аюулт үзэгдэл ой хээрийн түймэр, нисэх онгоцны сүйрэл, гол, нуурын мөсний цөмрөлт, уурхайн дэлбэрэлт, гүний нуралт, химийн хорт бодисын хордуулалт, объектын гал түймэр болон авто тээврийн хэрэгслийн томоохон осол зэрэг хүний буруутай үйл ажиллагаа, техникийн холбогдолтой осол гарч хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин сүйрч, нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учирч байна.

Монгол Улсад жилд дундажаар 3200 орчим аюулт үзэгдэл, осол тохиолддогийн 90 гаруй хувийг объектын болон ой хээрийн түймэр харин үлдсэн 10 хувийг бусад аюулт үзэгдэл, осол эзэлдэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.4.3.1-д "иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно" гэж, мөн үзэл баримтлалын 3.5.5.2-т "Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж чадавхийг бэхжүүлнэ" гэж, Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого"-ын 2.1-д "Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрт тус тус заасан байна.

2015 онд Япон улсын Сендай хотноо зохион байгуулсан Дэлхийн бага хурлаас гаргасан "2015-2030 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичигт гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх, гамшгийн эрсдэлийг удирдах засаглал

болон бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үндсэн чиглэл болгон тусгасан[55] нь дэлхий дахинд төр гамшгаас хамгаалах асуудлыг бие даан хариуцах бус гамшгийн эрсдлийг бууруулах асуудлыг олон нийтийн оролцоотой хамтын хүчээр хийхийг чухалчилсан баримт бичиг болсон.

Иймд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг орчин үеийн гамшгаас хамгаалах менежментийн үзэл баримтлалд нийцүүлэн, үр дүнтэй, оновчтой явуулахад иргэдийн эмзэг байдал, хэрэгцээ шаардлагыг төрийн зүгээс бодлогын түвшинд авч үзэх хэрэгтэй байна.

Гэр хороолол дахь гал түймрийн эрсдэл

Манай оронд сүүлийн 15 жилийн дунджаар (2000-2015он) аюулт үзэгдэл, осол 3200 орчим удаа тохиолдож, түүнд 180 орчим хүн амь насаа алдаж, эдийн засаг экологид 89,0 тэрбум төгрөгийн хохирол учраад байна. Дээрх осол аюулт үзэгдэл, ослын 90 гаруй хувь, хохирлын 80 гаруй хувийг гал түймрийн аюулт үзэгдэл эзэлж байгаа судалгаа гарч байна. Мөн түүнчлэн 2005 онд объектын гал түймэр 2428 удаагийн дуудлага бүртгэгдэж 2 тэрбум 115,8 сая төгрөгийн хохирол учирч байсан бол 2015 онд 4561 удаагийн дуудлага бүртгэгдэж 11 тэрбум 517,4 сая төгрөгийн хохирол учирсан байгаагаас харахад 10 жилийн хугацаанд даруй гал түймрийн тоо 2 дахин, хохирлын тоо 5 дахин нэмэгдсэн байна.

1-р зураг дээрх судалгаа, тоо баримтаас авч үзвэл өнөөдөр объектын гал түймрийн асуудал дээр анхаарлаа хандуулах цаг аль хэдийн ирсэн байна.

2015 онд Монгол улсын хэмжээнд нийт 5426 удаагийн аюулт үзэгдэл осол тохиолдож, үүний улмаас 198 хүний амь насаа алдаж, 85 хүн гэмтэж бэртэн 202,9 мянган толгой мал хорогдож, 79,9 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан байна[56].


Үүнээс Улсын хэмжээнд нийт 4561 удаагийн объектын гал түймэр гарч, 58 хүн нас барж, 35 хүн түлэгдэж гэмтэн 594 толгой мал хорогдож, 1626 гэр орон сууц шатаж, 11,5 тэрбум төгрөгний хохирол учирсан байна.

Дээрхи статистик мэдээ, судалгаанаас үзвэл Монгол Улсад гарч байгаа аюулт үзэгдэл, ослын дийлэнх хувийг объектын болон ой хээрийн гал түймэр эзэлж байгаа нь ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагын галын аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллаж байгаа, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, гал түймрийн эрсдэлийг бууруулах ажлыг төрийн бодлогын хүрээнд авч үзэх шаардлага урган гарч ирж байна.

Монгол Улсад гарч байгаа гал түймрийг өмчийн хэлбэр болон гал гарах шалтгаан нөхцлөөр авч үзвэл:

[55]Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр

[56]Монгол улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл 2014, 2015




Зураг-1. 2000-2015 онд Монгол Улсад гарсан гамшиг ослын тоо



Зураг-2. 2015 онд Монгол Улсад гарсан гамшиг ослын тоо (эзлэх хувиар)



Зураг-3. 2015 онд Монгол Улсад гарсан гамшиг ослын хохирол (эзлэх хувиар)



Зураг-4. 2015 оны гал түймрийн аюулт үзэгдэлд өртсөн өмчийн хэлбэр



Зураг-5. 2015 оны гал түймрийн аюулт үзэгдэлд өртсөн амины өмчийн хэлбэр

Хүснэгт-1. Объектын гал түймэр гарсан шалтгаан

Цахилгаан эрчим хүчнээс	**884**
Гагнуур, паялник, бамбараас	26
Пийшин зуух, яндангийн цонолтоос	278
Ил задгай гал,асгасан үнс нурамнаас	2313
Лаа, дэн, тамхи, шүдэнзний галаас	80
Хүүхдийн болгоомжгүй үйл ажиллагаанаас	43
Газрын тосны бүтээгдэхүүний ашиглалтын буруугаас	4
Машин техникийн гэмтэл ашиглалтын буруугаас	117
Технологийн горим зөрчснөөс	7
Байгалийн үзэгдлээс	3
Тэсрэлт, дэлбэрэлт, ослоос	2
Машин техникийн яндангийн цонолт, оч болон цахилгааны очноос	82
Санаатай үйлдлээр	32
Архидан согтуурснаас	13
Шалтгаан тогтоогдоогүй	279
Бусад	123

Улсын хэмжээнд гарч буй гал түймрийн 70 гаруй хувь нь амины өмч буюу гэр хороололд гарч байгаа бөгөөд үүний улмаас олон мянган айл өрх орон гэргүй болсон байна. Хувийн өмчид гарсан гал түймрийн машин техник, хашаа саравч, өнжмөл өвс зэрэгт гарсан гал түймрийг бусад хэлбэр гэж үзэж амьдран суух хэлбэрээр авч үзвэл 1662 гэр орон сууц гал түймрийн улмаас өртөж сүйдсэн байна.

Дээрх судалгаанаас авч үзвэл гарсан гал түймрийн шалтгаан нөхцлийн 2313 удаагийн ил задгай гал, асгасан үнс нурамны улмаас хогийн суваг, өнжмөл өвс, гэр хорооллын дундах хогийн цэгт гал гарсан бол бас нэг дийлэнх шалтгаан нь гэр хорооллын ард, иргэд айл өрхийн ахуйн цахилгаан шугам сүлжээний ашиглалт, угсралт, техникийн шаардлагыг хангаагүйгээс гал түймэр гарах шалтгаан бий болсон байна.

Дээрх шалтгааны улмаас тухайн айл өрх галд өртөөд зогсохгүй зэргэлдээх айл өрх галд давтаж улмаар 1985 онд Яармагт нэг гудамжны 10 айл өрх, 1987 онд Хайлаастад мөн нэг гудамжны 5 айл өрх өртөж байсан гашуун түүх бэлхнээ харуулж байна.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага 2012 онд бүтцийн өөрчлөлтөөр гэр хороод хариуцсан гал түймрийн туслах байцаагчийн орон тоог хассанаар гэр хороодод галын аюулгүй байдлыг хангах хяналт тавих улсын хяналт байхгүй болсноор төрийн үйлчилгээний нэг хэсэг орхигдсон байна гэж үзэж болно.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2014 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн "Өдөрлөг зохион байгуулах тухай" А/241 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлд гарсан гал түймрийн хамгийн их дуудлагатай Баянзүрх дүүргийн 5, 9, 14 дүгээр хороонд гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх өдөрлөгийг 2014 оны 9 дүгээр сарын 29-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулсан нь хамгийн сүүлийн судалгааны материал болж байна.

Тус өдөрлөгт Онцгой байдлын ерөнхий газраас 5 албан хаагч, нийслэлийн Онцгой байдлын газраас 12 албан хаагч , Аврах ангиас 23 албан хаагч, төвийн 6 дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 28 албан хаагч, Аврах гал унтраах ангиас давхардсан тоогоор 423 албан хаагч, Онцгой байдлын байгууллагын 8 ахмад ажилтан, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, 5, 9, 14 дүгээр хороодоос 46 ажилтан оролцож, нийт 545 хүн, шуурхай албаны 3 автомашинтайгаар зохион байгуулж ажилласан байна.

Баянзүрх дүүргийн 5, 9, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах гэр хорооллын бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг 33 байгууллага, аж ахуйн нэгж, 14 нийтийн байр, 2884 айл өрхөд галын аюулаас урьдчилан сэргийлэх шалгалтыг зохион байгуулж, гал гарч болзошгүй *нийт 4233 зөрчил илрүүлж, 636 зөрчлийг газар дээр нь арилгуулж, заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 18-ийг бичиж, байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажилласан*

байна.Шалгалтаар илрүүлсэн нийтлэг зөрчлийн талаар авч үзвэл[57]:

1. Цахилгааны монтажны кабель утас ашиглалт, угсралтын шаардлага хангаагүй, норм дүрэм зөрчсөн-1811

2. Цахилгааны уртасгагч эвдрэл гэмтэлтэй-167

3. Цахилгааны ачааллыг нэмэгдүүлж нэг дор олон төрлийн цахилгаан хэрэгсэл залгасан-23

4. Гэр хорооллын айл өрхийн хашаа, гэр байшингийн хоорондын зай хэмжээ алдагдсан-637

5. Бага насны хүүхдийг хараа хяналтгүйгээр гэр байшиндаа цоожилдог-43

6. Гэр хорооллын айл өрхийн хашаанд байрлах чингэлэг, агуулах, амбаарт шатах тослох материал хадгалдаг-52

7. Айл өрхийн ашиглаж байгаа пийшин зуух, яндангийн зөрчилтэй-292

8. Шуурхай албаны автомашин хүрэлцэн очих боломжгүй өндөрлөг газарт буусан-94

9.Мухар гудамжтай айл өрх-150

10. Хашаандаа өвс, мод зэрэг шатах материалыг нөөцөлж хадгалдаг-52

11. Гэр хашаандаа үйлдвэрлэл эрхэлдэг-150

12. Зориулалтын төмөр тагтай саванд хийгээгүй, үнс нурам ил задгай асгасан -760 зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Гэр хорооллын гал түймрийн эрсдэлийг бууруулах арга зам

Судалгаанаас үзвэл Монгол улсад гарч байгаа аюулт үзээгдэл, ослын 90 гаруй хувь, хохирлын 80 гаруй хувийг гал түймрийн аюулт үзэгдэл эзэлж байгаагийн 60 гаруй хувь гэр хорооллын айл өрхөд гарч байна.

Гал түймэр гарч байгаа шалтгаан нөхцлийн 21 гаруй хувийг цахилгаан шугам сүлжээний ашиглалт, угсралт, техникийн шаардлагын улмаас гарч байгаа нь тогтоогдсон, Гал түймрийн аюулт үзэгдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 48 гаруй хувь нь цахилгаан эрчим хүчний зөрчил дутагдал эзэлж байгаагаас үзвэл гал түймрийн аюул эрсдэл нь "Цахилгаан эрчим хүчний ашиглалт, угсралт"-аас үүдэлтэй болох нь тодорхой байна.


Гэр хорооллын галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар айл өрхийн цахилгаан шугам сүлжээг хэрэглээний ачаалал, гүйдлийн хүчид тохирсон шугам, мөн түүнд тохирсон гал хамгаалагчийг шинэчлэн солих шаардлагыг тухай бүр хүргүүлдэг боловч энэ шаардлага нь тэр бүр хэрэгжихгүй байгаа нь айл өрх, иргэний орлого, санхүүгийн чадавхаас шалтгаалан мэргэжлийн түвшинд иж бүрэн сольж чаддаггүй, зарим айл өрх нь өөрсдийн санхүүгийн боломжийн хүрээнд чанар муу, даац, гүйдлийн хүчид тохирохгүй материалаар мэргэжлийн бус хүнээр хийлгэж байгаа нь шаардлагын түвшинд хүрдэггүй байна.

[57]Нийслэлийн Онцгой байдлын газрын 2014 оны ГАУС-лэх ажлын тайлан.

Гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээ (Давуу тал)	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад учирсан бэрхшээл (Сул тал)
- Гал түймрийн талаарх сургалт сурталчилгааг хийсэн. - ГАУС-лэх үзлэг шалгалт явуулсан. - Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж өгсөн. - гэр барилга байгууламжийн хоорондын зай хэмжээ тогтоон зааварчилгаа өгсөн. - Гал ихээр гарахад нөлөөлдөг үнс нурмаа ил задгай асгахгүй байх зөвлөгөө өгдөг - Мөн цахилгаан шугам сүлжээг мэргэжлийн байгууллагаар шалгуулж шинэчлэх, засварлах зөвлөгөө өгдөг	- Гал түймрийн аюулт үзэгдлийн талаар хайрхардаггүй, мэдлэг муу. - ГАУС-лэх үзлэг шалгалтаар явсан алба хаагчдыг оруулдаггүй, үзлэг шалгалтад ач холбогдол өгдөггүй - Эрчим хүч, цахилгааны мэдлэг муу - Ахуйн цахилгаан эрчим хүчний засварчин монтёр гэр хороодод байдаггүй - Цахилгаан шугам сүлжээг засварлах чадвар байхгүй - Санхүүгийн боломж сул зэрэг сул

Тэгвэл гэр хороололд гарч байгаа болон гарч болзошгүй хамгийн эрсдэл ихтэй аюул нь цахилгаан эрчим хүчний асуудал болоод байна.

Үүнийг шийдвэрлэхийн тулд Төр, хувийн хэвшил, иргэний хамтын ажиллагаа буюу өнөөдрийн гамшгийн менежментийн олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаа юм.



Төр нь аймаг нийслэл, дүүрэг, сум хороодын гэр хороодын гамшгийн эрсдлийг үнэлээд түүндээ тохирсон гамшигтай тэмцэх бэлэн байдал, чадавхийг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг төлөвлөн бодлогын хувьд гамшгийн эрсдлийг удирдах засаглалыг хөгжүүлэх.

Төрийн болон хувийн хэвшил нь мэргэжлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж, ахуйн цахилгаан эрчим хүчийг нь стандарт норм дүрмийн дагуу үйлчилгээг үзүүлснээр Гал түймрийн аюулыг бууруулах бодитой шийдэлд хүрэх.

Гамшгаас хамгаалах эрсдэлийн, банк бус санхүүгийн байгууллага нь тухайн айл өрхийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шинэчлэн засварлахад шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг эргэн төлөгдөх нөхцлөөр (өнөөгийн лизингийн зээлийн хэлбэр) санхүүжүүлэх.

Иргэн айл өрх нь цахилгаан эрчим хүчнээс шалтгаалсан гал түймрийн аюул гарах магадлал буурна.

Дүгнэлт

1. Монгол Улсад гарч байгаа аюулт үзэгдэл, ослын 90 гаруй хувь, хохирлын 80-аад хувийг гал түймрийн аюулт үзэгдэл эзэлж байна. Гал түймрийн аюулт үзэгдлийн 84 хувийг объектын гал түймэр эзэлж байна

3. Обьектын гал түймрийн 72 хувийг хувийн амины өмчид гарсан гал түймэр эзэлж байна.

4. Гал түймэр гарч байгаа шалтгаан нөхцлийн 884 тохиолдол буюу 21 хувийг цахилгаан шугам сүлжээ ашиглалт, угсралт, техникийн шаардлага хангаагүйгээс гарсан байна.

5. Гэр хороодын айл өрхөд хийсэн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтаар 4223 гал гарч болзошгүй зөрчил дутагдал илрүүлсний дийлэнх буюу 48 хувь нь цахилгаан шугам сүлжээний зөрчил дутагдал зонхилж байна.

Гэр хороодын гал түймрийн эрсдэлийг Төр, иргэд, хувийн хэвшил, олон нийтийн оролцоотой бууруулахын тулд дараах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах нь зүйтэй. Үүнд:

1. Иргэдэд гамшгийн талаарх мэдлэг, эрсдэлийг ойлгуулан тэдний оролцоотой үнэлэх.

2. Объектын гал түймрийн 70 гаруй хувийг эзэлдэг гэр хорооллын гал түймрийн тоо хохирлыг иргэд, хувийн хэвшлийн оролцоотой бодитой бууруулснаар гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэхэд хувь нэмэр болох

3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төр дангаараа хариуцан гардан хэрэгжүүлэн эрсдэлийг хариуцдаг байсан бол иргэд өөрсдөө эрсдэлээ тооцон мэргэжлийн байгуулагатай хамтран цахилгаан эрчим хүчээ шинэчлэх хамтын ажиллагааны үр дүнд гал түймрийн эрсдэлийг бууруулах

4. Иргэдийн аюулгүй амьдрах таатай нөхцөл бололцоо, санхүүгийн тулгамдаж буй асуудал, эрсдэлийг бууруулахад том хөрөнгө оруулалт болох зэрэг давуу талууд бий болно гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010

3. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, 2011

4. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, 2015

5. 2015-2030 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичиг, 2015

6. Д.Бадамсүрэн, П.Амарзаяа, Д.Содномрагчаа, Ч.Мэндэлмаа, П.Чимэдцэрэн нарын Монгол Улсад

тохиолдсон аюулт үзэгдэл, солын мэдээний эмхэтгэл 2014, 2015

7. Д.Сэржмядаг. “Олон нийтийн оролцоотойгоор гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, туршсан дүн” илтгэл, 2015

8. В.Батсайхан нарын “Гамшгийн нэр томьёоны тайлбар толь” 2012

9. Д.Сэржмядаг “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо” 2013

10. Нийслэлийн Онцгой байдлын газрын 2015 оны тайлан

11. Нийслэлийн Онцгой байдлын газрын Гэр хороодод явуулсан Гамшгаас урьдчилан сэргийлэх шалгалтын илтгэх хуудас 2014

12. Нийслэлийн Статистикийн газрын 2015 оны статистик мэдээлэл

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

ахмад Ц.Очбадрал
ХСИС-ийн Хууль сахиулахын
удирдлагын академийн
821 дүгээр дамжааны суралцагч,
магистрант

Хураангуй.

Ахлагч бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтыг сайжруулснаар гамшиг, осол, гал түймрийн голомтод Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавх нэмэгдэх болон цаашид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

Түлхүүр үг. Ахлагч бүрэлдэхүүн, хүний нөөцийн сонгон шалгаруулалт, орон тоо, нөхөн хангалт.


Удиртгал

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэн, Мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төв, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах анги, Хангалт үйлчилгээний анги, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын нөөцийн салбар зэрэг 100 гаруй нэгжтэйгээр улсын хэмжээнд гамшиг, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн жилүүдэд улс орны хүн ам, хот суурин газрын хэт төвлөрөл, дэд бүтэц, зам, барилга ихэсч байгаатай уялдан гамшиг, осол, гал түймрийн тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа боловч Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн орон тоо, гал унтраах, аврах ангийн тоо төдийлөн хангалттай нэмэгдэхгүй байна.

Тус байгууллага нь 2016 оны байдлаар 4121 албан хаагчийн батлагдсан орон тоотой. Үүнээс 3704 төрийн тусгай албан хаагч /1003 офицер, 2701 ахлагч/, 417 төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоотой байна. Офицерийн нөхөн хангалт 93.5 хувь буюу 938, ахлагчийн нөхөн хангалт 89 хувь буюу 2406, төрийн үйлчилгээний албан хаагчийн нөхөн хангалт 99.2 хувь буюу 414 ажилтан байгаа бөгөөд нийт албан хаагчдын нөхөн хангалт 91.1 хувь буюу 3758 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

ОХУ-д 650 хүн тутамд, АНУ-д 260 хүн тутамд, Япон улсад 375 хүн тутамд тус тус галын мэргэжлийн нэг ажилтан ногдож байхад Монгол Улсад 2020 хүнд галын мэргэжлийн нэг албан хаагч ногдож байна.



Зураг 2. Нэг албан хаагчид ногдох хүн ам

Гүйцэтгэх чиг үүргийнхээ хувьд төрийн бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай харьцуулахад илүү эрсдэлтэй, өдөр тутмын ажил үүрэг нь гамшгийн аюултай нүүр тулж байдаг тус байгууллагын албан хаагчдын хувьд амь насны эрсдэл харьцангуй их байдаг нь 2004 оноос хойших хугацаанд албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан 16 ахлагч бүрэлдэхүүний баримтаас харагдана.

Хүснэгт 1. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн ахлагч бүрэлдэхүүний судалгаа

Ангилал	Он						Нийт
	2005	2007	2008	2012	2013	2014	
Ахлагч	1	1	9	3	1	1	16

Иймд Онцгой байдлын албанд шинээр орох ахлагч бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулж авах эрхзүйн орчныг сайжруулах бодитой шаардлага үүсээд байна.

Ахлагч бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 91 дүгээр тушаалаар батлагдсан "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад алба хаах журам"-ыг баримтлан албанд анх орох иргэнээс сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг тавьдаг. Үүнд:

2.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад төрийн тусгай албан хаагчаар ажиллахыг хүссэн иргэн дор дурдсан шаардлага шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

2.1.1. Тухайн нутаг дэвсгэрт оршин суух хаягийн бүртгэлтэй, 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн байна.

2.1.2. Өөрийн хүсэлтээр тус байгууллагад ажиллах өргөдлөө бичгээр гаргасан байна.

2.1.3. Ахлагчийн албан тушаалд ажиллахыг хүссэн иргэн бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой, офицерийн албан тушаалд ажиллахыг хүссэн иргэн тухайн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг хангахуйц боловсрол мэргэжилтэй байх ба цэргийн алба хаасан, эсхүл цэргийн хэргийн мэдлэг олгох анхан шатны сургалтад хамрагдсан байна.

2.1.4. Эрүүл мэнд, бие бялдрын хувьд магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тус албанд тэнцэх, 165 см-ээс доошгүй өндөртэй. бие бялдрын зөв хөгжилтэй, эрүүл чийрэг, бие эрхтэний хувьд ямар нэгэн эмгэг, бэртэл, согоггүй, шивээсгүй байна.

2.1.5. Ял шийтгэлгүй байна.

2.2. Дор дурдсан төрийн тусгай албан тушаалд ажиллахыг хүссэн иргэн энэ журмын 2.1-д заасан нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтээс гадна дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1. Тусгай зориулалтын болон шуурхай албаны автомашины жолоочийн албан тушаалд тухайн ангиллын автомашиныг 3-аас доошгүй жил жолоодсон туршлагатай 30 хүртэлх насны эрэгтэй, бусад ахлагчийн албан тушаалд 25 хүртэлх насны эрэгтэй, эмэгтэй, офицерийн албан тушаалд 35 хүртэлх насны эрэгтэй, 32 хүртэлх насны эмэгтэй байна.

2.2.2. Ажлын зайлшгүй шаардлагаар нэн шаардлагатай мэргэжлээр мэргэшсэн 42 хүртэлх насны иргэнийг ажилд авч болно.

Дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнийг тус журмын 4.3, 4.4-т зааснаар хөдөлмөрийн гэрээ байгуулан, ахлагчийн албан тушаалын сул орон тоонд дадлагажих ажилтнаар 6 сар хүртэлх хугацаанд ажиллуулж, төрөл мэргэжлийн анхан шатны сургалтад хамруулж, "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын дагуу шалгалт авч, томилох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Харин Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4-т зааснаар "хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол" төрийн жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хориглоно.

Онцгой байдлын албанд шинээр томилогдож байгаа ахлагчийн тоо жил тутам өсөн нэмэгдэж байгаа боловч сүүлийн 5 жилд тус байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн нийт 386 ахлагчийн шалтгаан нөхцлийг судалж үзэхэд амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилгоор бизнес хийх, өндөр цалин хангамж санал болгосон хувийн хэвшлийн салбар руу орох, мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилгоор сургуульд суралцах зэрэг шалтгаанаар тус албанаас гарсан байна.[58] Энэ нь манай улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар хөгжиж, үндэсний хэмжээний том компаниуд өсөн нэмэгдэж, тэдний өгч байгаа цалин, урамшуулал, нийгмийн хангамж нь төрийн байгууллагаас илүү байгаатай шууд холбоотой юм.

[58] Онцгой байдлын ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2015, х. 15-16

Хүснэгт 2. Ахлагч бүрэлдэхүүний хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн

Ангилал	Шалтгаан	Он									
		2011		2012		2013		2014		2015	
Ахлагч	Томилогдсон	90		313		176		232		235	
	Чөлөөлөгдсөн	58	124	82	152	64	113	72	112	110	234
	Халагдсан	20		28		7		15		43	
	Тэтгэвэрт	46		42		42		125		81	

Мөн халагдсан 113 ахлагчийн дийлэнх хувь нь 5 хүртэлх жил ажилласан залуу албан хаагч эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн халагдсан шалтгаан нөхцлийг судалж үзэхэд олон хоног ажил тасалж, албаны бэлэн байдал алдагдуулсан, үүрэгт ажлаасаа няцсан, ажлын цагаар ажлын байранд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, гэмт хэрэгт холбогдсон нь шүүхээр тогтоогдсон гэх мэт шалтгаанууд байна. Энэ нь тус байгууллагын хүний нөөцийг судалж, сонгох, дасан зохицуулах, сургаж хөгжүүлэх бодлого, үйл ажиллагаа учир дутагдалтай байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 3. Ахлагч бүрэлдэхүүний насны байдал

Ангилал	1-5	5-10	10-15	15-20	20-25	25-30
Ахлагч	583	598	766	303	115	41
	24,2%	24,9%	31,8%	12,6%	4,8%	1,7%

Дээрх хугацаанд тус албанаас цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгохоор нийт 336 ахлагч албан хаагч гарсан байгаа нь олон жил ажиллаж мэргэшсэн, мэдлэг, дадлага, туршлага сайтай албан хаагчдын орон зайг нэн яаралтай нөхөн хангах асуудал яах аргагүй тулгамдаж буй асуудлын нэг болж байна. Тэтгэвэрт гарах хүсэлтэй болон гарсан албан хаагчийн тоо харьцангуй ихэсч байгаа шалтгаан нь албан хаагчдын өвчлөл, стресс, амьдралын амжиргааны түвшинтэй хамааралтай бөгөөд нөгөө талаар цэргийн албан хаагчдын нэг удаагийн тэтгэмжийн хэмжээг өөрчлөх талаар төр засгийн зүгээс сүүлийн үед их ярьж, бичиж байгаатай шууд холбоотой юм.

Хүснэгт 4. Ахлагч бүрэлдэхүүний орон сууцны нөхцөл

Ангилал	Нөхөн хангагдсан	Түрээсийн байр, айлд	Байгууллагын орон сууц	Гэр, байшин	Нийтийн орон сууц	Ха-луун ус
Ахлагч	2406	280	109	1428	586	3
		11.6%	4.5%	59.4%	24.4%	0.1%

Хувь хүний хувьд ажиллаж, амьдрах орчин, хамт олон, эрхзүйн баталгаа, амьдралын хэв маяг, төлөвшлийн түвшингээс шалтгаалж ажил, албандаа хандах хандлага илэрхийлэгдэнэ. Тиймээс тухайн албан хаагчийн нийгмийн асуудал нь байгууллагын үйл ажиллагаатай шууд болон шууд бус хэлбэрээр холбогддог тул тэдгээр субьектив хүчин зүйлийг судлан үзэж, албан хаагчдын амьжиргааны баталгаажих түвшинг нэмэгдүүлэх замаар бие бүрэлдэхүүний нийгмийн баталгааг сайжруулснаар сэтгэл санаа өөдрөгөөр ажил, албандаа үнэнч зүтгэж, албаараа бахархах, эрч хүчтэй, тогтвор суурьшилтай ажиллах, үүрэг гүйцэтгэх таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Халагдсан, чөлөөлөгдсөн албан хаагчдын тоо жилээс жилд өсч байгаа нь нэг талаасаа нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалж байгаа боловч нөгөө талаараа хүний нөөцийн судалгаа, сонголт тэр бүр оновчтой биш, шалгаруулалт хангалттай хийгдэхгүй, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, техник, багаж, зэвсэглэмж дутмаг, мөн улс төр, нийгмийн үйл явцын нөлөөлөл их байгаатай холбоотой гэж үзэж байна.

Иймд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад анх орох иргэдээс сонгон шалгаруулж авах эрхзүйн орчныг шинэчлэн боловсруулж, чанд мөрдөх, албан хаагчийн нийгмийн баталгаа, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, багаж, зэвсэглэмж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайжруулах, улс төр, нийгмийн үйл явцын нөлөөллийг арилгах нь дээрх шилжилт хөдөлгөөнийг бууруулахад эерэг үр нөлөө үзүүлнэ.

Дүгнэлт

Улс орны хүн ам, хот суурин газрын хэт төвлөрөл, дэд бүтэц, зам, барилга ихэсч байгаатай уялдан гал түймэр, гамшгийн тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа тул Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүний нөөцийн орон тоог нэмэгдүүлэх нь нэн тэргүүний чухал үйл асуудал юм.

Албан хаагчдын аюулгүй ажиллаж, амьдрах нийгмийн баталгаа, гал түймэр, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, техник, багаж, зэвсэглэмжийн хангалтыг сайжруулах асуудлыг тус байгууллага болон төр засаг нэн яаралтай анхааралдаа авах нь зүйтэй.

Цаашид Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад анх орох иргэдээс сонгон шалгаруулж авах эрхзүйн орчныг шинэчлэн боловсруулж, чанд мөрдөх, улс төр, нийгмийн үйл явцын нөлөөллийг арилгах нь шилжилт хөдөлгөөнийг бууруулж, туршлагатай, чадвартай албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлснээр байгууллагын цаашдын хөгжилд чухал үр нөлөө үзүүлэх юм.

Иймд дотоод болон гадаадын ижил төстэй байгууллагуудад мөрдөгддөг эрхзүйн орчныг судалж, хэрэгжүүлэх боломжтой сонгон шалгаруулалтын арга зүйг Монгол Улсын Онцгой байдлын асуудал

эрхэлсэн байгууллагад анх орох иргэдээс сонгон шалгаруулж авахтай холбогдсон эрхзүйн орчинд тусган оруулах шаардлагатай.

Ахлагчийн албан тушаалд анх орох иргэдийг журмын дагуу тодорхой хугацаанд "дадлагажих ажилтан"-аар томилж, дадлагажуулсны дараагаар Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуульд мэргэжлийн анхан шатны сургалтад хамруулах гэсэн шат дараатай үйл ажиллагааны үндсэн дээр жинхлэн томилж ажиллуулах нь тухайн албан тушаалд хандах хандлага, байгууллагад тогтвор суурьшилтай ажиллах чин эрмэлзэл болон сэтгэлзүй, бие бялдрын чадавхыг тодотгон харуулах сайн талтай.

Ашигласан материал

1. Шуурав, Я. Менежмент. 2009, Улаанбаатар
2. Цэцэгмаа, Ц. Хүний нөөцийн менежмент. 2014, Улаанбаатар
3. Онцгой байдлын ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2015
4. Гамшиг судлалын хүрээлэн. "Судалгааны ажлын эмхтгэл-2014, 2015"
5. Буянтогтох, Г. (2015). "Онцгой байдлын албаны хүний нөөцийн менежментэд тулгамдаж буй зарим асуудал"

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛАХ НЬ

Хошууч Т. Мөнхдорж
ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны сурагч, магистрант

Удиртгал

Аливаа улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт нь тухайн улсын хөгжлийг тодорхойлдог гол хүчин зүйл байдаг.

Монгол Улсад өнөөгийн байдлаар үндэсний, салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр 1991 оноос хойш 480 гаруй бодлогын баримт бичигийг баталсанаас өнөөдөр 190 гаруй нь хугацааны хувьд хүчинтэй байна. Эдгээр бодлогын баримт бичгүүд нь үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө зэрэг нэршилтэй байна. Түүнчлэн хэрэгжих хугацаа, бодлогын зорилго, зорилт давхардсан, хоорондын уялдаа сул байгаагаас хэрэгжилт хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхгүй байна. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгцээ, шаардлагын үндэслэл, тооцоо, судалгаа нь хангалттай түвшинд хийгдэж, санхүүгийн эх үүсвэр, чадавхтай зохистой түвшинд уялдаагүй байгаа нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжих боломжийг бууруулж байна. Иймд, нэн тэргүүнд хүчин төгөлдөр хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдийг цэгцлэн, хөгжлийн нэгдсэн зорилгод чиглүүлэн, хөгжлийн бодлогын нэгдмэл байдлыг хангаж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын залгамж чанарыг хадгалах эрх зүйн орчинг бий болгох асуудал чухлаар тавигдсан.

Улс орны эдийн засгийн үр өгөөж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тэнцвэртэй, хүртээмжтэй өсөлтийг орон даяар бий болгох, хүний хөгжлийг хангах болон ард иргэдийн амьдралын түвшинг сайжруулахад чиглэгдсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулах, хоорондын уялдааг хангах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай" хуулийг 2015 оны 11 дүгээр сард УИХ-аар баталсан.

Үүнтэй уялдуулан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг бодлогын бүх түвшинд, салбар хооронд болон орон нутгийн хөгжлийн бодлогуудын уялдааг ханган, хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааг тусгах нь нэн чухал асуудлын нэг юм.

Иймд энэхүү илтгэлд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг Монгол Улсын гол салбаруудын бодлого, төлөвлөлттэй хэрхэн уялдуулан тусгах, бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлыг хөндөхийг зорьсон болно.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулах нь

Гамшгийн эрсдэл гэж аюул, осол, эмзэг байдлын хоорондын харилцан

үйлчлэлээс бий болсон хор уршиг эсвэл гарч болох хохирлын (хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, амьжиргааны хэрэгсэл, хүрээлэн буй орчинд хохирол учирч эсвэл эдийн засгийн үйл ажиллагаа тасалдсан) магадлалыг хэлнэ. Эрсдэлийг дотор нь:

1. Тодорхойлогдсон бөгөөд тохирох арга хэмжээ төлөвлөгдсөн,
2. Тодорхойлогдсон бөгөөд тохирох арга хэмжээ төлөвлөгдөөгүй,
3. Тодорхойгүй гэж гурав ангилдаг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах гэж гамшиг үүсгэх онц аюултай объектууд, экологи, байгалийн аюултай үзэгдлүүдийг ажиглах, хүрээлэн байгаа орчны төлөвт мониторинг хийх, хууль эрх зүй, зохион байгуулалт, эдийн засаг, инженер техник, экологийн хамгаалалт, эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээнүүдийг тусгасан цогц бодлого явуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ[59] юм гэж тодорхойлжээ.

Үүнтэй зэрэгцэн гамшигтай тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэхэд засгийн газрын үүрэг, оролцоо нэмэгдэх хэрэгтэй гэсэн чиглэлд нийгмийн сэтгэл зүй өөрчлөгдөн Монгол Улс ч дэлхий нийтийн жишгээр дараах бодлогын бармит бичгүүдэд Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаар тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1. Монгол Улсын хөгжлийн бодлого, хөтөлбөр

"Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-д "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ" гээд:

I үе шат (2016-2020) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгох.

II үе шат (2021-2025) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жишиг төслүүдийг хэрэгжүүлж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулах.

III үе шат (2026-2030) Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг зөөлрүүлж, гамшгийн эрсдэл, түүнээс үүдэлтэй хохирлыг бууруулах.

"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д "Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлыг хомсдлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах,

[59] Гамшгийн нэр томъёоны тайлбар толь. УБ. 2012.

хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн", "Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцлийг бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ" гэж тус тус тодорхойлсон.

"Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж буй барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ", "Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургана", "Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ" гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн байна.

2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, эрх зүйн орчин

Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр дараах таван үндсэн чиглэлээс бүрдсэн. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангана.
2. Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулна.
3. Гамшгийн нэр томьёоны ойлголт, төрийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах чиг үүрэг, тогтолцоо, гамшгийн эрсдэл хуваалцах даатгал, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
4. Аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсруулж, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулна.
5. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлнэ.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр нь хоёр үе шаттай бөгөөд эхний үе шат /2011-2015/-нд гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог төлөвшүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн болон мэргэжлийн

байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах, дараагийн үе шат /2015-2021/-нд байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог бий болгох, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхыг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнд хүрэхээр төлөвлөгдсөн байна.

Засгийн газраас 2015 онд баталсан Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрт "Гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог хангах", "Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах" гэсэн хоёр гол зорилтыг дэвшүүлсэн байна.

3. Дэлхий нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны бодлого хөтөлбөр

НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах газраас Япон Улсын Сендай хотод 2015 оны 3 дугаар сард зохион байгуулсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах" Дэлхийн гуравдугаар бага хурлаар дэлхийн 187 орон, 200 гаруй олон улсын болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид нэгдэн хуралдаж "2005-2015 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах Хёогогийн үйл ажиллагааны хүрээ" баримт бичгийг хэрэгжүүлэх чиглэлээр улс орнуудын төр, засаг, олон улсын байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тайлан, үр дүнг хэлэлцэн, дараагийн шатны "2015-2030 он хүртэлх "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сэндайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичгийг хэлэлцэн баталсан.

Энэхүү үйл ажиллагааны хүрээ нь ирэх 15 жилийн хугацаанд дараах үр дүнд хүрэхийг зорьж байна.

Хүлээгдэж буй үр дүн:

Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах.

Дээрх хүлээгдэж буй үр дүнд хүрэхийн тулд дараах зорилгыг дэвшүүлсэн.

Зорилго: Аюулд өртөх байдал, гамшигт эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдлыг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх эдийн засгийн, бүтцийн, хууль эрх зүйн, нийгмийн, эрүүл мэндийн, соёлын, боловсролын, байгаль орчны, технологийн, улс төрийн болон институцийн нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх.

Энэ баримт бичгийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулахад дараах дөрвөн тэргүүлэх чиглэлд хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1.Гамшгийн эрсдэлийг ойлгох:

Гамшгийн эрсдэлийн менежментийн бодлого, үйл ажиллагаа нь гамшгийн эрсдэлийг түүний бүх хэмжээс буюу эмзэг байдал, чадавх, хүн ам, эд хөрөнгийн өртөх байдал, аюулын шинж чанар болон хүрээлэн буй орчны

хүрээнд ойлгосон ойлголтод үндэслэх ёстой. Иймэрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг үр дүнтэй арилгах зорилгод ашиглах боломжтой гэж үзэж байна.

2.Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх:

Гамшгийн эрсдэлийн үндэсний, бүсийн болон олон улсын түвшний засаглал нь гамшгийн эрсдэлийг үр дүнтэй удирдахад чухал ач холбогдолтой. Алсын хараа, төлөвлөгөө, чадавх, заавар чиглэл, салбарын болон салбар хоорондын зохицуулалт, холбогдох талуудын оролцоо тодорхой байх шаардлагатай.

Иймээс гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээхийн тулд гамшгийн эрсдэлийн засаглалыг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлдэг гэж үзэж байна.

3.Гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах:

Бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад төр, хувийн хэвшлээс оруулж буй хөрөнгө оруулалт нь ард иргэд, олон нийт, улс орон, эд хөрөнгө, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, соёлын чадавх, хүрээлэн буй орчныг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй. Эдгээр нь шинийг санаачлах, өсөлт хөгжил, ажлын байр бий болоход нөлөөлөх бөгөөд ард иргэдийн амь насыг хамгаалах, хохирлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, сэргээн босгох, нөхөн сэргээх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, зардалд хэмнэлттэй чухал ач холбогдолтой арга хэмжээ болно гэж үзэж байна.

4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

Ард иргэд, эд хөрөнгийн гамшигт өртөх байдал, гамшгийн үед авсан сургамж зэрэг нь гамшгийн эрсдэл тогтвортой өсөж байгааг болон цаашид гамшгийн хор уршгийг арилгах бэлэн байдлыг сайжруулах, шаардлагатай арга хэмжээ авах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хор уршгийг арилгах, бэлэн байдлыг хангах арга хэмжээтэй уялдуулах шаардлагатай байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхыг бий болгоно. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг итгэмжлэн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангуулах, үйл ажиллагааг удирдуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээх хандлагыг хүртэх боломжтой зохион байгуулах. Гамшиг тохиолдохоос өмнө сэргээн босгох, нөхөн сэргээх шатны бэлтгэлийг хангасан байх шаардлагатай бөгөөд энэ нь гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хөгжлийн үйл ажиллагаатай уялдуулах, улс орон, ард иргэдийг гамшигтай тэмцэх чадавхтай болгох чухал боломж олгодог гэж үзэж байна.

Хүснэгт:1 Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төрийн бодлого, хөтөлбөрийн харьцуулалт

БАРИМТ БИЧИГ	Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр \Монгол Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт\	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал \Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт\	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 \Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт\	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ \2015 оны 3 дугаар сарын 18\
Зорилго	хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхи, бэлэн байдлыг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.	Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангахад оршино.	Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болгоход оршино.	Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулахад оршино.
Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх зохицуулалт	Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.	Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс юм.	“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ”	Улс орнууд гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхиа бэхжүүлэх асуудлыг тогтвортой хөгжил, ядуурлыг арилгах зорилтын хамт яаралтай шийдвэрлэх, боломжийн хэрээр бүх шатны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөвт тусгах, холбогдох баримт бичгүүдийн хүрээнд авч үзэхийг илэрхийлнэ.

Давуу тал	Улсын хэмжээний Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрт тусгасан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээ, шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, биелэлтийг тайлагнаж байхаар баталсан нь цаашид энэхүү төрийн бодлогын баримт бичиг тогтвортой хэрэгжих баталгаа хангагдаж байна.	Энэхүү баримт бичигт Байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах гэсэн бодлогын хүрээнд тусгагдсан нь Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхийг бэхжүүлж байна.	Энэ үзэл баримтлалд Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгохоор тусгасан нь Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх алхам бүрдэж байна.	Сендайн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхдээ үндэсний онцлогийг харгалзсан, дотоодын хууль тогтоомж, олон улсын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, амлалтуудад нийцүүлсэн гамшгийн эрсдэлийг бууруулах талаарх томоохон баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төрийн бодлого боловсруулах баталгаа хангагдаж байна.
Сул тал	- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байрууллагуудын уялдаа холбоо хамтран ажиллах боломжийг хэрхэн бүрдүүлж, үүрэгжүүлэх, - биелэлт хангагдаагүй тохиолдолд хариуцлагын тогтолцоог хэрхэн тооцох тухай тусгаагүй	-Гамшгаас хамгаалах, менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааг Байгалийн аюулт үзэгдэлд багтаан гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж ажиллах тухай тусгасан. - Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн биелэлтэд байнгын хяналт тавьж, үндэсний аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгнө.	-Энэхүү үзэл баримтлалд “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ” гэж тусгасан - Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцыг үзүүлэлтээр тодорхойлж үзнэ гэсэн нь хэрхэн тооцох талаар тусгагдаагүй байна.	

Хэрэгжилтийг тооцох	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, салбар дундын зохицуулалт хийх, хяналт тавих үүргийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдан чиглүүлнэ.	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт, үндэсний аюулгүй байдлын тухайн жилийн нөхцөл байдлын талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн жил бүр Монгол Улсын Их Хуралд хаалттай мэдээлэл хийнэ.	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцыг 20 үндсэн үзүүлэлтээр тодорхойлж үнэлнэ	Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос хойш баримтлах үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үнэлэх арга хэлбэрүүдийг тодорхойлох.

Сул талын тайлбар:

- Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого нь гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн уялдаа холбоо, оролцоо, хамтран ажиллах чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлэх талаар зохицуулалт тодорхойгүй байна
- Гамшгаас хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн хоорондын үйл ажиллагааны хэрэгжилтийг хэрхэн хангах, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлагын арга хэмжээг тусгаагүй байна
- Гамшгаас хамгаалах, менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааг Байгалийн аюулт үзэгдэлд багтаан гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж ажиллах тухай тусгасан нь гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхи бэхжүүлэх асуудалд нэгдсэн нэр ойлголтонд оруулах шаардлагатайг харуулж байна.
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ” гэж тусгасан нь гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг уур амьгалын өөрчлөлттэй холбон тайлбарласан нь учир дутагдалтай юм.
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн биелэлтэд байнгын хяналт тавьж, үндэсний аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгнө гэсэн заалт нь биелэлт хангагдахгүй байгаа нь үйл ажиллагааны уялдаа холбоо муу, хариуцлагын тогтолцоо байхгүйтэй болбоотой гэж тус тус үзлээ.

Иймд дээрх сул талыг арилгах хүрээнд дараах үйл ажиллагааг тусгах саналтай байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах талаар, төрийн болон төрийн бусад байгууллага, иргэдийн хамтын оролцоо, үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, сургалт явуулж байх
2. Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны биелэлтийг хангах, хариуцлага, шаардлагыг өндөржүүлж, эрх зүйн баталгааг хангах
3. Гамшгаас хамгаалах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн бодлого боловсруулахад тэдний оролцоог нэмэгдүүлэх
4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааны тодорхой арга, хэлбэрийг бэхжүүлж, үр дүнг дээшлүүлнэ.

Дүгнэлт

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь маш нарийн зохицуулалт бүхий бодлогын асуудал бөгөөд түүнийг дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотой хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч бүх талын оролцоо, түншлэлийн замаар хэрэгжүүлэхийг чухалчилж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг бодлого боловсруулах үйл явцад уялдуулан тусгаснаар эрсдэлд тэсвэртэй бодлогын хувилбаруудыг системтэйгээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсын хууль тогтоомж, Төрийн албаны шинэтгэлийн бодлогын баримт бичгүүд, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичиг, Монгол Улсын хөгжлийн бодлого, хөтөлбөр, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхи бэхжүүлэх асуудалд чиглэсэн нэгдмэл нэг ойлголттой болж, шинэчлэгдэн боловсронгуй болж, тасралтгүй, хурдтай өөрчлөгдөж байх шаардлагатай юм. Мөн түүнчлэн гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгох нөхцөл бүрдэнэ.

Иймд дээрх судалгааны ажлын хүрээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг түүнийг боловсронгуй болгох хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхи бэхжүүлэх асуудлыг бодлогын баримт бичгүүдэд нэгдсэн нэр ойлголтонд оруулах
- Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030", Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх
- Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах
- Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030", Сендайн үйл ажиллагааны хүрээ бодлогын баримт бичигтэй уялдуулж шинэчлэх, шаардагдах хөрөнгө оруулалтыг үндэслэлтэй тооцож, зарцуулсан хөрөнгийн өртгийг тооцох
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа нь бодлогын баримт бичиг, урт, дунд, богино хугацааны төсөл, хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон задарч хэрэгжих
- Салбар, яамдын бодлого, төлөвлөгөөтэй гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг уялдуулах, үе шаттайгаар хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах
- Гамшгаас хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн хоорондын үйл ажиллагааны хэрэгжилтийг хэрхэн хангах, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлагын арга хэмжээний зохицуулалтыг тусгах зэрэг болно.

Ашигласан материал

1. Гамшгаас хамгаалах тухай хууль УБ, 2003 он,
2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль УБ, 2015 он,
3. "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" УИХ-ын 2010 оны 48 тогтоол,
4. "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол,
5. "Гамшгаас хамгаалах төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр" УИХ-ын 2011 оны 22 дугаар тогтоол,
6. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
7. "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө" ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоол,
8. "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам" ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоол,
9. "Онцгой байдлын ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө" МУ-ын Шадар

сайдын 2015 оны 112 дугаар тушаал,

10. "Гамшгийн менежмент" НҮБ-ын Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь төслийн эмхэтгэл УБ, 2004 он,
11. Сэржмядаг Д. "Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо: хөгжил хандлага" УБ, 2013 он,
12. "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичиг,
13. UNISDR 2015, Development of the Post -2015 Framework for Disaster Risk Reduction, http://www.wcdrr.org/preparatory/post2015
14. UNISDR 2005, 2005-2015 онд авч хэрэгжүүлэх Хёогогийн үйл ажиллагааны хүрээ: "Улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхийг бий болгох нь, [], from http://www.unisdr.org/we/coordinate/hfa http://ontsgoisur.gov.mn/

СОНСОГЧИЙН БУЛАН

ХУР БОРООНЫ УСЫГ АМЬДРАЛД АШИГЛАХ АРГА

сонсогч Г.Уртнасан
Онцгой байдлын сургуулийн
641 дүгээр дамжаа

Монгол орны усны нөөц

Монгол орны усны нийт нөөц нь дэлхийн усны нөөцийн 0.00004 хувийг, гол мөрний усны нөөц нь дэлхийн гол мөрний усны нийт нөөцийн 1.63 хувийг тус тус эзэлдэг байна. Монгол орны ашиглаж болох боломжит усны нийт нөөц 34.6 км куб, vvний 70 гаруй хувийг гадаргын, 30 хvрэхгvй хувийг газрын доорхи ус тус тус эзэлдэг. Гэвч манай орны нийт нутаг дэвсгэрийн 69.1 хувийг эзэлдэг говь, хээрийн бvсэд гадаргын усны сvлжээ бараг байхгvйгээс газрын доорхи усны багахан нөөцөөс нийт ус хэрэглээний 80 хувийг хангадаг.

Монгол орон усны нөөцөөр багавтар орны тоонд ордог бөгөөд усны нөөцийн тархац нь жигд биш учраас нэг хvнд ногдох усны нөөц Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймагт 45-55,2 шоо.м байгаа нь дэлхийн дунджаас 4-5 дахин их байхад говийн бvсэд нэг хvнд ноогдох усны нөөц дэлхийн дунджаас 10 дахин бага байдаг. Одоогийн байдлаар 200 гаруй суурин газрын усны нөөц баталгаажаагvй, төв суурин газар оршин суугчдын 38% нь эрvvл ахуйн шаардлага бvрэн хангаагvй усыг амьдрал ахуйдаа хэрэглэж байгаагаас шvд цоорох, бамбай булчирхайн vрэвсэл, гэдэсний халдварт өвчин ихсэх хандлагатай эрдэсжилтийг бууруулах шаардлагатай 47 сум, усыг нь зөөлрvvлэх шаардлагатай 27 сум, ундны усны магнийг нь бууруулах шаардлагатай 99 сум байна.

Хvн амын унд ахуйн хэрэгцээнд жилд 90.5, Үйлдвэрт 222,3 сая м куб ус хэрэглэж, 60 гаруй хувь буюу 200 орчим сая м куб бохир ус гаргаж байна. Үvний 40 орчим хувийг механик болон биологийн аргаар цэвэрлэж, vлдэх хувийг шууд байгальд хаяж байна. Гэтэл жилд 131 сая буюу бvх бохир усны 60 гаруй хувийг цэвэрлэх хvчин чадал бvхий 107 байгууламж байгаа боловч 25 нь огт ажилгvй, 32 нь хvчин чадлынхаа дөнгөж хагасыг ашиглаж байна. Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, цэвэрлэгээний тvвшин туйлын хангалтгvй, байгаль орчныг бохирдуулах vндсэн нөхцөл болж байна. Тухайлбал: Богд, Дэлгэрмөрөн, Туул, Хангал, Хараа, Хэрлэн гол Улаанбаатар хот, аймгийн төвийн орчимд 5-80 км газарт бохирдсон байна. Тvvнчлэн зарим хот, аймгийн төвийн 400 гаруй бохирын цооног дvvрч халих, ил задгай газар, гуу жалганд хуурай хог хаягдал асгах хөдөө аж ахуйн vйлдвэрлэлд химийн бордоо, гербицид их хэмжээгээр хэрэглэх зэрэг нь усны эх vvсвэр, байгаль орчныг бохирдуулахад нөлөөлж байна.

Монгол орны байгалийн усны нөөц

Гол мөрөн	34,6 км^3
Нуур	500 км^3
Мөстөл, мөсөн гол	62,9 км^3
Газар доорх ус	12,0 км^3
Нийт	609,5 км^3

Дэлхийн үндсэн байгалийн бүсүүдэд ордог хур тунадасны байдлаас харахад манай орон нь хуурай байгалийн бүсэд хамаарна. Энэ бүсэд усны нөхөн сэлбэгдэх нөөцийг бүрдүүлдэг хур тунадасны хэмжээ нь харьцангуй бага, орон зайн хувьд жигд бус тархалттай байдаг.

Дэлхийн голлох байгалийн бүсүүдэд ордог хур тунадасны хэмжээ

Байгалийн бүс	Жилийн хур тунадасны дундаж хэмжээ, мм	Хур тунадастай байх сарын тоо
Говийн	100 хүртэл	0-1
Хуурай	100-400	1-3
Хагас хуурай	400-600	3-4
Хагас чийглэг	600-1200	4-6
Чийглэг	1200-1500	6-9
Их чийглэг	1500-аас дээш	9-12

Улаанбаатар хотын усны нөөц болон ашиглалт

Улаанбаатар хотын 1 сая гаруй хүн ам, 20 мянган үйлдвэр, аж ахуйн газрууд, 400 га усалгаатай газар тариалан,330 мянган тоо толгой мал сүрэг,3 цахилгаан станцын ус хангамж Туулын эхээс бүрэн хамаардаг. Улаанбаатар хотын усны жилийн нийт хэрэглээ нь 77 сая куб метр ба үүний ихэнх хэсгийг хотын ус сувгийн ашиглалтын газраас хангадаг. Ус ашиглалт, хэрэглээний үнэ нь жилд 90 гаруй тэрбум төгрөгт хүрэх ба үүний гуравны хоёрыг унд, ахуйн ус хэрэглэгчид бүрдүүлдэг. Улаанбаатар хотын газар доорхи усны түвшин сүүлийн 50 жилийн туршид буурах хандлагатай байгаа төдийгүй түүний хэрэглээ тэжээгдэлтэй нь харьцуулахад хурдтай өсч байна. Улаанбаатар хот хүрээгээ тэлэхийн хирээр усны хэрэгцээ,шаардлага өсөн нэмэгдэж байгаа бөгөөд уг асуудал улам бүр хурцдаж байна. Засгийн Газраас гаргасан судалгаагаар өдөрт хэрэглэх усны хэмжээ нь өнөөгийн байдлаар 212 мянган куб.метр байгаа бол энэ хэмжээ цаашид 2010 онд 286 мянган куб. метр , 2020 онд 438 мянган куб. метр , 2050 онд 708 мянган. куб метр болж өсөх хандлагатай байна. Одоо байгаа ашиглалтын худгууд нь бүх хүчин чадлаараа ажиллахад өдөрт 300,000 куб. метр усаар хангахаар төлөвлөгдсөн. Усны хэрэглээ нь дээрхи хүчин чадлаас давж, улирлын чанартай усны хомсдол аль хэдийн үүсч эхэлсэн бөгөөд зарим нэг судалгааны үр дүнг ээр 10 жилийн дараа Улаанбаатар хот усны хомсдолд орж болзошгүйг харуулж байна.

Усны хэрэглээ

Хүн амын болон мал аж ахуйн ус хэрэглээг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Хотын хүн амын ус хэрэглээ:

- Орон сууцанд оршин суудаг иргэдийн ус хэрэглээ /200 литр/,
- Гэр хороолол дахь зөөврийн ус хэрэглэдэг /6-8 литр/,
- Төвлөрсөн шугамнаас ус хэрэглэдэг иргдийн /7-9 литр/,
- Зуслан, хувийн орон сууцтай иргэдийн ус хэрэглээ /5-6 литр/,
- Мал бүхий болон бага хэмжээний газар таралан эрхлэгч иргэдийн /судалгаа байхгүй /

Хөдөөгийн хүн ам, мал аж ахуйн ус хэрэглээ:


Орон сууцанд оршин суудаг нэг иргэн 1998 онд 450 литр ус хэрэглэж байсан бол 2011 онд 200 гаруй литр буюу ус хэрэглээ 2 дахин буурсныг судалгаагаар тогтоосон байна.

Энэхүү бодит үр дүн эх үүсвэрээс хэрэглэх усны хэмжээг 2 дахин бууруулсан, энэ хэмжээгээр бусад өсөн нэмэгдэх хэрэглээг усаар хангах боломжийг бүрдүүлсэн. Хүн амын тоо нь өөрөө ус хэрэглээг тодорхойлдог үндсэн үзүүлэлт. Нийслэл хотын хүн ам хэдий олон байна, ус хэрэглээ төдий чинээ их болно.

Хотын хүн амын тоо өдгөө 1.3 сая болсон, бараг 60 хувийн ус хэрэглээ ихээхэн доогуур түвшинд байгаа. Иймээс иргэдийн одоогийн ус хэрэглээг нэмэгдүүлэх арга бол орон сууцжуулах явдал юм. Энэ нь нэг иргэний хоногийн дундаж ус хэрэглээ 7-9 литр байгааг доод тал нь 150 литр болгох шаардлага гарч ирнэ. Одоогийн ус хэрэглээг 16-20 дахин нэмэгдүүлэх хэрэгтэй болно.

Иймд усны хэрэглээ, шаардлагыг зөв зохицуулах, усыг үр ашигтай хэрэглэх, системийн алдагдлыг багасгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тиймээс дараах саналыг дэвшүүлж байна.

Миний дэвшүүлж буй санаа нь Борооны усыг цуглуулан ахуй хэрэглээндээ хэрэглэх явдал юм. Доорх зурган дээрх төхөөрөмж маань дээвэр дээр орж буй болон цугласан борооны усыг хоолойгоор дамжуулан газар доорх цистернд цуглуулах юм. Мэдээж борооны усыг шууд хэрэглээндээ ашиглах нь бохир учир филтер буюу ус цэвэршүүлэгч суурьлуулж өгнө. Ус цэвэршүүлэгчийн хувьд 2,3 янз байх боловч миний хувьд элсний филтер нь хамгийн тохиромжтой гэж үзэж байгаа. Яагаад гэвэл хөрөнгө бага шаардагдах ба илүү био технологийг хангаж өгсөн.



Зурагны тайлбар: Дээрх зурган дээр дээврээс борооны усыг цуглуулах хоолой мөн жижиг хэмжээны ус цуглуулах сав мөн элсэн филтер байна. Элсэн филтерт савны 2/3 нь элс, 1/3 нь том хайрган чулуунууд байна. Элсэн филтерээс шүүсныхээ дараа савандаа цуглуулж цаашаа хэрэгцээндээ ашиглана.

Энэхүү технологийг ашиглахын тулд бидэнд хэдий хэмжээний борооны ус хэрэгтэй, хэр их хугацаанд ашиглаж болох мөн хэдэн хүн хэрэглэх боломжтой талаар 2 болон 5 давхар байшингуудад жишээ авч үзсэн билээ.

30м^2 тэгш гадаргуунд 25мм хур тунадас ороход 2,375 л ус хуримтлагдана.

Жишээ №1

5 Давхар байшин давхар тус бүрдээ 6 айл нийт 30 айлын орон сууц.

297м^2 дээвэр дээр 25мм хур тунадас буухад:

297м^2 * 2,4 л = 712,8 л ус цуглана.

Бүтэн өдрийн турш 86 мм хур тунадас ороход:

712,8 л * 86 мм = 61,300,8 л ус цуглана.

1 гэр бүлд 760 л ус ашигалдаг гэхэд 30 айл 22800 л ус ашиглана. Тэгвэл сард 68400/0 л ус шаардлагатай. Тэгвэл сард 5550 мм хур тунадас буюу 12193350 л ус хэрэгтэй гэсэн үг.

Жишээ №2

2 Давхар байшин.

39м^2 дээвэр дээр 25мм хур тунадас буухад:

39м^2 * 2,4 л = 93,6л ус цуглана.

Тэгвэл бүтэн өдрийн турш 86 мм хур тунадас ороход:

93,6л * 86 мм = 8,049.6 л ус цуглана.

1 гэр бүлд 760 л ус ашигалдаг гэж үзвэл сард 22800 л ус шаардлагатай. Тэгвэл сард 185 мм хур тунадас буюу 17,316 л ус хэрэгтэй гэсэн үг. Тиймээс 20 тн сав шаардлагатай.

4 ам бүлтэй гэр бүл өдөрт 760 л ус хэргэлдэг.

Усны хэрэгцээ

Хэрэглээ	1 өдөр /л/
Хоол хийх болон аяга тавга угаах	76 л
Хувцас, Цагаан хэрэглэл гэх мэт угаалга	133 л
Усанд орох	247 л
Бусад	304 л

1 хүнд ноогдох усны хэрэглээ өдөрт 190-285 л. Хэрвээ 35-40 хоног бороо орохгүй байлаа гэхэд 20 тн цистернийг 4 ам бүлтэй гэр бүл хангалттай хэрэглэж хүрнэ гэсэн үг.


Усны савны үнийн судалгаа

Ил байрлах сав



Энэхүү сав нь:

- 380 л усны багтаамжтай
- 380.000 төг



Энэхүү сав нь:


- 18,000 л усны багтаамжтай
- 6.000.000 төг



Энэхүү сав нь:

- 4,500 л усны багтаамжтай
- 2.000.000 төг

Газар доор байрлах сав



Дээрх савнууд нь:


- 1,300 л – 14,000 л хүртэл усны багтаамжтай
- 900.000 – 8.000.000 төг




Дээрх усны савнууд нь:

- 1,300 л - 10,000 л хүртэл усны багтаамжтай
- 1.000.000 – 6.000.000 төг

Дээрх савнууд магадгүй үнэтэй санагдаж болох юм тэгвэл гар доорх материалаа ашиглах ба орлуулж ашиглаж болох савны санаанууд:



Дүгнэлт

Гадаргын усны нөөцийн 85 хувийг цэнгэг ус, түүний 93.6 хувийг Хөвсгөл нуурын ус эзэлнэ. Газрын доорхи усны нөөц баялаг асар их хэмжээтэй боловч удаан хугацаанд нөхөн сэлбэгддэг учраас ашиглаж болох нөөцийн хэмжээ тун бага байдаг бол гадаргын ус буюу голын ус богино хугацаанд / 20 хоногт / буюу жилдээ 18 удаа солигддог ажээ.

Манай улс ус хэрэглээнийхээ 90 орчим хувийг газрын доорхи усаар хангадаг байна. Газрын доорхи ус нь экологийн нэн эмзэг тогтоцтой, усны горим тэжээлийн систем нь өвөрмөц, нөхөн сэргэх хугацаа нь хэдэн арав, хэдэн зуун жилээр тооцогддог учраас газрын доорхи усыг онцгой хамгаалалтанд авч нөхөн сэлбэгдэх хэмжээнээс үл хэтрүүлэн ашиглах шаардлагатай байдаг.Монгол Улсын хэмжээнд 2003 оны тоо бүртгэлээр газрын доорхи усыг ашиглаж буй уст цэг 40870 ш байгаагаас инженерийн хийцтэй уст цэг 19460 ш, энгийн уурхайн худаг 21410 ш байна. Инженерийн хийцтэй 19460 ш уст цэг ашиглагдаж байгаагаас 5656 ш өрөмдмөл худаг, 6064 ш богино яндант уурхайн худаг, 7740 ш бетонон хашлагатай уурхайн худаг байдаг.

Нийт ашиглагдаж байгаа уст цэгийн 8575 ш нь хүн амын унд-ахуйн усан хангамж болон үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн технологийн зориулалтаар ашиглагдаж байгаа бөгөөд 32263 нь бэлчээр усжуулалтын чиглэлээр ашиглагдаж байна.Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт нийт газрын доорхи усыг ашиглаж байгаа 426 уст цэгээс 373 нь хүн амын унд-ахуйн усан хангамж болон үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн технологийн зориулалтаар ашиглагдаж байгаа бөгөөд 53 нь бэлчээр усжуулалтын болон газар тариалангийн усалгааны чиглэлээр ашиглагдаж байгаа судалгаа бий. Улаанбаатар хотын унд-ахуйн хэрэгцээний усыг төв болон дээд эх үүсвэрээс хангадаг Төв эх үүсвэрт нийт 92 ш ашиглалтын худаг байдгаас одоо ажиллаж байгаа нь 87 ш байдаг бөгөөд ашиглалтын нөөц баялаг нь 90.4 мян м3/хоног, дээд эх үүсвэрт 37 ш ашиглалтын худаг ажиллаж байдаг бөгөөд ашиглалтын нөөц баялаг нь 59.7 мян м3/хоног байдаг, нийслэлийн хүн амын төвлөрсөн усан хангамжийн Дээд ба Төв эх үүсвэрийн нийт хүчин

чадал 151 00 м3/хоног нөөцтэй байна. Энэхүү системийг хэрэглэснээрээ бид цэвэр усны нөөцын хэрэглээг багасгаж мөн гэр хороололд амьдардаг айл өрхүүд худагаас усаа авахад хүндрэлтэй байдаг бөгөөд энэхүү хүндрэлийг багасгаж өгч байгаа билээ. Мөн хөдөө орон нутагт газар тариаланд энэхүү системийг ашиглах боломжтой.

Ашигласан материал

- WWW.ICC.MN
- WWW.MNE.MN
- Д.Батмөнх Монгол орны усны нөөц, ашиглалт, ус хэрэглээ
- http://www.denverpost.com/
- Rainwater harvesting for gardening use /Sam Angima & Bill Biernacki/

МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВЛӨГӨӨ


ХУВЦАСНЫ ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ АРГА

ахмад, А.АРИУНБИЛЭГ
Гамшиг судлалын хүрээлэнгийн Хувцасны технологи, стандарт, норм дүрэм хариуцсан ажилтан

Цэргийн албан хаагч хувцасны хэмжээгээ мэдэх үүрэгтэй гэж дүрэм, журманд заасан байдаг.

Энэ удаа та бүхэндээ биеэс хэмжээ авч өөрийн хувцасны хэмжээгээ хэрхэн тодорхойлох талаар мэргэжлийн зөвлөгөө өгөхөөр бэлтгэлээ.


Хувцас зохион бүтээлтэд хүний биеийн маш олон хэмжээсүүдийг ашигладаг.



Хүний биеийн стандарт хэмжээсийг антропометрын судалгаан дээр үндэслэн гаргадаг бөгөөд улс орнуудын хэмжээс харилцан адилгүй. Жишээлбэл монгол хүнд өндөр, мөч урттай европ хүний хэмжээгээр хийсэн хувцас тийм ч тохиромжтой биш байдаг. Манай улсад MNS 4252:1995 стандартаар батлагдсан монгол хүний хэв шинжит галбирын хэмжээг ашиглаж байна.

Та бүхэнд эдгээр олон хэмжээгээр биш үндсэн хэдэн хэмжээгээр хувцасны хэмжээгээ тодорхойлох бяцхан нууцыг задруулая. Энэ нь бидний стандартын бус гэж ярьдаг хүнд үйлчлэхгүй гэдгийг анхааралаарай.

Эхний алхам бол өөрийн биеэс хулдаасан метрээр хэмжээ авах юм. Хүнээр туслуулсан ч болно шүү. Хэмжихдээ нимгэн хувцастай цэх зогсож, хулдаасан метрийг хэт сул хэт чанга биш барьж хэмжинэ. Хэмжээс тус бүрийн талаар тайлбарлая.




Хэмжээс-1 биеийн өндөр. Биеийн өндөр буюу чац /рост/ гэдэг нь гуталгүй үед хүний хөлний улнаас толгойн орой хүртлэх зайг хэмжинэ. Биеийн өндөр нь хувцасны уртын хэмжээсүүдэд нөлөөлөх ба дугаарлаж тэмдэглэдэг. Хэрэв та эрэгтэй 158 өндөртэй бол 1, 164-2, 170-3, 176-4, 182-5 чацтай гэсэн үг юм. Эрэгтэй эмэгтэй чацийн хэмжээ ялгаатай.

Чац /рост/		1	2	3	4	5	6
Биеийн өндөр /см-аар/	Эрэгтэй	158	164	170	176	182	188
	эмэгтэй	152	158	164	170	176	182

Чацийн хэмжээ 6 см-аар өөрчлөгдөж байгааг анзаарч байгаа байх. Хэрэв та 172 өндөртэй бол ойролцоогоор 3 гэсэн үг.


Хэмжээс-2 цээжний бүслүүр. Цээжний бүслүүр хэмжээг хөхний толгой, далны ясны дайруулан суган доогуур тойруулан хэмжинэ. Ер нь бүслүүр хэмжээсүүдээр хувцасны хэмжээ /размер/-г ерөнхийд нь тодорхойлж болно. Таны цээжний бүслүүр 102 см бол 2-т хуваагаад 51 буюу ойролцоогоор 50 хэмжээтэй хувцас өмсөнө гэж ойлгож болно. Хувцасны хэмжээ нь 44, 46, 48, 50, 52 гэх мэтчилэн 2-оор нэмэгддэг. Бидний дүрэмт хувцас ихэвчлэн 50/2, 48/3 гэх мэтчилэн хэмжээтэй байдаг ба эхний тоо таны хувцасны хэмжээг, дараагийн тоог чацийг илэрхийлнэ.



Хэмжээс-4 хүзүүний бүслүүр. Энэ хэмжээгээр цамцны хэмжээг тодорхойлж болно. Хүзүүг хэт их доогуур болон дээгүүр биш дунд хэсгээр бүслүүрдэн хэмжвэл таны хэмжээ зөв гарна. Цамцны 39,40,41 гэх мэт хэмжээ нь таны хүзүүний бүслүүр хэмжээ юм. Цамцны бусад өмсгөл хэмжээ болон ханцуйн уртыг ихэвчлэн хүний биеийн стандарт хэмжээгээр тооцож үйлдвэрлэдэг.

Хэмжээс-5 толгойн бүслүүр. Толгойн урд хэсгээр хөмсөгнөөс 1-1,5 см-ийн дээш зайд, ар хэсгээр дагзны төвгөр хэсгийг дайруулан хэмжинэ. Энэ хэмжээгээр малгайны хэмжээг шууд тодорхойлж болно.






Хэмжээс-8 гарын сарвууны бүслүүр. Бээлийний хэмжээг хүний гарын сарвууны бүслүүр хэмжээг хэмжиж тодорхойлдог. Эрхий хурууны үгт тулган гарын сарвууны бүслүүрийг хэмжинэ. Бээлийний 7,8,9 гэх мэт хэмжээсүүд нь гарын сарвууны бүслүүрийг хэмжээд инчид шилжүүлсэн хэмжээ юм. 1 инч 2,54см-тай тэнцдэгийг та бүхэн мэднэ. Жишээлбэл таны гарын сарвууны бүслүүр 19.5 см бол 8 хэмжээтэй бээлий таарна гэсэн үг юм.

Бээлийний өмсгөл хэмжээ	Албан хаагчийн сарвууны бүслүүр		Сарвууны бүслүүрийн хэлбэлзэл, см
	сантиметрээр	инчээр	
6	15,2	6	14,0-16,49
7	17,8	7	16,5-18,99
8	20,3	8	19,0-21,49
9	22,9	9	21,5-23,99
10	25,4	10	24,0-26,49
11	27,9	11	26,5-28,99

Гутлынхаа хэмжээг тодорхойлохын тулд хатуу гадаргуу дээр цаас дэлгэн хөлөө тавьж, тавхайгаа тойруулан харандаагаар зураад уртыг нь хэмжинэ.

Доорх хүснэгтээс гутлынхаа хэмжээгээ тодорхойлоорой. Жишээ нь та эрэгтэй хүн бөгөөд хөлийн тавхайн урт 26 см бол таны гутлын хэмжээ 42, америк улсад үйлдвэрлэсэн гутал 9, хятад улсынх бол 44 таарна. Хэрэв тавхайн уртын хэмжээ нь хүснэгтэнд байгаа хоёр тооны дунд таараад байгаа бол эсвэл зүүн, баруун хөлний хэмжээ адилгүй бол аль их тоог нь сонгоно.



Эрэгтэй гутлын хэмжээ

Тавхайн урт, см	23.5	24.1	24.4	24.8	25.2	25.7	26	26.5	26.8	27.3	27.8	28.3
Европ	39	39	40	40-41	41	41-42	42	42-43	43	43-44	44	44-45
Америк	6	6.5	7	7.5	8	8.5	9	9.5	10	10.5	11	11.5
Хятад	39.5	41	-	42	43	43.5	44	44.5	45	46	-	47
Англи	5.5	6	6.5	7	7.5	8	8.5	9	9.5	10	10.5	11

Эмэгтэй гутлын хэмжээ

Тавхайн урт, см	21.3	21.6	22.2	22.5	23	23.5	23.8	24.1	24.6	25.1	25.4	26
Европ	34	35	35-36	36	36-37	37	37-38	38	38-39	39	39-40	40
Америк	4	4.5	5	5.5	6	6.5	7	7.5	8	8.5	9	9.5
Хятад	35	35.5	36	36.5	37	37.5	38	39	39.5	40	41	41.5
Англи	1.5	1	2.5	3	3.5	4	4.5	5	5.5	6	6.5	7

Бүгд Найрамдах Солонгос Улсад үйлдвэрлэсэн гутлын хэмжээ 240, 245, 250 гэсэн байдаг нь хөлийн тавхайн уртын хэмжээг миллиметрээр илэрхийлж байгаа юм. Зарим гуталд хөлийн тавхайн өргөний хэмжээг тэмдэглэх нь бий. Эдгээр тэмдэглэгээ нь:

B - Нарийхан тавхай

D - Дунд зэргийн буюу стандарт тавхай

EE - Өргөн тавхайтай хүнд таарна гэсэн үг юм.

МЭДЭЭЛЭЛ

ОНЦГОЙ БАЙДЛЫН СУРГУУЛИЙН 2016 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1 СУРГАЛТЫН ТААТАЙ ОРЧИН БҮРДЭВ

Хууль сахиулахын их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн шинэ байр ашиглалтанд орсоноор **Онцгой байдлын сургууль нийт 24 өрөө, хичээлийн анги, танхим**д сургалтын үйл ажиллагаагаа явуулах боллоо.

ОБЕГ-аас **20 гаруй нэр төрлийн 1300 гаруй ширхэг ном**, **Сонсогчдын сургалт, дадлагад 572.571.670 төгрөгийн** үнэ бүхий техник, тоног төхөөрөмжийг хүлээн авсан



2 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭРИЙГ НЭМЭГДҮҮЛЭВ


Онцгой байдал-Гамшгаас хамгаалах алба мэргэжлээр **3 ба 5 жилийн эчнээ анги шинээр нээн** сургалтыг явуулж эхлээд байна.

"Эдийн засаг-Улсын нөөцийн ажил" мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулан БСШУЯ-аар баталгаажуулан анхны элсэлт авч, сургалтыг явуулж эхлэв.

3

ХАМТАРСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-ын Элчин сайдын яам, Аляскийн үндэсний гвард, Номхон далайн тусгай ажиллагааны командтай хамтран **"Гамшгийн үеийн хор уршгийг арилгах нь" сэдэвт сургалтыг** зохион байгуулав.





4

"ГАМШИГ, ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" СУРГАЛТЫН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭВ

БСШУЯ-наас "Боловсролыг дэмжих" хөтөлбөрийн хүрээнд их, дээд сургуулийн оюутнуудын дунд зарласан төслийн сонгон шалгаруулалтад Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 4-5 нас, Ерөнхий боловсролын сургуулийн 1-4 ангийн сурагчдад "Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх" сургалт зохион байгуулах төсөл шалгарч, амжилттай хэрэгжсэн.




5 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭВ

* **Польш Улсын Дотоод явдлын яамны Галын аюулгүй байдлын дээд сургуульд** “Галын аюулгүй байдлын инженер” мэргэжлээр 2;
* **ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны академид** Галын аюулгүй байдлын инженер мэргэжлээр 3;
* **Бүгд найрамдах Солонгос улсын Чаншин их сургуулийн Инженерийн сургуульд** “Галын аюулгүй байдлын инженер” мэргэжлээр 4 сонсогч тус тус суралцахаар явсан.
* **ОХУ-ын Дорнод сибирийн Удирдлага, Технологийн их сургуультай** богино хугацааны оюутан солилцох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.

ОНЦГОЙ БАЙДЛЫН СУРГУУЛИЙН 2016 ОНЫ ТООН МЭДЭЭ

Элсэгчдийн
- босго дундаж оноо **960**
- үндэсний тэтгэлэг **100%**



Багшлах бүрэлдэхүүний
- доктор **27%**
- докторант **46%**
- магистр **27%**

Төгсөгчдийн
- голч дүн **3.03**
- сурлагын чанар **93.7%**

Төгсөгчдийн
- ажил эрхлэлт **99%**
- үндсэн мэргэжлээрээ ажил эрхлэлт **98%**

НОМЫН ТАНИЛЦУУЛГА



ХСИС-ийн Онцгой байдлын сургуулиас “Хүн ам, газар нутгийн инженерийн хамгаалалт” ном хэвлэгдэн гарч олон нийтийн хүртээл боллоо.

Дэлхий нийтийг хамарсан уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтын нөлөөгөөр байгалийн гамшгийн цар хүрээ, давтамж ихсэж байгаа нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж, шуурхай зохион байгуулах шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна. Энэхүү номонд гамшгийн үед аврах ажиллагааг хурдан шуурхай зохион байгуулахад нэн чухал арга хэмжээ болох хүн ам, газар нутгийг хамгаалах асуудлыг авч үзсэн.

Тус номыг Онцгой байдлын албан хаагчид болон сонсогч, суралцагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаарх мэдлэгийн санд багахан ч гэсэн хувь нэмэр оруулах зорилгоор боловсруулсан. Мөн энэхүү номыг Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүн эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох болон өдөр тутмын сургалт, дадлагын ажилдаа ашиглах боломжтой юм.